



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION

МАЛЧДЫН АЖ БАЙДЛЫН СУДАЛГАА



УЛААНБААТАР ХОТ
2018 ОН

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

Малчдын аж байдлын судалгаа

Судалгааг гүйцэтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт,
Нийгмийн хамгааллын бодлогын судалгааны сектор

Судалгааг гүйцэтгэсэн багийн гишүүд:

М.Алтансүх	ХНХСИ-ийн захирал
О.Баасантогтох	ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбарын эрдэм шинжилгээний ажилтан, докторант
Ч.Цогтбаяр	НХБСС-ын эрхлэгч
Ч.Отгонцэцэг	НХБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
Э.Туяацэцэг	НХБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
Б.Төмөрчулуун	НХБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
М.Энхзориг	НХБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо
Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөрийн ордон,
5 давхар
Утас: 77121286
Вэб хуудас: www.rilsp.gov.mn

Агуулга

ӨМНӨХ ҮГ	iv
Хүснэгтийн жагсаалт	v
Зургийн жагсаалт	vi
Товчилсон үгс	x
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ	xi
1. УДИРТГАЛ	1
1.1. Үндэслэл	1
1.2. Судалгааны зорилго, зорилтууд	2
1.3. Судалгааны арга	2
1.4. Түүвэрлэлт	3
1.5. Мэдээлэл боловсруулалт	4
1.6. Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт	4
1.7. Судалгааны мэдээлэл цуглуулалт	5
1.8. Судалгааны агуулга, үзүүлэлт	5
2. МАЛЧИД, МАЛЧИН ӨРХ	8
2.1. Статистикийн судалгаан дахь малчдын дүр зураг	8
2.2. Судалгаанд оролцсон малчдын хүн ам зүйн шинж	11
2.3. Гэрлэлт, гэр бүлийн байдал	12
3. ӨРХИЙН ӨМЧ, ХЭРЭГЛЭЭ	15
3.1. Сууцны төрөл, хэрэглээ	15
3.2. Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө	17
3.3. Хүнсний хэрэглээ	19
4. ӨРХИЙН АМЬЖИРГАА: ОРЛОГО, ЗАРЛАГЫН БҮТЭЦ	21
4.1. Өрхийн орлого, зарлагын бүтэц	21
4.2. Өрхийн орлогод мал, малын гаралтай түүхий эдийн эзлэх хэмжээ	28
4.3. Зээлтэй малчин	34
4.4. Малчдын амьжиргаа	37
5. МАЛЧДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ: ОНЦЛОГ, БЭРХШЭЭЛ	39
5.1. Хөдөлмөрийн онцлог, хөдөлмөрийн хуваарь	39
5.2. Малчдын ахуйн хүрээн дэх хөдөлмөр	42
5.3. Мал маллаж буй арга, хэлбэр, түүнд гарч буй өөрчлөлт	45
5.4. Мал маллахад тулгарч буй бэрхшээл	47
6. МАЛЧДЫН НИЙГМИЙН ҮҮРЭГ, БАЙР СУУРЬ	50
6.1. Туслах малчин, тэдгээрийн нийгмийн асуудал	50
6.2. Фермер эрхлэгчид ба бэрхшээл	54

7. ТӨРИЙН БОДЛОГО НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ХАМРАГДАЛТ	56
7.1. Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж	56
7.2. Боловсролын үйлчилгээний хүртээмж, хамрагдалт	61
7.3. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын хамрагдалт, хандлага	65
7.4. Орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрт хамрагдаж буй байдал	72
7.5. Малчдын талаар төрөөс баримтлаж буй бодлого, хэрэгжилтийн байдал	76
ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ	82
Дүгнэлт	82
Санал, зөвлөмж	84

ӨМНӨХ ҮГ

Манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр суурь эзэлдэг салбарын нэг юм. Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийн бааз бүрдүүлэхэд томоохон ач холбогдолтой юм.

Монгол Улсын Үндсэн хуульд “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэж хуульчлан заасан байдаг бөгөөд 1991 онд Өмч хувьчлах тухай хууль батлагдсанаар малчид малаа хувьчилж авч, мал хувийн өмчид шилжсэн.


2017 оны эцсийн байдлаар 228.9 мянган малтай өрх байгаагийн 74.1 хувь нь буюу 169.7 мянган малчин өрх байгаа бөгөөд Мал аж ахуйн салбарт ажиллагсад нь хөдөлмөр эрхэлж буй нийт иргэдийн 30.0 хувийг эзэлж байна.¹

Мал аж ахуйн салбар нь хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний шингээлт өндөртэй голлох салбар боловч тэнд ажиллагсдын бараг таван хүн тутмын нэг нь л нийгмийн даатгалд хамрагдсан байгаа юм. Энэ нь малчдын нийгмийн баталгаа өнөө болон ирээдүйд томоохон эрсдэлд байгааг илтгэх бөгөөд зайлшгүй анхаарах шаардлагатайг илэрхийлж байна. Түүнчлэн мал аж ахуй эрхлэгч, малчид нь хувьсан өөрчлөгдөж буй нийгмийн хөгжилд дасан зохицох, тэдний гэр бүлийн байдал, нийгмийн хамгаалал, халамж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах нөхцөл, боломж зэрэг аж төрөх ёсны ерөнхий үзүүлэлтүүдийг нарийвчлан судалж, дүр төрхийг тодорхойлох, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуйн үр нөлөө, бололцоог судлах суурь судалгааны ажил үгүйлэгдэж байсан.

Энэхүү хэрэгцээ, шаардлагын үүднээс салбарын яамны захиалгаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь “Малчдын аж байдын судалгаа”-г хийж, гүйцэтгэлээ.

Та бүхэн судалгааны үр дүнтэй танилцан, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглахын зэрэгцээ судалгааны арга, аргачлалтай холбоотой санал хүсэлтээ бидэнд илгээж, хамтран ажиллахыг хүсье.

ЗАХИРАЛ



М.АЛТАНСҮХ

¹ УСХ, Мал тооллогын урьдчилсан дүн 2017 он

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 2.1. Малчдын тооны хэтийн тооцоолол, 2000-2035 он	11
Хүснэгт 3.1. Малчин өрхийн хөрөнгө, эд хөрөнгө, бүсээр	18
Хүснэгт 4.1. Малчин өрхийн сарын дундаж орлого, байршил, мянган төгрөг	22
Хүснэгт 4.2. Малчин өрхийн сарын дундаж орлогын бүлэг, хонин толгойд шилжүүлсэн малын тоогоор.....	24
Хүснэгт 4.3. Малчин өрхийн сарын дундаж зарлагын төрөл, байршлаар, мянган төгрөгөөр.	26
Хүснэгт 4.4. Малчин өрхийн сарын дундаж орлогын бүлэг, хонин толгойд шилжүүлсэн малын тоогоор.....	27
Хүснэгт 4.5. Малаасаа ашиг хүртдэг малчин өрхийн хувь, байршлаар.....	29
Хүснэгт 4.6. Малчин өрхийн малаас хүртэж буй дундаж орлого, байршлаар.....	29
Хүснэгт 4.7. Ноос, ноолуурын ашиг шим.....	30
Хүснэгт 4.8. Малчин өрхийн ноос, ноолуураас олж буй дундаж орлого, төрөл, байршлаар	30
Хүснэгт 4.9. Арьс, ширний ашиг шим	30
Хүснэгт 4.10. Малчин өрхийн арьс, ширнээс олж буй дундаж орлого, арьс, ширний төрөл, байршлаар.....	31
Хүснэгт 4.11. Малаас сүү, сүүн бүтээгдэхүүний ашиг шим хүртдэг малчин өрхийн хувь, төрөл, байршлаар	31
Хүснэгт 4.12. Малчин өрхийн сүү, сүүн бүтээгдэхүүнээс олж буй дундаж орлого, сүүний төрөл, байршлаар	32
Хүснэгт 4.13. Бусад бүтээгдэхүүн борлуулсан ашиг, байршлаар	32
Хүснэгт 4.14. Мал зарж ашиг шим хүртсэн малчин өрхийн хувь, төрөл, байршлаар	32
Хүснэгт 4.15. Малчин өрхийн мал зарж олсон дундаж орлого, малын төрөл, байршлаар .	33
Хүснэгт 4.16. Мал махалж зарж ашиг шим хүртсэн малчин өрхийн хувь, төрөл, байршлаар	33
Хүснэгт 4.16. Малчин өрхийн мал махалж зарж олсон дундаж орлого, малын төрөл, байршлаар.....	34
Хүснэгт 4.18. Зээлтэй малчин өрхүүд, зээлийн эх үүсвэр, зээлийн хэмжээ, хугацаа, байршлаар.....	35
Хүснэгт 7.1. Улсын хэмжээнд малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан, халдварт өвчин, өвчнөөр өвчилсөн, эдгэрсэн малын тоо, зардал .	61
Хүснэгт 7.2. Төсөл хөтөлбөрүүдэд хамрагдсан малчид, байршлаар	74
Хүснэгт 7.3. Төсөл хөтөлбөрүүдэд хамрагдсан малчид, төсөл хөтөлбөрүүдээ үнэлсэн байдал	75
Хүснэгт 7.4. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын эхний үе шат (2009-2015 он)-нд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө.....	76
Хүснэгт 7.4. Төр засгийн зүгээс малчдыг дэмжих бодлогын чиглэлүүд	79

Зургийн жагсаалт

Зураг 1.1. Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт.....	4
Зураг 2.1. Малчдын тоо, өсөлтийн хувиар, 1990-2017 он	8
Зураг 2.2. Малчдын тоо, аймгаар, 2017 он	8
Зураг 2.3. Малчдын хувь, насны бүлгээр, 1990-2017 он	9
Зураг 2.4. Малчдын хувь, насны бүлэг, хүйсээр, 2017 он	9
Зураг 2.5. Малчин өрхийн тоо, нийт өрхөд эзлэх хувиар, 1995-2017 он	10
Зураг 2.6. Малчин өрхийн тоо, аймгаар, 2017 он	10
Зураг 2.7. Судалгаанд хамрагдсан малчин өрх дэх нийт иргэдийн нас, хүйсийн бүтэц, хувиар	12
Зураг 2.8. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 15 ба түүнээс насны гишүүдийн гэрлэлтийн байдал.....	12
Зураг 2.9. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 15 ба түүнээс насны гишүүдийн гэрлэлтийн байдал, хүйсээр	12
Зураг 2.10. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүдийн гэрлэлтийн байдал, насны бүлгээр	13
Зураг 2.11. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн тэргүүлэгчийн насны бүлэг, хүйсээр, хувиар	13
Зураг 2.12. Малчин өрхийн гэр бүлийн гишүүдийн ерөнхий бүтэц, харьцаа.....	14
Зураг 2.13. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн тэргүүлэгчийн яс үндэс, хувиар.....	14
Зураг 3.1. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн сууцны төрөл, улирлаар	15
Зураг 3.2. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн цахилгааны эх үүсвэр.....	15
Зураг 3.3. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн цахилгааны эх үүсвэр, бүсээр	16
Зураг 3.4. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн халаалтын эх үүсвэр	16
Зураг 3.5. Судалгаанд хамрагдсан сууцаа галлаж халаадаг өрхүүдийн түлшний төрөл	16
Зураг 3.6. Сууцаа галлаж халаадаг өрхүүдийн түлшний төрөл, бүсээр	17
Зураг 3.7. Малчин өрхийн хөрөнгө	18
Зураг 3.8. Мах болон гурилан бүтээгдэхүүний хэрэглээний бүтэц, хувиар	19
Зураг 3.9. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн хүнсний ногоо болон бусад бүтээгдэхүүний хэрэглээний бүтэц, хувиар	19
Зураг 3.10. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн өдрийн дундаж хооллолт, хувиар, байршлаар.....	20
Зураг 3.11. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн өдрийн дундаж хооллолт, хувиар, бүсээр	20
Зураг 4.1. Малчин өрхийн сарын дундаж орлогын бүтэц, байршлаар	21
Зураг 4.2. Малчин өрхийн орлогын эх үүсвэр, орлогын төрлөөр.....	21
Зураг 4.3. Малчин өрхийн орлогын эх үүсвэр, орлогын төрөл, байршлаар	22
Зураг 4.4. Малчин өрхийн сарын дундаж орлогын бүлэглэлт.....	22
Зураг 4.5. Малчин өрхийн сарын дундаж орлогын бүлэглэлт, байршлаар	23
Зураг 4.6. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн малын тоог богд шилжүүлэн тооцсон хувь	23
Зураг 4.7. Малчин өрхийн сарын дундаж орлого, хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлгээр, мянган төгрөг	24
Зураг 4.8. Малчин өрхийн сарын дундаж орлого, МАА-н арга хэлбэрээр	24
Зураг 4.9. Малчин өрхийн сарын дундаж орлогын бүтэц, МАА-н арга хэлбэрээр	25
Зураг 4.10. Малчин өрхийн сарын дундаж зарлага, бүцтээр	25
Зураг 4.11. Малчин өрхийн сарын дундаж зарлагын бүлэглэлт	26
Зураг 4.12. Малчин өрхийн сарын дундаж зарлагын бүлэглэлт, байршлаар.....	27

Зураг 4.13. Малчин өрхийн сарын дундаж зарлага, хонин толгойд шилжүүлсэн малын тоогоор.....	27
Зураг 4.14. Малчин өрхийн сарын дундаж зарлага, МAA арга хэлбэрээр	28
Зураг 4.15. Малчин өрхийн сарын дундаж зарлагын бүтэц, МAA-н арга хэлбэрээр.....	28
Зураг 4.16. Нийт малчин өрхийн малын түүхий эдээс хүртэж буй ашиг шим	29
Зураг 4.17. Зээлтэй малчдын хувь, насны бүлгээр, 2017 он.....	34
Зураг 4.18. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүд, зээлтэй эсэх, байршлаар	35
Зураг 4.19. Зээлийн зориулалт, хувиар.....	36
Зураг 4.20. Зээлтэй өрхийн эзлэх хувь, зээлийн дундаж хэмжээ, малын тоогоор.....	36
Зураг 4.21. Зээлтэй өрхийн эзлэх хувь, өрхийн орлогын бүлэглэлтээр	37
Зураг 4.22. Малчин өрхийн амьжиргаа сайжирсан эсэх, хувиар.....	37
Зураг 4.23. Малчин өрхүүдэд чухал хэрэгцээтэй байгаа зүйлс, хувиар	38
Зураг 5.1. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлт, хүйсээр	39
Зураг 5.2. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлт, насны бүлгээр	39
Зураг 5.3. Малчин өрхийн хөдөлмөр эрхлэж буй гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр, хувиар	40
Зураг 5.4. Малчин өрхийн хөдөлмөр эрхлэж буй гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр, хувиар, байршлаар	40
Зураг 5.5. Малчин өрхийн хөдөлмөр эрхлэж буй гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр, насны бүлгээр	40
Зураг 5.6. Малчдын мал малласан жил, насны бүлгээр	41
Зураг 5.7. Эдийн засгийн идэвхгүй байгаа шалтгаан	41
Зураг 5.8. Эдийн засгийн идэвхгүй байгаа голлох шалтгаан, насны бүлгээр	41
Зураг 5.9. Малчин өрхийн МAA-д өдөрт зарцуулж буй цаг, байршлаар.....	42
Зураг 5.10. Малчин өрхийн МAA-д өдөрт зарцуулж буй цаг, үндсэн болон туслах малчин	42
Зураг 5.11. МAA салбарт хөдөлмөр эрхлэж буй малчдын хувь, ахуйн хүрээн дэх хөдөлмөр эрхлэлтээр, хүйсээр	43
Зураг 5.12. МAA салбарт хөдөлмөр эрхлэж буй малчдын хувь, ахуйн хүрээн дэх хөдөлмөр эрхлэлтээр, насны бүлгээр	44
Зураг 5.13. МAA салбарт хөдөлмөр эрхлэж буй малчдын хувь, ахуйн хүрээн дэх хөдөлмөр эрхлэлтээр, байршлаар	44
Зураг 5.14. МAA салбарт хөдөлмөр эрхлэж буй малчдын хувь, ахуйн хүрээн дэх хөдөлмөр эрхлэлтээр, бүсээр.....	45
Зураг 5.15. Малчдын мал маллаж буй арга хэлбэр, байршлаар	45
Зураг 5.16. МAA-н салбарыг хөгжүүлэх хэлбэр	46
Зураг 5.17. Малчдын хувь, цаашид ямар хэлбэрийн МAA хөгжүүлэх нь хэрэгтэй эсэхээр, насны бүлэг, бүсээр	46
Зураг 5.18. МAA-н салбарыг хөгжүүлэх хэлбэр	47
Зураг 5.19. Малчид мал маллахад тулгарч буй хүндрэл бэрхшээл	47
Зураг 5.20. Малчид мал маллахад тулгарч буй хүндрэл бэрхшээл, бүсээр	48
Зураг 5.21. Малчид мал маллахад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг даван туулж буй хувь	48
Зураг 5.22. Малчид мал маллах явцад ямар нэг торгуульд орж байсан эсэх, байршлаар	49
Зураг 6.1. Судалгаанд хамрагдсан үндсэн болон туслах малчид, насны бүлгээр.....	50
Зураг 6.2. Үндсэн болон туслах малчид, насны бүлгээр, 2017 он	51
Зураг 6.3. Үндсэн болон туслах малчдын хувь, мал малласан жилээр.....	51
Зураг 6.4. Үндсэн болон туслах малчдын хувь, боловсролын түвшингээр	52

Зураг 6.5. Үндсэн болон туслах малчдын хувь, хонин толгойд шилжүүлсэн нийт хариулж буй малын тоогоор.....	52
Зураг 6.6. Үндсэн болон туслах малчдын хувь, хонин толгойд шилжүүлсэн тавиул малын тоогоор.....	52
Зураг 6.7. Малчид мал хөлсөөр харуулдаг эсэх, өрхийн тэргүүлэгчийн насны бүлгээр.....	53
Зураг 6.8. Малаа хөлсөөр харуулдаг малчин өрх, хэнийг хөлсөлдөг эсэх, гэрээ байгуулдаг эсэх	53
Зураг 6.9. Мал хүнээр харуулсан, харсан тохиолдолд хөлсөө ямар хэлбэрээр авдаг эсэх.....	54
Зураг 6.10. Фермерийн МАА эрхэлдэг малчин, фермерийн аргаар	55
Зураг 6.11. Анх малтай болоход нөлөөлсөн хүчин зүйлс, мал маллагааны хэлбэрээр	55
Зураг 7.1. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн гишүүд, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр, хувиар	56
Зураг 7.2. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн иргэдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь, насны бүлэг, төрөлхийн, олдмол эсэхээр.....	56
Зураг 7.3. Судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, хувиар.....	57
Зураг 7.4. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн ундны усны эх үүсвэр	57
Зураг 7.5. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн ундны усны эх үүсвэр, бүсээр	58
Зураг 7.6. Малчин өрхүүдээс хамгийн ойр эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх дундаж зай, байршлаар, километрээр.....	58
Зураг 7.7. Малчдын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан байдал, үйлчилгээний төрлөөр*	59
Зураг 7.8. Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан малчид үйлчилгээний төрөл, хүйсээр.....	59
Зураг 7.9. Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан малчдыг насны бүлгээр.....	60
Зураг 7.10. Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаагүй шалтгаан	60
Зураг 7.11. Малчдын малаас хүнд халдварладаг өвчний талаарх мэдлэг, сонссон байдал бүсээр	61
Зураг 7.12. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүдийн боловсролын түвшин, насны бүлгээр	62
Зураг 7.13. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 6-15 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдалт, байршлаар.....	62
Зураг 7.14. Сургуульд хамрагдаагүй малчин өрхийн 6-15 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдаагүй шалтгаан	63
Зураг 7.15. ЕБС-д хүүхдийг 6 наснаас хамруулж байгаа нь зөв эсэх, буруу гэж үзэж буй бол шалтгаан.....	63
Зураг 7.16. Малчдын сүүлийн 12 сарын хугацаанд шинээр мэргэжил болон ур чадвар олгох сургалтад хамрагдсан байдал, байршлаар	64
Зураг 7.17. Сургалтад хамрагдсан малчдаас ямар байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдсан эсэх, хувиар	64
Зураг 7.18. Насны бүлэг дэх малчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал төлөлтийн хувь, насны бүлгээр	66
Зураг 7.19. Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал төлдөг малчдын нийт малчдад эзлэх хувь, аймгаар, 2017 он	67
Зураг 7.20. Сүүлийн 12 сарын хугацаанд нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, төлсөн сараар	67
Зураг 7.21. Сүүлийн 12 сарын хугацаанд нийгмийн даатгалд хамрагдсан байдал, төлсөн сар, байршлаар	68
Зураг 7.22. Сүүлийн 12 сарын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, төлсөн сараар, байршлаар.....	68

Зураг 7.23. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн гишүүдийн сүүлийн 12 сарын нийгмийн даатгалд хамрагдсан байдал, мал малласан жилээр	68
Зураг 7.24. Сүүлийн 12 сарын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, мал малласан жилээр	69
Зураг 7.25. Сүүлийн 12 сарын нийгмийн даатгалд хамрагдсан байдал, насны бүлгээр	69
Зураг 7.26. Өрхийн гишүүдийн сүүлийн 12 сарын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, насны бүлгээр	69
Зураг 7.27. Өрхийн гишүүдийн сүүлийн 12 сарын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, хүйсээр.....	70
Зураг 7.28. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн гишүүдийн сүүлийн 12 сарын НДШ, ЭМДШ төлөөгүй шалтгаан	70
Зураг 7.29. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүд НДШ, ЭМДШ төлснөөр нийгмийн баталгаа хангагдана гэж бодож буй эсэх.....	71
Зураг 7.30. Малчдын тэтгэврийн насыг өөрчилсөн нь зөв гэж үзсэн малчдын шалтгаан ...	71
Зураг 7.31. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүд НДШ, ЭМДШ төлөх сонирхол	72
Зураг 7.32. Төсөл хөтөлбөрт хамрагдаж байсан малчид ямар төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдсан эсэх.....	73
Зураг 7.33. Төсөл хөтөлбөрт хамрагдаж байсан малчид ямар төсөл хөтөлбөрүүдэд хамрагдсан эсэх.....	73
Зураг 7.34. Ноос болон арьс ширний урамшуулалд хамрагдсан байдал	75
Зураг 7.35. Ноос болон арьс ширний урамшууллын ач холбогдол	76
Зураг 7.36. Малчдыг дэмжиж ажиллах талаарх байгууллагууд үнэлгээ	77
Зураг 7.37. Малчдыг дэмжиж ажиллах талаарх байгууллагууд үнэлгээ	78
Зураг 7.38. Малчдыг дэмжиж ажиллах талаарх байгууллагууд үнэлгээ	78
Зураг 7.39. Төр засгийн зүгээс малчдыг дэмжих бодлогын чиглэлүүд.....	79
Зураг 7.40. Төр засгаас хэрэгжүүлж буй хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, үйлчилгээний талаарх мэдээллийг ямар эх сурвалж	81
Зураг 7.41. Төр засгаас хэрэгжүүлж буй хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, үйлчилгээний талаарх мэдээллийг ямар эх сурвалж, байршлаар.....	81

Товчилсон үгс

ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ШХА	Швейцарын Хөгжлийн Агентлаг
МАА	Мал аж ахуй

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгааг бүсийн төлөөлөл болох 8 аймаг, 24 сум, нийслэлийн МАА болон фермер өрх амьдардаг хоёр дүүргийн төлөөллийг хамруулан, нийт 1050 малчин өрхөөс судалгааны мэдээллийг авч, үр дүнг боловсрууллаа. Малчдын 96.5 хувь нь өөрийн эзэмшлийн малаа хариулдаг гэсэн бол 3.5 хувь нь бусдын малыг ямар нэгэн байдлаар хариулдаг туслах малчин байна. Мал маллагааны арга хэлбэрийг авч үзвэл 94.0 хувь нь уламжлалт аргаар МАА эрхлэж байгаа бол 6.0 хувь нь фермерийн аж ахуй эрхлэж байна. Фермерийн аж ахуй эрхлэж байгаа малчдын 55.6 хувь нь фермер болон уламжлалт арга хосолсон, 44.4 хувь нь дан фермерийн мал аж ахуй дагнан эрхэлдэг байна.

Өрхийн ам бүлийг тооцвол нэг өрх дунджаар 3.9 гишүүнтэй (4080 хүн) байгаагаас тэдгээрийн 50.4 хувь нь эрэгтэй, 49.6 хувь нь эмэгтэйчүүд юм. Судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн 29.3 хувь нь 15 хүртэлх насны хүүхэд, 53.6 хувь нь 15-49 насны иргэд, үлдсэн 17.1 хувь нь ахмад настнууд байна.

Судалгаанд хамрагдсан 15 ба түүнээс дээш насны өрхийн гишүүдийн 57.8 хувь нь батлуулсан, 5.9 хувь нь батлуулаагүй гэр бүлтэй байгаа бол 30.4 хувь нь огт гэрлээгүй байна. Өрхийн тэргүүлэгчийн хувьд судлагдсан өрхийн 89.4 хувьд нь эрэгтэйчүүд, 10.6 хувьд нь эмэгтэйчүүд өрх тэргүүлэн амьдарч байна. Нэг өрх дунджаар 4 гишүүнтэй (3.88) байгаа ба өрхийн бүтцийг харвал өрхийн тэргүүн, эхнэр/нөхөр, 2 хүүхдийн хамт амьдарч байна.

Сууцны төрөл, хэлбэр. Судалгаанд хамрагдсан малчид хүйтний улирал(өвөл, хавар)-д 85.9 хувь нь гэрт амьдардаг бол 14.0 хувь нь байшинд амьдардаг гэжээ. Сууцны өмчлөлийг харвал 98.1 хувь нь өөрийн сууцанд, 1.9 хувь нь бусдын сууцанд түрээстэй болон түрээсгүй суудаг.

Цахилгаан хангамж. Судлагдсан өрхийн 98.1 хувь нь цахилгааны эх үүсвэртэй байгаагаас 60.8 хувь нь нар, салхины сэргээгдэх эрчих хүч, 21.0 хувь нь бага оврын цахилгаан үүсгүүр, 16.2 хувь нь төвлөрсөн систем, 0.2 хувь нь бусад эх үүсвэр ашиглаж байна. Нийт өрхийн 1.9 хувь нь цахилгаан хэрэглэдэггүй.

Дулааны эх үүсвэр. Түлшний хэрэглээний хувьд судлагдсан малчин өрхийн 98.0 хувь нь ердийн галлагаагаар, 1.2 хувь нь нам даралтын зуухаар сууцаа халаадаг. Түлшний хэрэглээний хувьд 63.7 хувь нь сууцаа халаахдаа аргал, хөрзөн, 23.5 хувь нь мод, заг, бургас, үртэс, 10.1 хувь нь нүүрс ашигладаг.

Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө. Хот болон аймгийн төв гэх мэт төв суурин газарт судалгаанд оролцогчид малчдын 5.3 хувь нь төвлөрсөн халаалтын системд холбогдсон орон сууцтай бол 2.6 хувь нь бие даасан тохилог сууц, 26.2 хувь нь сууцны тусдаа байшинтай, 40.9 хувь нь өмчилсөн газартай гэжээ. Судлагдсан малчдын тухайд 67.8 хувь нь өөрийн гэсэн өвөлжөөтэй, 41.3 хувь нь хаваржааны газартай гэжээ.

Техник хэрэгслийн хэрэглээ жил тутам нэмэгдэх болсон. Судалгаанд хамрагдсан нийт малчин өрхийн 84.0 хувь нь ямар нэг механикжсан тээврийн хэрэгсэлтэй гэж хариулсан бөгөөд дөрвөн өрх тутмын нэг (25.8 хувь) нь суудлын машинтай, гурван өрх тутмын нэг (36.6 хувь) нь ачааны машинтай, гурван өрх тутмын хоёр (64.1 хувь) нь мотоциклтой байна. Өрхийн хэрэглээний хувьд хоёр өрх тутмын нэг (55.3 хувь) нь цахилгаан үүсгүүртэй, гурван өрх тутмын нэг (36.3 хувь) нь хөргөгчтэй, 6.5 хувь нь интернет хэрэглэдэг.

Өрхийн орлогын бүтэц. Судалгаанд хамрагдсан малчдын өрхийн орлогын бүтцийг тодруулвал, 10.7 хувь нь цалин хөлс, 17.2 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, 66.8 хувь нь мал аж, ахуй, 4.3 хувь өрхийн бизнес эрхлэж, 1.0 хувь нь бусад эх үүсвэрээс орлого олдог гэжээ.

Малчин өрхийн хувьд мал, малын гаралтай түүхий эд өрхийн орлого бүрдүүлэхэд голлох нөлөө үзүүлдэг. Гэхдээ энэ нь газар зүйн байршлаас хамааран хэмжээний хувьд харилцан адилгүй байгаа юм.

Малчдын орлого бүрдүүлэхэд нөлөөлж буй харьцаа хэмжээг харвал мал аж ахуйн орлого (95.0 хувь), тэтгэмж тэтгэвэр (74.9 хувь), цалин хөлс (16.7 хувь) голлох нөлөө үзүүлж байгаа бол өрхийн бизнес (4.8 хувь), бусад (5.1 хувь) эх үүсвэр 10.0 орчим хувийг эзэлж байна.

Орлогын хэмжээ. Судалгаанд хамрагдсан нийт малчдын сарын дундаж орлого 959.0 мянган төгрөг байна. Нийт өрхийн 89.5 хувь нь ноос, ноолуураас, 87.1 хувь нь арьс, ширнээс, 31.7 хувь нь сүүнээс, 2.2 хувь нь сүүн бусад бүтэгдэхүүнийг зарж ашиг шимийг нь хүртдэг байна. Мөн нийт өрхийн 55.0 хувь мал зарж, 24.6 хувь нь мал махалж ашиг шимийг нь хүртсэн байна.

Зарлагын тооцоо. Судалгаанд хамрагдсан малчдын өрхийн сарын дундаж зарлагын бүтцийг харвал нийт зардлын 14.8 хувийг хүнсэнд, 13.1 хувийг гэр ахуйн бараа, хувцас хэрэглэл худалдаж авахад, 4.3 хувийг сургалтын төлбөрт, 18.2 хувийг малын тэжээлд, 1.7 хувийг шатахуунд, 11.0 хувийг түлээ, түлшинд, 3.4 хувийг харилцаа холбоонд, 6.1 хувийг боловсролд, 5.7 хувийг эрүүл мэндийн үйлчилгээнд, 17.4 хувийг зээлийн төлбөрт, 2.2 хувийг туслах ажилтны цалинд, 1.0 хувийг цахилгаан, ус дулааны төлбөрт, үлдсэн 1.1 хувийг бусад зүйлд зарцуулсан байна.

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 54.6 хувь нь зээлтэй байлаа. Нийслэл болон сумын төвөөс хамрагдсан 5 өрх тутмын 3 нь, аймгийн төв болон хөдөөний 2 өрх тутмын 1 нь зээлтэй байлаа. Зээлтэй өрхийн 97.0 хувь нь арилжааны банкнаас дунджаар 18.2 сарын хугацаатай 5.7 сая төгрөгийн зээл авсан байна. Зээл авсан нийт өрхийн 49.2 хувь нь ахуйн хэрэглээнд, 18.8 хувь нь оюутны сургалтын төлбөрт, 18.7 хувь нь автомашин худалдан авахад, 13.4 хувь нь хадлан тариа бэлтгэх, малын тэжээл худалдан авахад, 10.8 хувь нь өрөө дарах зориулалтаар тус тус зээл авсан байна.

Малчин өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүдийн 74.1 хувь нь хөдөлмөр эрхлэдэг бол 25.9 хувь нь одоогоор хөдөлмөр эрхлээгүй байна.

МАА-н салбарт хөдөлмөр эрхлэж буй малчдын дийлэнх нь мал хариулах, услах, ноос, ноолуур самнах, хяргах, хашаа хороо барих, нутаг сэлгэж нүүх, оторлох, мал зарж борлуулах, өвлийн бэлтгэл хангах зэрэг ажлыг хийдэг. Үйл ажиллагааны төрлөөр харвал 3 малчин тутмын 2 нь мал саах, нэмэлт тэжээл авах, тарих, цагаан идээ боловсруулах ажлыг хийдэг бол 2 малчин тутмын 1 нь арьс шир боловсруулах, сүү цагаан идээ зарж борлуулах ажлыг хийдэг байна.

Малчдын аж байдлын судалгаанд “НДШ болон ЭМД-ыг сүүлийн 12 сарын хугацааны хэдэн сард нь төлсөн бэ?” гэсэн асуултад судалгаанд оролцсон малчдын 71.1 хувь нь нийгмийн даатгал төлөөгүй гэсэн бол 26.7 хувь нь 12 сарын хугацаанд нийгмийн даатгал төлсөн гэжээ. Үлдсэн 2.3 хувь нь тогтмол бус боловч НДШ төлжээ.

Мал маллахад тулгарч буй бэрхшээлийг тодруулахад судалгаанд оролцогчдын 95.8 хувь нь ган гачиг, 90.3 хувь нь зуд турхан, 90.4 хувь нь бэлчээрийн хомсдол, 80.9 хувь нь гол горих булаг шанд хатах ширгэх, усны хомсдол үүсдэг гэж хариулсан бөгөөд үүний шалтгааныг цөлжилт, бэлчээрийн доройтол, даац хэтэрч байгаатай холбон тайлбарлаж байна. Мөн 2 малчин тутмын нэг нь буюу 51.9 хувь нь малын хулгай, 51.3 хувь нь араатан амьтан (чоно, үнэг, дорго) гэж хариулсан бол 21.0 хувь нь түймэр, 30.0 хувь нь үер усны аюул, 21.0 хувь нь малаа хулгайд алдах эрсдэл их байдаг гэжээ. Дээрх бэрхшээлийг даван туулж буй аргыг тодруулахад 42.1 хувь нь огт арга хэмжээ авч чадаагүй, 57.9 хувь нь эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх ямар нэгэн арга хэмжээ авдаг аж.

1. УДИРТГАЛ

1.1. Үндэслэл

Монгол улсад 2017 оны эцсийн байдлаар 228.9 мянган малтай өрх байгаагийн 74.1 хувь нь буюу 169.7 мянган малчин өрх (303.6 мянган малчин) байна.² Малчдын тоо 2017 онд өмнөх оноос 3 хувиар буюу 7.7 мянгаар буурсан бол малтай өрхийн тоо өмнөх оноос 2.0 хувиар өсжээ³. Мал аж ахуйн салбар нь хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний шингээлт өндөртэй голлох салбар(хөдөлмөр эрхлэж буй нийт иргэдийн 30.0⁴) боловч тэнд ажиллагсдын ердөө 23.9⁵ хувь нь нийгмийн даатгалд хамрагдсан байна. Энэ нь малчдын нийгмийн баталгаа өнөө болон ирээдүйд томоохон эрсдэлд байгааг зайлшгүй анхаарах шаардлагатайг илэрхийлж байна.

Манай улсад мал маллах үндсэн хоёр хэлбэр байгаагаас зонхилох (98.1 хувь⁶) хэсэг нь уламжлалт аргаар, бэлчээрийн мал аж ахуйг, үлдсэн хэсэг нь фермерийн буюу эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг. Үндэсний статистикийн хорооны 2017 оны мал тооллогын урьдчилсан дүнгээр эрчимжсэн мал аж ахуй эрхлэж байгаа иргэн, өрхийн тоо 3182, аж ахуй нэгжийн тоо 108 байна.⁷

Малын тоо толгой зах зээлийн нийгэмд шилжсэн үеэс эхлэн бараг тогтмол өссөн. Сүүлийн таван жилд 45 саяас 66 сая (2013 онд 45.144.324, 2014 онд 51.982.583, 2015 онд 55.979.781, 2016 онд 61.549.236, 2017 онд 66.218.959)⁸ толгой малтай болжээ. Мал аж ахуйн салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний 10.7 хувийг бүрдүүлдэг⁹ бөгөөд хүнсний гол бүтээгдэхүүн, боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн эх үүсвэр (нэхмэл эдлэл, арьс шир г.м) болдог онцлогтой. Улсын хэмжээнд 2017 оны жилийн эцэст хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 4256.3 тэрбум төгрөг байсан бөгөөд 3704.1 тэрбум төгрөг (87.0 хувь) нь мал аж ахуйн, 552.2 тэрбум төгрөг (13.0 хувь) нь газар тариалангийн үйлдвэрлэл байна.¹⁰

Мал аж ахуйн салбарын нийгэм, эдийн засагт гүйцэтгэх үүрэг өндөр байгаа ч салбарын өсөлт, хөгжилд гадаад (жил дараалсан ган, зуд, цөлжилт зэрэг байгаль цаг уурын өөрчлөлтийн нөлөө), дотоод (бэлчээрийн даац хэтрэлт, талхлалт) хүчин зүйлээс улбаатай бэрхшээл учирсаар л байна. Бэлчээрийн даац хэтрэлттэй холбоотой Швейцарийн хөгжлийн агентлагийн “Ногоон алт” төслийн хүрээнд хийсэн тооцоогоор нийт бэлчээр нутгийн даацыг 43.4 сая хонин толгой мал ба 5 төрлийн малаар бол 26.5 сая малд тохиромжтой¹¹ гэж тооцон гаргасан. Харин Ус цаг уур, байгаль орчны хүрээлэнгээс “2017-2018 оны өвөл, хаврын бэлчээрийн даацын тухай мэдээлэлд Монгол Улсын нийт бэлчээр нутгийн талаас илүү хувьд бэлчээрийн даац 2-5 дахин, бүр түүнээс ч олон дахин хэтэрсэн”¹² гэж мэдэгдсэн нь бэлчээр хийгээд малын тоо толгойг хэрхэн зохицуулах талаар анхаарах зайлшгүй шаардлагатай болсныг илтгэнэ.

Мал аж ахуйн салбарт тулгамдаж буй нөхцөл байдлыг салбарын эрдэмтэд “...мал аж ахуйн үйлдвэрт технологийн шинэчлэл үндсэндээ хийгдээгүй, хөрөнгө оруулалт өмнөх тогтолцооны үетэй харьцуулахад эрс буурсан, зах зээлийн шинэ орчин нөхцөлд малчид хамтран ажиллах арга хэлбэрээ олоогүй, бүтээгдэхүүнээ зах зээлд үр ашигтай борлуулах тогтолцоо бүрдээгүй...”¹³ хэмээн нэгтгэн дүгнэсэн нь бий.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн салбарын бодлогод мал аж ахуйн салбарын 2020-2025 оны хөгжлийн хандлага, стратегийн зорилтыг “... Хөгжлийн загвар нь уламжлалт өв соёлыг хадгалсан бэлчээрийн аж ахуйг зонхилон, дэвшилтэт технологи, техник

² ҮСХ, Мал тооллогын урьдчилсан дүн 2017 он

³ ҮСХ, Мал тооллогын урьдчилсан дүн 2017 он

⁴ ҮСХ, Ажиллах хүчний судалгаа, 2017 оны II улирал

⁵ ҮСХ, Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга 2017 он

⁶ ҮСХ, Мал тооллогын дүн 2017 он

⁷ ҮСХ, Мал тооллогын 2017 оны урьдчилсан дүн

⁸ Малын тоо // <https://www.1212.mn/> // 2019.01.04

⁹ ҮСХ, Дотоодын нийт бүтээгдэхүүн, 2017 он (урьдчилсан гүйцэтгэл)

¹⁰ ҮСХ, Статистикийн эмхэтгэл 2017

¹¹ ХХААЯ, ШХА, “Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан” 2015 он

¹² Ц.Энх-Амгалан. Бэлчээрийн даац хэтрэлт – цөлжилт – зуд <http://www.zaluu.com/read/21cgehbcc/> // 2019.01.04

¹³ “Малчин өрхийн амьжиргаа: Нөлөөлөх хүчин зүйлс, дээшлүүлэх арга зам” судалгаа <http://agrimatco.mn/new/?p=1576>

бүхий эрчимжсэн аж ахуйг хот суурингийн орчимд бүсчлэн хөгжүүлэх, нөөцийг тогтвортой, зохистой ашиглах, ногоон эдийн засгийн чиг баримжааг дэмжихэд суурилна” гэж эхний үед суурьшлын хэв маягт нийцүүлэн уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх, цаашид 2025-2030 оны хөгжлийн хандлага, стратегийн зорилтыг “...бэлчээрийн мал аж ахуйн өв соёлыг дэлхий нийтэд таниулсан органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн урсгалыг бий болгож үнэ цэнийн сүлжээг хөгжүүлсэн, тогтвортой үйлдвэрлэлийг явуулахад бодлого чиглэгдэнэ”¹⁴ хэмээн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр тодорхойлсон. Салбарын хөгжлийн чиглэлийг бодлого, хөтөлбөрт ийнхүү тусгасан ч:

1. Малчдын аж байдал, амьжиргаанд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс хийгээд амьжиргаа дээшлүүлэх боломж гарц,
2. Малын тоо толгойн өсөлт, байгаль цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй мал аж ахуйн салбар, малчдад тулгарч буй бэрхшээл,
3. Нийгмийн халамж хамгаалал, боловсрол, эрүүл мэнд зэрэг төрөөс үзүүлж буй үйлчилгээний хүртээмж чанар, үйлчилгээний нөхцөл хийгээд нийгмийн цаашид анхаарах чиглэл,
4. Уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуйн ялгаа, үр нөлөө зэргийг тодруулах бодит хэрэгцээ нь судалгаа хийх үндэслэл болсон.

1.2. Судалгааны зорилго, зорилтууд

Судалгааны зорилго нь малчдын аж байдлыг тодорхойлох, тулгарч буй бэрхшээл, төр засгийн зүгээс явуулж буй бодлого хөтөлбөрийн хэрэгжилт, үр нөлөөг тодруулах, улмаар судалгааны тайлан, үр дүнд үндэслэн малчдын өмнө тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэхэд чиглэсэн санал, зөвлөмж боловсруулахад судалгааны зорилго чиглэлээ. Судалгаанд зорилтуудыг дэвшүүлээ. Үүнд:

- Хүн амын дундах малчдын эзлэх хэмжээ, өсөлт бууралт,
- Малчин өрхийн амьжиргаа, орлого, зарлагын бүтэц,
- Малчдын хөдөлмөр хуваарилалт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс,
- Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж,
- Нийгмийн хамгааллын хөтөлбөрийн хэрэгжилт,
- Уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй буюу фермерийн аж ахуйн ялгаа, үр нөлөө, фермерийн аж ахуй эрхлэх боломж, бололцоо,
- Төрөөс хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөрийн хэрэгжилт, үр нөлөөг тодорхойлох

1.3. Судалгааны арга

Судалгааны онцлог, хүртээмжийг бодолцон тоон судалгааны арга буюу сурвалжлагын асуулгын аргыг сонгон авсан. Мөн хоёрдагч мэдээллийн эх сурвалж болох захиргааны тоон мэдээ, мэдээлэл, суурь судалгаа, дүрэм журамд харьцуулалт, шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.

Судалгааны анхдагч мэдээлэл цуглуулахад CAPI (Computer Assisted Personal Interview – Компьютерт суурилсан нүүр тулсан ярилцлагын арга) буюу ухаалаг төхөөрөмж ашиглаж судалгаанд оролцогчтой ярилцах байдлаар мэдээлэл цуглууллаа.

¹⁴ Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам. <http://mofa.gov.mn/exp/blog/7/240>

Схем 1. Мэдээлэл цуглуулах үйл явц



Мэдээлэл цуглуулах үйл явц *нэгдүгээрт*: CSPro 7.1 программд таблетад суурилуулах асуултын эхийн загварыг бэлтгэж, бүх таблетад нэгэн зэрэг байршуулах, *хоёрдугаарт*: судлаач өгөгдсөн асуулгын дагуу хариулагчаас сурвалжлагын асуулгын аргаар мэдээлэл цуглуулах (байршил, мэдээлэл авах үеийн болон мэдээлэл авахад зарцуулсан хугацаа), *гуравдугаарт*: цуглуулсан мэдээллийг утасгүй интернетийн сүлжээгээр дамжуулан төв систем рүү илгээх, *дөрөвдүгээрт*: цуглуулсан мэдээлэл автоматаар нэгтгэгдэх, *тавдугаарт*: талбарын судлаачдын явуулсан мэдээллийг дор бүр нь шалгаж мэдээллийн чанарыг дээшлүүлэх, *зургаадугаарт*: цуглуулсан нийт мэдээлэлд анхдагч болон хоёрдогч боловсруулалт хийж судалгааны үр дүнг гаргалаа.

1.4. Түүвэрлэлт

Тус судалгааны түүврийн онцлог, тархалтыг тооцон, олон шатлалт, тохиолдлын түүврийн аргыг ашигласан бөгөөд эхний шатанд аймаг, дүүргийг, хоёр дахь шатанд сум болон хороодыг, гурав дахь шатанд тухайн сумдаас хоёр багийг, дөрөв дэх шатанд судалгаанд оролцогчдыг сонгож мэдээлэл цуглуулсан.

Малчдын аж байдлын судалгааны түүврийн нэгж нь малчин өрх юм. Түүврийн хэмжээг дараах томъёогоор тооцож гаргав. Үүнд:

$$n = \frac{4 * r * (1 - r) * deff}{(RME * r) * pb * AveSize * PR}$$

$$Standard\ error\ (se): (r * RME) / 2$$

- r Нийт орон нутгийн өрхөд эзэлж буй малчин өрхийн эзлэх хувь (Хөдөөний өрх = сумын төвийн өрх болон хөдөөний өрхийн тоо);
- pb Нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувь;
- $AveSize$ Ам бүлийн дундаж тоо;
- RME 95 хувийн итгэх магадлалтай түүврийн харьцангуй алдаа;
- $Deff$ Түүврийн нөлөө;
- RR Өрхийн хариулах хувийг 90 хувь гэж авч үзвэл

Дээрх утгуудыг орлуулж түүврийн хэмжээг тооцоход 1090 гарсан бөгөөд түүврийн хэмжээг түүврийн анхан шатны нэгжид тэгш хуваарилагдахаар 1050 өрхийг судалгаанд хамруулсанаар судалгааны найдвартай байдал, төлөөлөх чадвар өндөр болсон. Харин түүврийн нарийвчлалыг аймаг, дүүргийн ойролцоо оршин суудаг малчид болон фермерүүдээс 25 өрх, сумдаас тус бүр хоёр баг сонгож нийт 50 өрхөөс мэдээлэл авахаар тооцсон.

Судалгааны үр дүнг үндэсний түвшинд, мөн хот, хөдөө болон бүсээр тооцох, харьцангуй олон талбараас мэдээлэл цуглуулах зорилгоор түүврийн зохиомжийг хийсэн. Судалгаанд баруун бүсээс Говь-Алтай аймгийн Алтай хот, Жаргалан, Халиун сум, Завхан аймгийн Улиастай хот, Эрдэнэхайрхан, Тэлмэн сум, хангайн бүсээс Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот, Цагааннуур, Баруунбүрэн сум, Хөвсгөл аймгийн Мөрөн хот, Алаг-Эрдэнэ, Цагаан-Уул сум, төвийн бүсээс Дундговь аймгийн Сайнцагаан, Эрдэнэдалай, Дэрэн сум, Өвөрхангай аймгийн Арвайхээр хот, Өлзийт, Зүүнбаянулаан сум, зүүн бүс Дорнод аймгийн Хэрлэн хот, Баяндун, Цагаан-Овоо сум, Сүхбаатар аймгийн Баруун-Урт хот, Баяндэлгэр, Түвшинширээ сум, Улаанбаатар хотоос Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийг сонгож тухайн засаг захиргааны нэгжид харъяалал бүхий малчид, фермерүүдийг хамруулсан.

1.5. Мэдээлэл боловсруулалт

Түүврийн аргачлалд тусгасны дагуу судалгааны явцад хуримтлуулсан 1050 өрхийн мэдээллийг тайлан, үр дүн гаргахад ашигласан бөгөөд үр дүнг боловсруулахдаа SPSS 25 программыг ашиглаж анхдагч болон хоёрдогч боловсруулалт хийсэн.

1.6. Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт

“Малчдын аж байдлын судалгаа”-ны ерөнхий зохион байгуулалт, бэлтгэл ажил 2018 оны 4 дүгээр сараас эхэлсэн.

Зураг 1.1. Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт



Судалгааг зохион байгуулахад дараах үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Бэлтгэл ажлын хүрээнд:
 - Судалгааны арга зүй, аргачлал, хөтөлбөр боловсруулах;
 - Судалгааны асуулга, нөхөх зааврыг боловсруулах;
 - Түүврийн зохиомж боловсруулах, түүвэрлэлт хийх;
 - Судалгааны мэдээллийг оруулах, шалгах, засварлах, үр дүнгийн хүснэгт гаргах программын бодлогын даалгаврыг боловсруулах;
 - Туршилтын судалгаа явуулах;
 - Туршилтын судалгааны үр дүнд суурилан судалгааны асуулга, нөхөх заавар, оролтын программыг эцэслэн боловсруулах;
 - Судалгааны мэдээлэл цуглуулах судлаач, багийн ахлагч нарт зориулсан сургалт зохион байгуулах;
- Мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд:
 - Мэдээлэл цуглуулах явцад хяналт тавьж, зөвлөх;

3. Боловсруулалт, тайлан бичих ажлын хүрээнд:
 - Судалгааны мэдээллийг шалгаж, засварлах, кодлох;
 - Үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулах;
4. Үр дүнг түгээх, хэвлэн нийтлэх ажлын хүрээнд:
 - Нэгдсэн тайлан боловсруулж хэвлэх;
 - Анхдагч мэдээллийн нууцлалыг хангаж, хэрэглэгчдэд нээлттэй түгээх;
5. Судалгааны архив үүсгэх:
 - Судалгааны бүх үе шатны ажилбарыг архивлах.

1.7. Судалгааны мэдээлэл цуглуулалт

Судалгааны мэдээлэл цуглуулах үйл явцыг хоёр үе шаттайгаар зохион байгууллаа. Эхний удаад судалгааны асуулгын агуулга, үзүүлэлтийн уялдаа холбоо, хариулагчид ойлгомжтой байдлыг тодорхойлох, мэдээлэл цуглуулалтын зохион байгуулалт, асуулгад зарцуулж буй хугацаа зэргийг нягталж эцэслэх зорилгоор туршилтын судалгааг 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Улаанбаатар хотын Багануур дүүрэгт зохион байгуулав. Тус туршилтаар нийт 18 малчин өрх болон фермерээс судалгаа авч туршилтын судалгааны үр дүнд асуулгыг эцэслэн засварлаж, баталсан.

Эцэслэсэн арга, аргачлал, асуулгын дагуу судалгааны багийн ахлагч, мэдээлэл цуглуулагч нарт 2 хоногийн сургалт зохион байгууллаа. Сургалтыг ХНХСИ-ийн сургалтын танхимд явуулсан бөгөөд судалгааны мэдээлэл цуглуулагч нарыг 10 хувийн нөөцтэй бэлтгэж, нөөц бүрдүүлсэн.

Багийн ахлагч нарт тусгайлан нэмэлт сургалт хийж, судалгааг хэрхэн зохион байгуулж явуулах талаар заавар, зөвлөгөө өгч, тусгайлан гарын авлагаар хангасан. Сургалтын дараа оролцогчдыг тодорхой байршилд туршилт хийлгэж, гаргаж буй алдаа, тодорхой бус асуудал байвал газар дээр нь зөвлөгөө өгөх байдлаар дадлагажуулсаны дараа мэдээлэл цуглуулах байршлуудад хуваарилсан.

Судалгааны мэдээлэл цуглуулах үүрэг бүхий багийг ахлагч, 2 мэдээлэл цуглуулагч, жолооч гэсэн бүрэлдэхүүнтэй байхаар зохион байгуулсан. Мэдээлэл цуглуулах ажлыг 2018 оны 5 дугаар сарын 20-оос хөдөө орон нутагт эхэлж, 2018 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн малчдыг судалгаанд хамруулснаар дууссан бол мэдээлэл боловсруулалтын ажил 2018 оны 6 дугаар сарын 18-ны өдрөөс 2018 оны 7 дугаар сарын 20-ны өдрүүдэд үргэлжилсэн.

1.8. Судалгааны агуулга, үзүүлэлт

Судалгаанд тусгагдсан зарим үзүүлэлтүүдийн ойлголт тодорхойлолтыг Монгол улс болон олон улсын нийтлэг стандарт бүхий ойлголт, тодорхойлолттой нийцүүлэн тусгасан. Ингэснээс судалгааны үр дүнг энэ чиглэлээр хийгдэж буй бусад судалгаа, олон улсын зарим судалгааны үр дүнтэй зэрэгцүүлэн дүн шинжилгээ хийх боломжийг олгож байна.

Малчин Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд зааснаар мал аж ахуй эрхлэж үндсэн орлогоо олдог иргэнийг;

Малчин өрх Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд зааснаар хувийнхаа өмчийн малыг маллаж, ашиг шимээр нь үндсэн орлогоо олдог гэр бүлийг;

Мал бүхий этгээд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд зааснаар малчин өрхөөс бусад мал өмчилж байгаа хувь хүнийг ойлгоно.

Өрхийн тэргүүлэгч Өрхийн тэргүүлэгч гэдэг нь бусад гишүүд нь өрхийн тэргүүн хэмээн хүлээн зөвшөөрсөн өрхийн гишүүн бөгөөд насанд хүрсэн хүн байна. Хэрвээ тухайн сууцанд нэгээс олон өрх амьдран сууж байвал төдий тооны өрхийн тэргүүн байна.

Сууцны төрөл

Гэр Бүх төрлийн гэр, цаатны урцыг хамруулна.

Орон сууцны байшин Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалттай, судалгаа авах үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй суурин барилгын доторх сууцыг хэлнэ. Энэ нь айл, өрх амьдрахаар баригдсан, өрх тус бүрт зориулагдсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, бүрэн тоноглол төхөөрөмж, дэд бүтэц бүхий өрөөнүүдтэй байна. Орон сууцны байшин нь дэд бүтцийн бүх төрлийн суурь хангамжаар тоноглогдсон, дараах нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байна. Үүнд:

- а) Цахилгаан, дулааны шугам сүлжээ болон усан хангамжийн сүлжээтэй;
- б) Сууцны дотор бие засах газартай;
- в) Сууцны дотор байрлуулсан онгоц, шүршүүртэй;
- г) Зориулалтын гал тогоо болон хоол хийх өрөө эсвэл талбайтай байна.

Бие даасан тохилог сууц (хаус) Нэг өрх амьдрах зориулалттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний холболт болон оролт нь бие даасан бөгөөд дулаан, агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай (ус татуургатай) байна. Өрөө тасалгаа нь өөр айлын сууцны өрөө, тасалгааны дээр байрлаагүй, орц, туслах өрөө тасалгаа, дээврийн хөндий, зоорины давхар, шугам сүлжээний хонгил зэрэг нь нийтийн бус зориулалттай сууцыг үүнд хамааруулна. Сууцны өрөө (унтлагын ба зочны), гал тогоо, ариун цэврийн буюу шүршүүрийн өрөө, бие засах өрөө, агуулах, ханын шүүгээтэй, мөн мансардтай, эсвэл мансардгүй байж болно.

Сууцны тусдаа байшин Ихэвчлэн гэр хорооллын хашаанд 1, түүнээс олон өрөөтэй, дэд бүтцийн (гал тогоо, онгоц, шүршүүр, халаалтын систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг) хангамжууд бүхэлдээ болон аль нэг нь байхгүй сууц орно.

Нийтийн байр Иргэд бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ амьдран суудаг, олон өрөөтэй сууцыг хамааруулна. Нийтийн байр нь ихэвчлэн гал тогоо, бие засах газар, халуун усны шүршүүр, уулзалтын танхимтай байдаг. Нийтийн байр гэдэгт оюутан, сурагчдын дотуур байр, байгууллагын ажиллагчдын байр орно.

Хөдөлмөр Оюуны болон биеийн хүчний ажлыг хамруулсан өргөн хүрээтэй ойлголт бөгөөд ажил эрхлэх чадамжийг ойлгоно.

Ажил эрхлэлт Ажилтан болон ажил олгогчийн хооронд үүссэн эрх зүйн харилцаа буюу гэрээний үндсэн дээр хийгдэж буй үйл ажиллагааг ойлгоно.

Эдийн засгийн идэвхгүй хүн ам Эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарагдахгүй хөдөлмөрийн насны нийт хүн ам болон хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн ам, хөдөлмөрийн наснаас дээш насны хүн амыг хамруулна. Эдийн засгийн идэвхгүй хүн амд хөдөлмөрийн нөхцөл, онцлогоос шалтгаалан тэтгэврийн наснаас өмнө тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон хүн ам, хөдөлмөрийн чадвараа зургаан сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан иргэн, хөдөлмөрийн насны өдрөөр суралцагч, хүндэтгэх ба хүндэтгэх бус шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй болон хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн амыг хамруулна. Эдийн засгийн идэвхгүй хүн амыг эдийн засгийн байнгын идэвхгүй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхгүй хүн ам гэж хоёр ангилна.

Ажиллагч Ажиллагч гэдэг нь цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг ойлгоно. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ.

Хөдөлмөр эрхлэлтийн статус Эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэж байгаа тухайн хүний ажиллаж байгаа байгууллага, бусад хүмүүстэй харьцах эрх мэдэл, ажил үүрэг, хүлээх хариуцлагаар тодорхойлогдоно.

Цалин хөлстэй ажиллагч Хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан эсхүл аман гэрээ болон хоёр талын тохиролцоогоор ажилладаг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг, ажил олгогчдод ажил, үйлчилгээ үзүүлснийхээ төлөө мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаг иргэнийг хэлнэ.

Ажил олгогч Эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бие даан гаргаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон ашиг буюу ашиг олох боломжоос шууд хамаарах бизнестээ урт хугацаагаар нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн болон бусад гэрээ, тохиролцооны үндсэн дээр авч ажиллуулж буй эзэн, байгууллагын удирдлагыг хэлнэ.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч Дангаараа буюу бусадтай хамтран өөрийн багаж, тоног төхөөрөмж, бусад материалыг ашиглан эдийн засгийн үйл ажиллагааг хараат бусаар явуулж, урт хугацаагаар ажилтан авч ажиллуулдаггүй (харин богино хугацаагаар түр авч ажиллуулж болно), бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрийг бие даан гаргадаг иргэнийг хэлнэ.

Мал аж ахуй эрхлэгч Жилийн дөрвөн улирлын туршид өөрийн мал аж ахуйг эрхлэж, түүний бүтээгдэхүүн, ашиг шимээр орлого олж, амьжиргааны эх үүсвэрээ хангаж буй иргэнийг хэлнэ.

Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч Мал аж ахуйгаас бусад өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд цалин хөлсгүй оролцон, хувийн хэрэглээгээ хангаж буй тухайн өрхийн гишүүн болон тухайн өрхөд хамт амьдрахгүйгээр аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд нь оролцож байгаа иргэнийг хэлнэ.

Дээрх ойлголт тодорхойлолтыг ашиглан судалгааны агуулга, үзүүлэлтийг судалгааны зорилтод тодорхойлсон үзүүлэлтийн хүрээнд үндэслэн боловсрууллаа. Асуулгыг дараах бүлэг, агуулгаар боловсруулсан. Үүнд:

Малчдын аж байдал Өрхийн хүн амын үзүүлэлт, ахуй нөхцөл байдал, сууцны нөхцөл, усны эх үүсвэр, ариун цэврийн байгууламж, орлого, орлогын эх үүсвэр, эд хөрөнгө

Хөдөлмөр эрхлэлт Өрхийн хөдөлмөр хуваарилалт, МАА-д зарцуулж буй цаг

Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний хүртээмж

Төрийн бодлого, хөтөлбөрүүд Төрөөс хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үр нөлөө


Эрчимжсэн МАА талаар Эрчимжсэн МАА ач холбогдол, шилжих сонирхол, боломж

2. МАЛЧИД, МАЛЧИН ӨРХ

2.1. Статистикийн судалгаан дахь малчдын дүр зураг

Малчид. 2017 оны байдлаар нийт 303.6 мянган малчин мал ахуйн салбарт ажиллаж байгаа бөгөөд өмнөх оноос 7 783 (2.5 хувь)-аар, 2000 оноос 117.8 мянгаар (27.9 хувь) буурсан байна.


Зураг 2.1. Малчдын тоо, өсөлтийн хувиар, 1990-2017 он



Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, www.1212.mn

Мал аж ахуйн салбарт ажиллаж буй малчдыг бүс нутгаар тодруулвал 2017 оны байдлаар хангайн бүсэд 41.1, баруун бүсэд 26.1, төвийн бүсэд 19.9, зүүн бүсэд 12.0, Улаанбаатар хотод 1.0 хувь нь харъяалагддаг. Малчдын тоогоор Хөвсгөл (10.3 хувь), Өвөрхангай (9.3 хувь), Архангай (8.9 хувь), Баянхонгор (7.3 хувь), Төв (6.4 хувь), Баян-Өлгий (5.7 хувь), Увс (5.7 хувь) аймгууд харьцангуй өндөр хувьтай байна.

Зураг 2.2. Малчдын тоо, аймгаар, 2017 он




Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, www.1212.mn

Насны бүлгээр авч үзэхэд нийт малчдын 34.5 хувь нь 15-34, 55.7 хувь нь 35-59, 9.8 хувь нь 60-аас дээш насныхан байна. Өмнөх оны статистик үзүүлэлтүүдтэй харьцуулахад 15-34 насны малчдын эзлэх хувийн жин жил тутам буурчээ. Тухайлбал, 2017 онд энэ насныхан нийт малчдын 34.5 хувийг эзэлж байгаа нь 1990 оны үзүүлэлтээс 21.1 пунктээр, 2016 оны үзүүлэлтээс 0.3 пунктээр буурчээ. Харин 35-39 насны малчид 1990 онд нийт малчдын 40.3 хувийг эзэлж байсан бол 2017 онд 55.7 хувь болж 15.4 пунктээр, 2016 оноос 0.4 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Ийнхүү залуу малчдын тоо жилээс жилд буурч байгаа нь малчдын залгамж халаа багасах, дунд болон ахмад малчдын тоо өсөх, насжих үйл явц идэвхжиж буйг харуулж байна.

Зураг 2.3. Малчдын хувь, насны бүлгээр, 1990-2017 он




Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, www.1212.mn

Хүйсийн хувьд малчдын дунд эрэгтэйчүүд давамгайлж байна. Тухайлбал, 2017 оны байдлаар нийт малчдын хүйсийн харьцаа 128 (56.1 хувь нь эрэгтэй, 43.9 хувь нь эмэгтэй) буюу 100 малчин эмэгтэйд 128 малчин эрэгтэй ногдож байна. Энэ үзүүлэлт 15-24 насны малчдын дунд 210 (67.7 хувь нь эрэгтэй, 32.3 хувь нь эмэгтэй), 65 ба түүнээс дээш насны малчдад 96 (51.1 хувь нь эмэгтэй, 48.9 хувь нь эрэгтэй) байна. Залуучуудын дундах хүйсийн харьцаа ийм их зөрүүтэй байгаа нь малчдын дундах гэрлэлт буурах, гэрлэлт оройтох, төрөлт буурах, бэлгийн зүй бус харилцаа олшрох, гэрлэлт дагасан шилжилт хөдөлгөөн эрчимжих, цаашлаад малчдын залгамж чанар алдагдах сөрөг нөлөө үзүүлж болзошгүйг анхаарах шаардлагатай юм.

Нас болон хүйсийн харьцааг тодруулбал, эрэгтэй малчдаас 37.1 хувь нь 15-34 насны залуучууд байгаа бол эмэгтэйчүүдийн 31.4 хувийг энэ насныхан эзэлж байна.


Зураг 2.4. Малчдын хувь, насны бүлэг, хүйсээр, 2017 он



Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, www.1212.mn

Малчин өрх. Монгол улсын статистикийн судалгаанд бүртгэлтэй нийт өрхийн дунд малчин өрхийн эзлэх хэмжээ зах зээлд шилжсэн үеэс хойш 1998 оны хүртэл өссөн бол үүнээс хойш 2015 оны хүртэл буурсан. Таван жилийн давтамжийг харвал малчдын эзлэх хэмжээ нийт өрхийн дунд 1995 онд 32.9, 2000 онд 34.6, 2005 онд 27.5, 2010 онд 21.6, 2015 онд хамгийн бага буюу 17.8 хувьд хүрч буурсан бол бол 2017 онд 19.2 хувь болж өссөн.

Зураг 2.1. Малчин өрхийн тоо, нийт өрхөд эзлэх хувиар, 1995-2017 он



Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, www.1212.mn

Нийт өрхийн дунд малчин өрхийн эзлэх хэмжээ 2015 оныг хүртэл буурч доод цэгтээ хүрч энэ үеэс аажмаар өсөх хандлагатай болсон.

Харъяаллын хувьд нийт малчин өрхийн 25.0 хувь нь баруун бүсэд, 40.7 хувь нь хангайн бүсэд, 21.0 хувь нь төвийн бүсэд, 12.1 хувь нь зүүн бүсэд, 1.2 хувь нь Улаанбаатар хотод байна.

Зураг 2.2. Малчин өрхийн тоо, аймгаар, 2017 он



Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, www.1212.mn

Малчдын цаашдын дүр зураг. Сүүлийн жилүүдийн статистик тооноос ажиглахад малчдын тоо буурах хандлагатай байна. Малчдын тооны бууралтыг ажиглахад 2009-2010 оны зудны дараа 22.1 мянгаар, 2011-2012 онд 21.8 мянгаар буурсан. Мөн 2017 онд өмнөх оноос 7.8 мянгаар (2.5 хувь), 2000 оноос 117.8 мянгаар (27.9 хувь) буурсан байна. “Малтусын өсөлтийн загвар” буюу НҮБ-ын хүн амын өсөлтийн тооцооллыг гаргахад ашигладаг аргачлалыг ашиглаж малчдын өсөлт, бууралтыг тооцож үзлээ.

Хэтийн тооцооллыг Хувилбар-I (5 жилийн дундаж), Хувилбар-II (8 жилийн дундаж), Хувилбар-III (10 жилийн дундаж) хувилбараар малчдын тоо, өсөлт, бууралтыг ашиглаж 2035 он хүртэлх тооцоо хийж үзсэн.

Хүснэгт 2.1. Малчдын тооны хэтийн тооцоолол, 2000-2035 он

Он	Малчдын тоо	Абсолют өсөлт		Өсөлтийн хувь		Он	Тооцоо малчид		
		Өмнөх	Суурь	Өмнөх	Суурь		5 жил	8 жил	10 жил
2000	421.4	-	-	-	-	2018	304.8	300.8	298.4
2001	407.0	-14.4	-10.7	-3.4	-2.6	2019	305.9	298.0	293.4
2002	389.8	-17.3	-28	-4.2	-6.7	2020	307.1	295.2	288.4
2003	377.9	-11.8	-39.8	-3.0	-9.5	2021	308.3	292.5	283.5
2004	369.7	-8.2	-48	-2.2	-11.5	2022	309.5	289.7	278.7
2005	364.3	-5.4	-53.5	-1.5	-12.8	2023	310.7	287.0	274.0
2006	364.4	0.1	-53.4	0	-12.8	2024	311.8	284.4	269.3
2007	366.2	1.8	-51.5	0.5	-12.3	2025	313.0	281.7	264.7
2008	360.3	-5.9	-57.5	-1.6	-13.8	2026	314.2	279.1	260.3
2009	349.3	-11	-68.4	-3	-16.4	2027	315.5	276.5	255.8
2010	327.2	-22.1	-90.6	-6.3	-21.7	2028	316.7	273.9	251.5
2011	311.2	-16	-106.6	-4.9	-25.5	2029	317.9	271.4	247.2
2012	289.4	-21.8	-128.3	-7	-30.7	2030	319.1	268.9	243.0
2013	285.7	-3.7	-132.1	-1.3	-31.6	2031	320.3	266.4	238.9
2014	293.6	7.9	-124.1	2.8	-29.7	2032	321.6	263.9	234.9
2015	297.8	4.2	-119.9	1.4	-28.7	2033	322.8	261.4	230.9
2016	311.4	13.5	-106.4	4.5	-25.5	2034	324.0	259.0	227.0
2017	303.6	-7.8	-114.2	-2.5	-27.3	2035	325.3	256.6	223.1

* https://en.wikipedia.org/wiki/Malthusian_growth_model


Тооцооллоос, Хувилбар-I-ээс үзэхэд 2035 онд малчдын тоо 325.3 мянга болж 21.7 мянгаар (7.1 хувь) өсөх хандлагатай байна. Харин хувилбар-II үзэхэд 2035 онд малчдын тоо 256.6 мянга болж 47.0 мянгаар (15.5 хувь) буурах хандлагатай байна. Өөрөөр хэлбэл сүүлийн жилүүдэд малчдын тоо харилцан адилгүй өөрчлөгдөж буйг энэхүү таамаглалын дүнгээс харч болно. Үүнээс үүдэн нийгэм эдийн засагт ямар нөлөө үзүүлэх, бууралтын шалтгаан нь юу вэ, малчдын талаар баримтлаж буй бодлого хөтөлбөр малчдын насны бүтэц, харьцаанд хэрхэн нөлөөлөх вэ гэсэн асуулт урган гарах бөгөөд эдгээрийг тус бүрд нь нарийвчлан судлах шаардлагатай болох нь харагдана.

2.2. Судалгаанд оролцсон малчдын хүн ам зүйн шинж

Судалгаанд нийт 1050 малчин өрхийг хамруулж, судалгааны үр дүнг боловсруулахдаа өрхийн мэдээллийг ашиглалаа.

Өрхийн ам бүлийг тооцож үзвэл нэг өрх дунджаар 3.8 гишүүнтэй (4080 хүн) байгаагаас тэдгээрийн 50.4 хувь нь эрэгтэй, 49.6 хувь нь эмэгтэйчүүд юм. Судалгаанд хамрагдсан иргэдийн насны бүлэг, хүйсийг хүн амын суваргаар харуулав (Зураг 2.7).

Зураг 2.7. Судалгаанд хамрагдсан малчин өрх дэх нийт иргэдийн нас, хүйсийн бүтэц, хувиар




Насны бүлгээр авч үзэхэд судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн 29.3 хувь нь 15 хүртэлх насны хүүхэд, 53.6 хувь нь 15-49 насны иргэд, үлдсэн 17.1 хувь нь ахмад настнууд байна.

2.3. Гэрлэлт, гэр бүлийн байдал


Судалгаанд 15 ба түүнээс дээш насны өрхийн гишүүдийн гэрлэлтийн байдлыг асуусан. Судалгаанд хамрагдсан 15 ба түүнээс дээш насны өрхийн гишүүдийн 57.8 хувь нь батлуулсан, 5.9 хувь нь батлуулаагүй гэр бүлтэй байгаа бол 30.4 хувь нь огт гэрлээгүй байна.

Зураг 2.8. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 15 ба түүнээс насны гишүүдийн гэрлэлтийн байдал




Судалгаанд оролцогчдын гэрлэлтийн байдлыг хүйсээр харахад батлуулсан болон батлуулаагүй хүмүүсийн эзлэх хэмжээ ойролцоо харьцаатай байна. Хүйсийн хувьд огт гэрлээгүй эрэгтэйчүүдийн хэмжээ эмэгтэйчүүдээс их, эмэгтэйчүүдийн дунд бэлбэсэн, өрх толгойлсон эхчүүдийн хэмжээ өндөр байна.

Зураг 2.9. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 15 ба түүнээс насны гишүүдийн гэрлэлтийн байдал, хүйсээр




Насны бүлгээр харвал 24 хүртэлх насанд огт гэрлээгүй залуучуудын тоо өндөр байгаа бол 25-аас дээш насныхны хувьд гэрлэсэн, гэр бүлтэй хүмүүсийн эзлэх хэмжээ өндөр байна.

Зураг 2.10. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүдийн гэрлэлтийн байдал, насны бүлгээр



Өрхийн тэргүүлэгчийн хувьд судлагдсан өрхийн 89.4 хувьд нь эрэгтэйчүүд, 10.6 хувьд нь эмэгтэйчүүд өрх тэргүүлэн амьдарч байна. Өрхийн тэргүүлэгчийг насны бүлэг, хүйсээр зураг 3.24-т харуулав.

Зураг 2.11. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн тэргүүлэгчийн насны бүлэг, хүйсээр, хувиар




Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувь 40-44 насанд тархалт хамгийн өндөр байгаа бол эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувь 45-аас дээш насанд өндөр байна. Энэ нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдээс бага (эрэгтэй 65.88, эмэгтэй 75.44¹⁵), нас баралт өндөр байдагтай холбоотой (эрэгтэйчүүдийн НБК 6.8, эмэгтэйчүүдийн НБК 4.2¹⁶) юм.

Судалгааны үр дүнгээс харахад нэг өрх дунджаар 4 гишүүнтэй (3.88) байна. Өрхийн бүтцийг харвал өрхийн тэргүүн, эхнэр/нөхөр, 2 хүүхдийн хамт амьдарч байна (Зураг 2.12).

¹⁵ YCX, www.1212.mn


¹⁶ YCX, www.1212.mn

Зураг 2.12. Малчин өрхийн гэр бүлийн гишүүдийн ерөнхий бүтэц, харьцаа



Судалгаанд оролцогчдын өрхийн тэргүүний яс үндсийг тодруулахад 75.1 хувь нь халх, 8.2 хувь нь Буриад, 6.2 хувь нь Дарьганга, 2.1 хувь нь Баяд, үлдсэн 8.4 хувь нь Урианхай, Дархад, Цахар, Үзэмчин гэх мэт бусад яс үндэстэй гэж хариулсан байна.

Зураг 2.13. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн тэргүүлэгчийн яс үндэс, хувиар




3. ӨРХИЙН ӨМЧ, ХЭРЭГЛЭЭ

3.1. Сууцны төрөл, хэрэглээ

Сууцны төрөл, хэлбэр. Малчдын улирлын онцлогтой холбоотой сууцны төрлөөс сонгон хэрэглэх хандлагатай болсон нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан малчид: хүйтний улирал(өвөл, хавар)-д 85.9 хувь нь гэрт амьдардаг бол 14.0 хувь нь байшинд, дулааны улирал(зун, намар)-д 87.6 хувь нь гэрт, 11.6 хувь нь байшинд амьдардаг гэжээ.


Зураг 3.1. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн сууцны төрөл, улирлаар



Сууцны өмчлөлийг харвал 98.1 хувь нь өөрийн сууцанд, 1.6 хувь нь бусдын сууцанд түрээсгүй, 0.3 хувь нь бусдын сууцанд түрээстэй суудаг.


Цахилгаан хангамж. Судлагдсан өрхийн 98.1 хувь нь цахилгааны эх үүсвэртэй байгаагаас 60.8 хувь нь нар, салхины сэргээгдэх эрчим хүч, 21.0 хувь нь бага оврын цахилгаан үүсгүүр, 16.2 хувь нь төвлөрсөн систем, 0.2 хувь нь бусад эх үүсвэр ашиглаж байна. Нийт өрхийн 1.9 хувь нь цахилгаан хэрэглэдэггүй гэжээ.

Зураг 3.2. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн цахилгааны эх үүсвэр



Бүс нутгаар үзвэл Баруун болон Хангайн бүсэд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ өндөр (82.9-87.2 хувь) байгаа бол Төвийн болон Зүүн бүсэд бага оврын цахилгаан үүсгүүр (37.3-46.8 хувь), сэргээгдэх эрчим хүчний (39.8-41.2 хувь) хэрэглээ өндөр байна. Харин Улаанбаатар хотын малчдын 60.0 хувь нь эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон байна.

Зураг 3.3. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн цахилгааны эх үүсвэр, бүсээр



Дулааны эх үүсвэр. Түлшний хэрэглээний хувьд судлагдсан малчин өрхийн 98.0 хувь нь ердийн галлагаагаар, 1.2 хувь нь нам даралтын зуухаар сууцаа халаадаг гэж хариулжээ.

Зураг 3.4. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн халаалтын эх үүсвэр




Түлшний хэрэглээний хувьд 63.7 хувь нь сууцаа халаахдаа аргал, хөрзөн, 23.5 хувь нь мод, заг, бургас, үртэс, 10.1 хувь нь нүүрс ашигладаг.

Зураг 3.5. Судалгаанд хамрагдсан сууцаа галгаж халаадаг өрхүүдийн түлшний төрөл



Түлшний хэрэглээ нь амьдарч бүсээс хамааран харилцан адилгүй ба түлшинд нэгдүгээрт аргал хөрзөн, хоёрдугаарт мод, заг, бургас, гуравдугаарт нүүрс ашиглаж байна. Гэхдээ эдгээрийг хэрэглэж буй харьцаа нь бүс бүрт харилцан адилгүй юм.

Зураг 3.6. Сууцаа галлаж халаадаг өрхүүдийн түлшний төрөл, бүсээр



Аргал, хөрзөнг зүүн бүсэд нийт малчдын 87.1 хувь нь, баруун бүсэд 61.2 хувь, хангайн болон төвийн бүсэд 52.2-59.8 хувь нь галлагаанд ашиглаж байгаа бол мод, заг, бургас зэргийг хангайн бүсэд хамгийн их (36.5 хувь), үүний дараа төвийн бүсийн малчдын 32.5 хувь нь, баруун бүсийн малчдын 22.8 хувь нь, Улаанбаатарын малчдын 14.9 хувь нь ашиглаж байна. Харин нүүрсний хэрэглээ Улаанбаатар хотод хамгийн өндөр (51.1 хувь) (Зураг 3.6).

3.2. Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө


Малчдын аж байдал, хэрэглээ сүүлийн жилүүдэд эрчимтэй өөрчлөгдөж, зарим талаар хэрэглээний өөрчлөлт нь тэдний амьдрал аж байдал, хөдөлмөр эрхлэлтэд ч зохих нөлөө үзүүлэх болсон.

Хот болон аймгийн төв гэх мэт төв суурин газарт судалгаанд оролцогчид малчдын 5.3 хувь нь төвлөрсөн халаалтын системд холбогдсон орон сууцтай бол 2.6 хувь нь бие даасан тохилог сууц, 26.2 хувь нь сууцны тусдаа байшинтай, 40.9 хувь нь өмчилсөн газартай гэжээ.

Малчдын хувьд дулаан болон хүйтний улиралд тохирсон бэлчээр, түүнд нийцсэн хашаа хороотой байдаг бөгөөд мал маллахад эдгээрийн үүрэг ач холбогдол өндөр. Өвлийн улиралд дулаан хэвтэр маш чухал байдаг. Судлагдсан малчдын тухайд 67.8 хувь нь өөрийн гэсэн өвөлжөөтэй, 41.3 хувь нь хаваржааны газартай гэжээ.

Техник хэрэгслийн хэрэглээ жил тутам нэмэгдэх болсон. Судалгаанд хамрагдсан нийт малчин өрхийн 84.0 хувь нь ямар нэг механикжсан тээврийн хэрэгсэлтэй гэж хариулсан бөгөөд дөрвөн өрх тутмын нэг (25.8 хувь) нь суудлын машинтай, гурван өрх тутмын нэг (36.6 хувь) нь ачааны машинтай, гурван өрх тутмын хоёр (64.1 хувь) нь мотоциклтой байна.

Зураг 3.7. Малчин өрхийн хөрөнгө



Өрхийн хэрэглээний хувьд хоёр өрх тутмын нэг (55.3 хувь) нь цахилгаан үүсгүүртэй, гурван өрх тутмын нэг (36.3 хувь) нь хөргөгчтэй, 6.5 хувь нь интернет хэрэглэдэг. (Зураг 3.7)

Дээрх өрхийн хөрөнгө, эд зүйлсийг бүсээр харвал өвөлжөө, хаваржааны газартай өрхийн эзлэх хувь Зүүн бүс (харгалзан 76.0 хувь, 45.6 хувь)-д хамгийн өндөр байгаа бол Улаанбаатар хот (харгалзан 36.0 хувь, 14.0 хувь)-д хамгийн бага байна. Харин механикжсан тээврийн хэрэгсэлтэй өрхийн эзлэх хувь Зүүн бүсэд 86.0 хувь, Баруун бүсэд 81.2 хувьтай байгаа нь бусад бүсүүдээс өндөр байна. Интернет хэрэглэдэг малчин өрх, хөргөгчтэй малчин өрхийн хувь Улаанбаатарт бусад бүсүүдээс өндөр байна.

Хүснэгт 3.1. Малчин өрхийн хөрөнгө, эд хөрөнгө, бүсээр

	Орон сууц	Тохилго сууц	Сууцны тусдаа байшин	Өмчилсөн газар	Өвөлжөө	Хаваржаа	Механикжсан тээврийн хэрэгсэл	Суудлын машин	Ачааны машин	Трактор	Мотоцикл	Интернет	Хөргөгч	Цахилгаан үүсгүүр
Баруун	6.0	0.4	21.2	23.2	70.0	54.0	81.2	26.4	33.6	0.8	63.2	4.8	28.4	41.2
Хангайн	6.8	1.6	21.9	39.0	69.7	41.8	77.3	21.5	27.5	0.8	63.3	1.6	20.3	49.4
Төвийн	2.8	7.6	21.7	43.4	61.8	29.3	77.5	25.7	41.0	13.3	61.4	6.0	49.4	46.6
Зүүн	4.8	0.8	37.2	54.4	76.0	45.6	86.0	28.0	41.6	12.8	75.2	9.6	38.0	88.4
Улаанбаатар	10.0	2.0	40.0	58.0	36.0	14.0	68.0	34.0	50.0	10.0	30.0	26.0	82.0	34.0

Малчдын хувьд суурин газар өөрсдийн гэсэн сууц, газартай болох, тэндээ хүүхдүүдээ байлгаж, сургах зэргээр ашиглагдаас гадна үл хөдлөх хөрөнгөтэй болж байгаагаараа сайн талтай.

Механикжсан тээврийн хэрэгслийн тоо өсөн нэмэгдэж байгаа нь ажил төрлөө хурдан хугацаанд бүтээхэд ашигтай боловч үүнийг дагаад техникийн хөдөлгөөнөөс үүдэлтэй хөрс элэгдэх, амь насаа эрсдэлд оруулах зэрэг сөрөг үзэгдлүүд гарах болсоныг анхаарвал зохино. Жишээлбэл, энэ асуудлыг нарийвчлан судлах, улмаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллах нь малчдын амь нас, эд хөрөнгийг хамгаалахад ихээхэн ач холбогдолтой.


Цахилгаан үүсгүүртэй болж энэ хэрээр ахуйн хэрэглээний зүйлийн тоо нэмэгдэж, суурин амьдралтай өрхийн нэгэн адил амьдрах болсон зэрэг нь өнөөгийн хөдөөгийн малчдын нийтлэг дүр төрх болжээ. Тайлангийн эхэнд залуучууд малчны амьдралаас дайжих үйл явц ажиглагдаж буй талаар тэмдэглэсэн. Хэрэглээ, соёлын эд зүйлийг малчид өөрсөддөө бий болгож байгаагийн нэгэн адил төрөөс малчдын нийгмийн харилцааг тэтгэх, соёлын үйлчилгээний хүртээмжийг

сайжруулах тал дээр анхаарвал бэлчээрийн мал аж ахуй эрхлэж буй малчдын залгамж халааг алдагдуулахгүй боломж бий юм.

3.3. Хүнсний хэрэглээ


Хоол хүнсний хэрэглээний бүтцийг тодруулвал гурил (99.6 хувь), цагаан будаа (84.1 хувь)-ны хэрэглээ хамгийн өндөр байгаа бол гоймон (34.4 хувь), гурилан бүтээгдэхүүн (27.7 хувь) хэрэглээ удаалж байна. Мөн судалгаанд хамрагдсан 5 өрх тутмын 4 нь хонины махыг, 3 нь ямааны махыг, 2 нь үхрийн махыг өдөр тутамдаа ихэвчлэн хэрэглэдэг байна.

Зураг 3.8. Мах болон гурилан бүтээгдэхүүний хэрэглээний бүтэц, хувиар




Хүнсний ногооны хувьд төмс, сонгино сармис, лууван, хүнсэнд хэрэглэдэг бусад зүйлсээс элсэн чихэр, ургамлын тос зэрэг бүтээгдэхүүнийг голлох хэрэглээнд тооцож болохоор байна.

Зураг 3.9. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн хүнсний ногоо болон бусад бүтээгдэхүүний хэрэглээний бүтэц, хувиар




Судалгаанд хамрагдсан нийт малчин өрхийн 38.4 хувь нь өдөрт 1 удаа, 42.4 хувь нь өдөрт 2 удаа, 19.0 хувь нь өдөрт 3 удаа, үлдсэн 0.2 хувь нь өдөрт 4 ба түүнээс дээш удаа хооллодог байна.

Зураг 3.10. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн өдрийн дундаж хооллолт, хувиар, байршлаар



Дээрх үзүүлэлтийг бүсээр харвал Хангайн бүсийн малчин өрхүүдийн 32.3 хувь нь өдөрт 3 удаа, 36.7 хувь нь өдөрт 2 удаа, 30.7 хувь нь өдөрт нэг удаа хооллож байгаа бол Төвийн бүсийн малчин өрхүүдийн 8.8 хувь нь өдөрт 3 удаа, 48.2 хувь нь өдөрт 2 удаа, 43.0 хувь нь өдөрт нэг удаа хооллож байна.

Зураг 3.11. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн өдрийн дундаж хооллолт, хувиар, бүсээр




Судалгаанд хамрагдсан 2 өрх тутмын 1 нь хоносон хоолоо өглөө халааж, орой унтахын өмнө махтай хоол хэрэглэдэг гэжээ. Мөн 5 өрхийн тутмын 2 өрх нь өөх тостой хоол байнга хэрэглэдэг байна. Судалгаанд хамрагдсан 10 өрх тутмын 9 нь малд явахдаа хоол унд огт авч явдаггүй гэж хариулсан юм. Малчдын энэхүү судалгаанаас харахад хоол ундны зохистой хэрэглээ, зөв хооллолтын талаар нарийвчилан судлах, мэдээлэл хүргэх, ойлголтыг сайжруулах хэрэгцээ шаардлага өндөр байгааг анхаарах хэрэгтэй юм.

4. ӨРХИЙН АМЬЖИРГАА: ОРЛОГО, ЗАРЛАГЫН БҮТЭЦ

4.1. Өрхийн орлого, зарлагын бүтэц


Өрхийн орлогын бүтэц. Судалгаанд хамрагдсан малчдын өрхийн орлогын бүтцийг тодруулвал, 10.7 хувь нь цалин хөлс, 17.2 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, 66.8 хувь нь мал аж, ахуй, 4.3 хувь өрхийн бизнес эрхлэж, 1.0 хувь нь бусад эх үүсвэрээс орлого олдог гэжээ. Малчин өрхийн хувьд мал, малын гаралтай түүхий эд өрхийн орлого бүрдүүлэхэд голлох нөлөө үзүүлдэг. Гэхдээ энэ нь газар зүйн байршлаас хамааран хэмжээний хувьд харилцан адилгүй байгаа юм. Тухайлбал, нийслэл болон аймagt энэ үзүүлэлт 60.0 орчим хувьтай байхад суманд 42.0 хувьтай буюу суурьшлын ялгаанаас хамаарч буурах үзүүлэлттэй, хөдөөд 70.0 гаруй хувьтай байна. Суурьшлын бүсэд ойр байх тусам малын ашиг шимээс гадна өөр бусад эх үүсвэрээс орлого олох боломж нэмэгддэг.

Зураг 4.1. Малчин өрхийн сарын дундаж орлогын бүтэц, байршлаар




Малчдын орлого бүрдүүлэхэд нөлөөлж буй харьцаа хэмжээг харвал мал аж ахуйн орлого (95.0 хувь), тэтгэмж тэтгэвэр (74.9 хувь), цалин хөлс (16.7 хувь) голлох нөлөө үзүүлж байгаа бол өрхийн бизнес (4.8 хувь), бусад (5.1 хувь) эх үүсвэр 10.0 орчим хувийг эзэлж байна.

Зураг 4.2. Малчин өрхийн орлогын эх үүсвэр, орлогын төрлөөр



Судалгаанд хамрагдсан нийслэлийн малчин өрхийн 90.0 хувь, аймгийн төвийн малчин өрхийн 93.0 хувь, сумын төвийн малчин өрхийн 92.3 хувь, хөдөөгийн малчин өрхийн 96.4 хувь нь мал аж ахуйгаас орлогын цөмийг бүрдүүлдэг. Нийслэл болон сумын төвийн 10 малчин өрх тутмын 3 өрх нь цалин хөлс, 10 өрх тутмын 8 өрх нь тэтгэвэр тэтгэмж гэсэн орлогын эх үүсвэртэй байна. Харин судалгаанд хамрагдсан сумын төвийн 10 малчин өрх тутмын 1 нь өрхийн бизнес эрхлэж байна.

Зураг 4.3. Малчин өрхийн орлогын эх үүсвэр, орлогын төрөл, байршлаар




Орлогын хэмжээ. Малчдын жилийн дундаж орлогыг сард шилжүүлж, зардлыг мөн адил зарчмаар тооцож гаргасан. Судалгаанд хамрагдсан нийт малчдын сарын дундаж орлого 959.0 мянган төгрөг байгаа бол нийслэлийн малчид 1 197.7 мянган төгрөг, аймгийн малчид 1 210.7 мянган төгрөг, сумын төвийн малчид 924.8 мянган төгрөг, хөдөөний малчид 874.6 мянган төгрөгийн орлоготой байна. Цалин хөлс авч өрхийн орлогыг бүрдүүлдэг хүмүүс сард 616.5 мянган төгрөг, тэтгэвэр, тэтгэмжийн орлоготой өрх 219.8 мянган төгрөг, мал, малын гаралтай түүхий эдээр орлого бүрдүүлдэг өрх 673.8 мянган төгрөг, бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг өрх 874.7 мянган төгрөг, бусад эх үүсвэртэй өрх 182.2 мянган төгрөгийн орлого олдог гэжээ.

Хүснэгт 4.1. Малчин өрхийн сарын дундаж орлого, байршил, мянган төгрөг

Байршил	Цалин хөлс	Тэтгэвэр, тэтгэмж	Мал аж ахуйн орлого	Өрхийн бизнес	Бусад	Дундаж орлого
Нийслэл	560.4	335.0	825.1	325.0	300.0	1 197.7
Аймгийн төв	980.6	286.8	791.7	1 587.1	148.5	1 210.7
Сумын төв	733.5	250.8	429.0	373.6	230.8	924.8
Хөдөө	447.7	189.0	666.0	781.7	167.3	874.6
Нийт	616.4	219.8	673.8	874.7	182.2	959.0

Судалгаанд хамрагдсан нийт малчдын 14.5 хувь нь 300000 төгрөг хүртэл, 22.4 хувь нь 300001-500000 төгрөг, 17.0 хувь нь 500001-700000 төгрөг, 14.2 хувь нь 700001-900000 төгрөг, 9.3 хувь нь 900001-1100000 төгрөг, 9.8 хувь нь 1100001-1600000 төгрөг, 5.4 хувь нь 1600001-2100000 төгрөг, 7.3 хувь нь 2100001 төгрөгнөөс дээш орлоготой бол нийт өрхийн 68.0 хувь нь сард дунджаар 900001 төгрөгнөөс бага орлоготой байна.


Зураг 4.4. Малчин өрхийн сарын дундаж орлогын бүлэглэлт



Судалгаанд хамрагдсан нийслэлийн 2 өрх тутмын 1 нь сард дунджаар 900000 төгрөгнөөс доош орлоготой байгаа бол энэ үзүүлэлтэд аймгийн төв болон сумын төвийн малчдаас 5 өрх

тутмын 3 нь, хөдөөний 10 өрх тутмын 7 нь өрх хамрагдаж байна. Хөдөөнөөс хамрагдсан 2 өрх тутмын 1 нь сард дунджаар 700000 төгрөгөөс доош орлоготой байна.


Зураг 4.5. Малчин өрхийн сарын дундаж орлогын бүлэглэлт, байршлаар



Судалгаанд хамрагдсан өрхийн орлогыг малын тоотой харьцуулж харахын тулд малын тоог бог буюу хонин толгойд (**1 үхэр = 6 хонь, 1 адуу = 7 хонь, 1 тэмээ = 5 хонь, 1 ямаа = 0.9 хонь**) шилжүүлсэн.

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 31.9 хувь нь 201-500, 23.9 хувь нь 501-999, 15.2 хувь нь 1000-2000, 13.5 хувь нь 101-200, 11.3 хувь нь 0-100, 4.1 хувь нь 2001-ээс дээш бог буюу хонин толгойд шилжүүлсэн малтай байна.

Зураг 4.6. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн малын тоог богд шилжүүлэн тооцсон хувь




Судалгаанд хамрагдсан 200-аас доош толгой малтай 2 өрх тутмын 1 нь сард дунджаар 500000 төгрөгний орлоготой байна. Харин 201-500 малтай 2 өрх тутмын 1 нь сард дунджаар 300000-700000 төгрөгний орлоготой өрх байна. 1000-2000 малтай 2 өрх тутмын 1 нь сард дунджаар 900000 төгрөгнөөс дээш орлоготой байна.

Хүснэгт 4.2. Малчин өрхийн сарын дундаж орлогын бүлэг, хонин толгойд шилжүүлсэн малын тоогоор

Орлогын бүлэг	Хонин толгойд шилжүүлсэн малын тоо						Малгүй
	0-99	100-200	201-500	501-999	1000-2000	2001-с дээш	
300 000 төгрөг хүртэл	27.4	27.3	12.2	9.5	8.2	2.3	60.0
300 001-500 000	30.1	25.9	31.3	16.7	9.4	2.3	20.0
500 001 - 700 000	13.3	20.3	19.1	19.0	11.9	7.0	0.0
700 001 - 900 000	9.7	9.8	14.6	19.8	13.2	7.0	20.0
900 001 - 1 100 000	11.5	3.5	7.8	11.1	11.9	16.3	0.0
1 100 001 - 1 600 000	1.8	4.9	7.8	13.9	17.6	11.6	0.0
1 600 001 - 2 100 000	2.7	6.3	1.8	5.2	12.6	14.0	0.0
2 100 001 төгрөгнөөс дээш	3.5	2.1	5.1	4.8	15.1	39.5	0.0
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Судалгаанд хамрагдсан 100-аас доош малтай өрх сард дунджаар 624.1 мянга, 101-аас 200 малтай өрх сард дунджаар 714.0 мянга, 201-ээс 500 малтай өрх сард дунджаар 842.4 мянга, 501-ээс 999 малтай өрх сард дунджаар 938.7 мянга, 1000-2000 малтай өрх сард дунджаар 1248.7 мянган төгрөгний орлоготой байгаа бол 2001-ээс дээш малтай өрх сард дунджаар 2651.4 мянган төгрөгний орлоготой байна.

Зураг 4.7. Малчин өрхийн сарын дундаж орлого, хонин толгойд шилжүүлсэн малын тооны бүлгээр, мянган төгрөг



Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 94.0 хувь нь уламжлалт (бэлчээрийн), 2.7 хувь нь фермерийн аж ахуй эрхлэж байгаа бол 3.3 хувь нь уламжлалт болон фермерийн аж ахуйг хослуулан эрхлэж байна. Уламжлалт аргаар мал малладаг өрхийн сарын дундаж орлого 924.8 мянган төгрөг, фермерийн мал аж ахуй эрхэлдэг өрхийн сарын дундаж орлого 1 309.5 мянган төгрөг, уламжлалт болон фермер хосолсон аж ахуй эрхэлдэг өрхийн сарын дундаж орлого 1 643.2 мянган төгрөг байна.


Зураг 4.8. Малчин өрхийн сарын дундаж орлого, МАА-н арга хэлбэрээр



МАА арга хэлбэрээс шалтгаалаад өрхийн орлого өөр байхаас гадна орлогын бүтэц ялгаатай байна. Уламжлалт аргаар мал малладаг өрхийн орлогын 67.3 хувийг МАА орлого, 17.3 хувийг тэтгэвэр, тэтгэмж, 9.8 хувийг цалин хөлс, 4.5 хувийг өрхийн бизнес, 1.0 хувийг бусад


орлого эзэлж байгаа бол фермерийн мал а ахуй эрхэлдэг өрхийн орлогын 40.1 хувийг МАА орлого, 37.4 хувийг цалин хөлс, 19.1 хувийг тэтгэвэр тэтгэмж, 2.6 хувийг өрхийн бизнес, 0.8 хувийг бусад орлого эзэлж байна.

Зураг 4.9. Малчин өрхийн сарын дундаж орлогын бүтэц, МАА-н арга хэлбэрээр



Зарлагын тооцоо. Судалгаанд хамрагдсан малчдын өрхийн сарын дундаж зарлагын бүтцийг харвал нийт зардлын 14.8 хувийг хүнсэнд, 13.1 хувийг гэр ахуйн бараа, хувцас хэрэглэл худалдаж авахад, 4.3 хувийг сургалтын төлбөрт, 18.2 хувийг малын тэжээлд, 1.7 хувийг шатахуунд, 11.0 хувийг түлээ, түлшинд, 3.4 хувийг харилцаа холбоонд, 6.1 хувийг боловсролд, 5.7 хувийг эрүүл мэндийн үйлчилгээнд, 17.4 хувийг зээлийн төлбөрт, 2.2 хувийг туслах ажилтны цалинд, 1.0 хувийг цахилгаан, ус дулааны төлбөрт, үлдсэн 1.1 хувийг бусад зүйлд зарцуулсан байна.

Зураг 4.10. Малчин өрхийн сарын дундаж зарлага, бүцтээр



Судалгаанд хамрагдсан нийт өрх сард дунджаар 1 227.0 мянган төгрөг зарцуулдаг. Суурьшлын бүсээр зарлагын хэмжээ өөрчлөгдөж байгаа бөгөөд нийслэлийн өрхийн дундаж зардал 1 721.7 мянган төгрөг, аймагт 1 473.0 мянган төгрөг, суманд 1 247.0 мянган төгрөг, хөдөөний өрх 1117.4 мянган төгрөг зарцуулж байна. Өрхийн зардлын хэмжээг зарцуулалтын төрлөөр нь харьцуулж харвал хүнсэнд 182.7 мянган төгрөг, цахилгаан ус, дулааны төлбөрт 50.3 мянган төгрөг, гэр ахуйн бараа, хувцас хэрэглэл худалдаж авахад 170.9 мянган төгрөг, сургалтын төлбөрт 283.5 мянган төгрөг, малын тэжээлд 248.3 мянган төгрөг, шатахуунд 52.5 мянган төгрөг, түлээ, түлшинд 158.6 мянган төгрөг, харилцаа холбоонд 43.0 мянган төгрөг, боловсролд 146.5 мянган төгрөг, эрүүл мэндийн үйлчилгээнд 101.0 мянган төгрөг, зээлийн төлбөрт 408.0 мянган төгрөг, туслах ажилтны цалинд 292.9 мянган төгрөг, бусад зардалд 94.4 мянган төгрөг сард дунджаар зарлагддаг гэж хариулжээ.


Хүснэгт 4.3. Малчин өрхийн сарын дундаж зарлагын төрөл, байршлаар, мянган төгрөгөөр

Байршил	Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	Дундаж
Хүнсний зардал	227.3	193.2	162.7	179.5	182.7
Цахилгаан, ус дулааны төлбөр	34.4	59.4	39.6	57.7	50.3
Гэр ахуйн бараа, хувцас гутал	140.3	194.7	186.7	163.9	170.9
Сургалтын төлбөр	282.6	250.7	391.5	283.0	283.5
Малын тэжээл	521.7	340.9	221.5	204.8	248.3
Шатахуун	52.3	71.3	73.5	40.4	52.5
Түлш (түлээ нүүрс г.м)	198.3	183.8	121.1	154.2	158.6
Харилцаа холбоо	60.6	68.3	42.8	34.4	43.0
Боловсролын зардал	258.2	187.3	160.6	127.7	146.5
Эрүүл мэндийн үйлчилгээний зардал	141.2	104.9	139.2	91.3	101.0
Зээлийн төлбөр	455.4	471.3	385.1	390.0	408.0
Туслах ажилтны цалин	1 059.8	349.4	184.8	237.9	292.9
Бусад	42.3	117.8	143.7	82.5	94.4
Дундаж зардал	1 721.7	1 473.0	1 247.0	1 117.4	1 227.0

* Тухайн зардал нь өрхүүдийн дундаж зардал


Судалгаанд хамрагдсан нийт өрхийн сарын дундаж зарлагын хэмжээг бүлэглэж харвал 7.8 хувь нь 300001 төгрөг хүртэл, 15.9 хувь нь 300001-500000, 13.9 хувь нь 500001-700000, 14.6 хувь нь 700001-900000, 9.9 хувь нь 900001-1100000, 16.7 хувь нь 1100001-1600000, 9.0 хувь нь 1600001-2100000, 12.3 хувь нь 2100001 төгрөгнөөс дээш зарлага гаргаж байна. Нийт өрхийн 47.8 хувь нь сард дунджаар 900001 төгрөгнөөс дээш зардал гаргадаг.

Зураг 4.11. Малчин өрхийн сарын дундаж зарлагын бүлэглэлт



Суурьшлын хувьд нийслэлийн 10 малчин өрх тутмын 7 нь, аймгийн төвд 2 малчин өрх тутмын 1 нь, сумын төв болон хөдөөд 5 малчин өрх тутмын 2 нь сард дунджаар 900000 төгрөгнөөс дээш зардал гаргаж байна.

Зураг 4.12. Малчин өрхийн сарын дундаж зарлагын бүлэглэлт, байршлаар




Нийт малын хэмжээг богд шилжүүлсэн үр дүнгээс харахад 100-аас доош малтай 2 өрх тутмын 1 нь сард дунджаар 700000 төгрөгнөөс дээш зардал гаргаж байна.

Хүснэгт 4.4. Малчин өрхийн сарын дундаж орлогын бүлэг, хонин толгойд шилжүүлсэн малын тоогоор

Зардлын бүлэг	Хонин толгойд шилжүүлсэн малын тоо					2001-с дээш
	0-100	101-200	201-500	501-999	1000-2000	
300 000 төгрөг хүртэл	13.4	11.3	9.2	6.0	3.1	0.0
300 001-500 000	18.5	19.7	15.8	15.9	14.5	2.3
500 001 - 700 000	16.0	12.0	15.5	14.7	10.7	9.3
700 001 - 900 000	11.8	14.1	16.1	13.1	13.2	25.6
900 001 - 1 100 000	10.1	7.7	8.9	10.8	15.1	0.0
1 100 001 - 1 600 000	10.9	20.4	16.4	16.7	14.5	27.9
1 600 001 - 2 100 000	10.9	4.9	6.8	8.8	13.8	14.0
2 100 001 төгрөгнөөс дээш	8.4	9.9	11.3	13.9	15.1	20.9
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0


Бог малд шилжүүлсэн үр дүнгээр өрхийн зардлыг дундажлан харвал 100-аас доош тооны малтай өрх сард дунджаар 1 029.6 мянга, 101-аас 200 толгой малтай өрх 1 207.3 мянган, 201-ээс 500 толгой малтай өрх дунджаар 1 190.1 мянган, 501-ээс 999 толгой малтай өрх дунджаар 1 290.8 мянган төгрөгний дундаж зардал гаргаж байна.

Зураг 4.13. Малчин өрхийн сарын дундаж зарлага, хонин толгойд шилжүүлсэн малын тоогоор




Мал маллагааны арга хэлбэрээр ялган харвал бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг өрхийн сарын дундаж зардал 1 198.1 мянган төгрөг, фермерийн мал аж ахуй эрхэлдэг өрхийн сарын дундаж зардал 1 876.5 мянган төгрөг, уламжлалт болон фермер хосолсон аж ахуй эрхэлдэг өрхийн сарын дундаж зардал 1 832.3 мянган төгрөг байна.

Зураг 4.14. Малчин өрхийн сарын дундаж зарлага, МАА арга хэлбэрээр



Мал маллагааны арга хэлбэрээс шалтгаалаад өрхийн зарлагын бүтэц ялгаатай байна. Жишээ нь: Уламжлалт аргаар мал малладаг өрхийн зарлагын 17.4 хувийг малын тэжээлд зарцуулдаг бол фермерийн мал аж ахуй эрхэлдэг өрхийн зардлын 31.1 хувийг малын тэжээл эзэлж байна.

Зураг 4.15. Малчин өрхийн сарын дундаж зарлагын бүтэц, МАА-н арга хэлбэрээр



4.2. Өрхийн орлогод мал, малын гаралтай түүхий эдийн эзлэх хэмжээ

Сум, суурин газрын ойр буй малчид сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулж ашгийг нь хүртэх боломж харьцангуй өндөр байдаг бол хөдөөний малчид өөрсдийн хэрэгцээнд, мөн өвлийн хүнсийг бэлтгэх, хэрэгцээнээс илүү гарсан боловсруулсан бүтээгдэхүүнийг зарж борлуулдаг. Бэлчээрийн маллагаа бүхий малын сүүний гарц өвлийн улиралд багасч, татардаг онцлогтой. Малын бусад түүхий эдийн гарц мөн улирлаас хамаардаг онцлогтой бөгөөд сүүний хувьд зун, намрын улиралд элбэг байдаг бол ноос, ноолуур хаврын улиралд, арьс шир идэш идэх үеэр элбэгшдэг. Малын түүхий эдээс олж буй орлого тогтмол бус бөгөөд зах зээл дэх түүхий эдийн үнэ ханшнаас шууд хамааралтай.


ҮСХ-ны мэдээллээс үзэхэд, 2018 оны эхний 6 сарын дунджаар үхрийн шир 18902 төгрөг (2 метрээс дээш, доош урттай үхрийн ширний дундаж үнэ), адууны шир 13462 төгрөг, хонины нэхий 2 535 төгрөг (ноостой, ноосгүй нэхийний дундаж үнэ), ямааны арьс 17081 төгрөг (ноолууртай, ноолуургүй арьсны дундаж үнэ) ханштай байсан бол хонины ноос 3086 төгрөг, ямааны ноолуур 79980 төгрөг (цагаан, бор ноолуурын дундаж үнэ), тэмээний ноос 10920 төгрөг (эр, эм тэмээний ноосны дундаж үнэ), сарлагийн хөөвөр 8000 төгрөгийн ханштай байна. Ноос, ноолуурын үнэ хамгийн өндөр байсан үеийг үзэхэд, хонины ноос 2018 оны 2 дугаар сард 4000 төгрөг, ямааны ноолуур 2018 оны 4 дүгээр сард 92174 төгрөг, тэмээний ноос 2018 оны 6 дугаар сард 10920 төгрөг, сарлагийн хөөвөр 2018 оны 1 дүгээр сард 13 000 хүрч байсан байна¹⁷.

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 89.5 хувь нь ноос, ноолуураас, 87.1 хувь нь арьс, ширнээс, 31.7 хувь нь сүүнээс, 2.2 хувь нь сүүн бусад бүтээгдэхүүнийг зарж ашиг шимийг нь

¹⁷ ҮСХ, Гол нэрийн зарим барааны дундаж үнэ, <http://1212.mn>

хүртдэг байна. Мөн нийт өрхийн 55.0 хувь мал зарж, 24.6 хувь нь мал махалж ашиг шимийг нь хүртсэн байна.

Зураг 4.16. Нийт малчин өрхийн малын түүхий эдээс хүртэж буй ашиг шим



Нийслэлээс судалгаанд хамрагдсан малчдын хувьд ноос, ноолуур (26.0 хувь), арьс, шир (72.0 хувь), сүү (90.0 хувь), мал зарж (36.0 хувь), мал махалж (10.0 хувь) борлуулах байдлаар ашиг шимийг нь хүртдэг бөгөөд малын түүхий эдээс өрхийн орлого бүрдүүлэхэд сүү голлох нөлөө үзүүлж байна. Сумын төв болон хөдөөнөөс судалгаанд хамрагдсан 10 өрх тутмын 9 нь ноос, ноолуураас, 10 өрх тутмын 8 нь арьс ширнээс, 2 өрх тутмын 1 нь малаа зарж ашиг шим хүртэж байна.

Хүснэгт 4.5. Малаасаа ашиг хүртдэг малчин өрхийн хувь, байршлаар

Байршил	Ноос, ноолуур	Арьс, ширнээс	Сүү	Бусад бүтээгдэхүүн	Мал зарж	Мал махалж
Нийслэл	26.0	72.0	90.0	0.0	36.0	10.0
Аймгийн төв	78.1	84.1	38.8	2.5	45.3	26.9
Сумын төв	95.2	87.5	18.3	5.8	51.9	16.3
Хөдөө	96.5	89.1	27.5	1.7	59.7	26.2
Нийт	89.5	87.1	31.7	2.2	55.0	24.6

Аймгийн төвийн малчин өрхүүдийн 78.1 хувь нь ноос, ноолуураас ашиг шим хүртдэг гэж хариулсан бөгөөд дунджаар 4908.4 мянган төгрөгийн орлого олсон байна. Харин сумын төвийн малчин өрхүүдийн 95.2 хувь нь ноос, ноолуураас ашиг шим хүртдэг хэдий ч дунджаар 2526.3 мянган төгрөгийн орлого олсон байна.

Хүснэгт 4.6. Малчин өрхийн малаас хүртэж буй дундаж орлого, байршлаар

Байршил	Ноос, ноолуур	Арьс, ширнээс	Сүү	Мал зарж	Мал махалж
Нийслэл	806.1	142.7	1 051.1	15 944.4	4 416.4
Аймгийн төв	4 908.4	555.3	764.3	5 660.5	7 635.7
Сумын төв	2 526.3	299.6	573.7	3 142.6	5 881.3
Хөдөө	4 870.9	418.3	1 013.0	4 330.0	4 806.5
Нийт	4 574.0	421.0	934.8	4 790.2	5 461.9

Ноос, ноолуураас ашиг шим хүртсэн нийт малчин өрхийн 97.2 хувь нь ямааны ноолуур, 81.7 хувь нь хонины ноос, 2.9 хувь нь тэмээний ноос, 2.2 хувь нь үхрийн хөөвөр, 36.4 хувь нь адууны дэл, сүүл борлуулж, ашиг шимийг нь хүртсэн байна.

Хүснэгт 4.7. Ноос, ноолуурын ашиг шим

Байршил	Ямааны ноолуур	Хонины ноос	Тэмээний ноос	Үхрийн хөөвөр	Адууны дэл, сүүл
Нийслэл	46.2	23.1	0.0	0.0	69.2
Аймгийн төв	96.2	73.9	3.2	0.0	30.6
Сумын төв	97.0	72.7	1.0	7.1	17.2
Хөдөө	98.5	86.0	3.1	2.1	39.9
Нийт	97.2	81.7	2.9	2.2	36.4

Сүүлийн жилд ноос, ноолуур, дэл, сүүлнээс дунджаар 4574.0 мянган төгрөгний орлого олж байгаа. Ноолуураас 4430.9 мянган төгрөг, хонины ноосоос 262.9 мянган төгрөг, тэмээний ноосоос 425.2 мянган төгрөг, үхрийн хөөврөөс 76.2 мянган төгрөг, адууны дэл, сүүлнээс 101.6 мянган төгрөг олж байна.

Нэг өрх дунджаар 45.1 кг ямааны ноолуурыг 99550 төгрөг, 207.7 кг хонины ноосыг 1250 төгрөг, 59.7 кг тэмээний ноосыг 6340 төгрөг, 9.0 кг үхрийн хөөврийг 8330 төгрөг, 12.9 кг адууны дэл, сүүлийг 7016 төгрөгөөр борлуулсан байна.

Хүснэгт 4.8. Малчин өрхийн ноос, ноолуураас олж буй дундаж орлого, төрөл, байршлаар

Байршил	Дундаж	Нийт	Үүнээс:				
			Ямааны ноолуур	Хонины ноос	Тэмээний ноос	Үхрийн хөөвөр	Адууны дэл, сүүл
Нийслэл	Орлого, мян.төг	806.1	1 417.7	276.7	-	-	127.1
	Кг		15.3	136.7	-	-	15.9
	Үнэ		93 500.0	2 333.3	-	-	8 011.1
Аймгийн төв	Орлого, мян.төг	4 908.4	4 774.3	339.6	301.5	-	183.3
	Кг		49.4	218.9	52.0	-	20.4
	Үнэ		97 043.0	1 448.7	8 100.0	-	7 754.9
Сумын төв	Орлого, мян.төг	2 526.3	2 488.4	116.5	600.0	86.9	95.0
	Кг		25.4	107.7	120.0	11.3	13.1
	Үнэ		97 479.2	1 210.4	5 000.0	7 571.4	6 882.4
Хөдөө	Орлого, мян.төг	4 870.9	4 661.9	265.7	446.3	70.9	86.5
	Кг		47.3	218.2	58.7	7.8	11.4
	Үнэ		100 487.9	1 210.6	6 000.0	8 714.3	6 858.9
Дундаж	Орлого, мян.төг	4 574.0	4 430.9	262.9	425.2	76.2	101.6
	Кг		45.1	207.7	59.7	9.0	12.9
	Үнэ		99 556.9	1 250.8	6 339.3	8 333.3	7 016.2

Арьс, шир борлуулсан нийт өрхийн 80.3 хувь нь ямааны арьс, 78.3 хувь нь хонины нэхий, 1.0 хувь нь тэмээний шир, 67.2 хувь нь үхрийн шир, 34.4 хувь нь адууны шир борлуулж ашиг шимийг нь хүртсэн байна.

Хүснэгт 4.9. Арьс, ширний ашиг шим

Байршил	Ямааны арьс	Хонины нэхий	Тэмээний шир	Үхрийн шир	Адууны шир
Нийслэл	8.3	13.9	0.0	97.2	13.9
Аймгийн төв	70.4	66.9	1.2	65.7	25.4
Сумын төв	78.0	81.3	0.0	61.5	26.4
Хөдөө	87.6	84.7	1.1	66.7	39.3
Нийт	80.3	78.3	1.0	67.2	34.4

Нэг өрх арьс, ширнээс жилд дунджаар 421.0 мянган төгрөгний орлого олж байгаагаас ямааны арьс 379.2 мянган төгрөг, хонины нэхий 56.4 мянган төгрөг, тэмээний шир 30.7 мянган төгрөг, үхрийн шир 82.9 мянган төгрөг, адууны шир 47.1 мянган төгрөг олж байна.

Борлуулж буй арьс ширний тоо хэмжээ, үнийн дүнг харвал нэг өрх сүүлийн жилд дунджаар 18.8 ширхэг ямааны арьс 19560 төгрөг, 20.0 ширхэг хонины нэхийг 2960 төгрөг, 1.7 ширхэг тэмээний ширийг 20080 төгрөг, 3.4 ширхэг үхрийн ширийг 23370 төгрөг, 2.3 ширхэг адууны ширийг 21380 төгрөгөөр борлуулсан байна.

Хүснэгт 4.10. Малчин өрхийн арьс, ширнээс олж буй дундаж орлого, арьс, ширний төрөл, байршлаар

Байршил	Дундаж	Нийт	Үүнээс:				
			Ямааны арьс	Хонины нэхий	Тэмээний шир	Үхрийн шир	Адууны шир
Нийслэл	Орлого, мян.төг	142.7	248.7	68.8	0.0	105.9	68.0
	Ширхэг		12.3	16.4	0.0	4.4	4.0
	Үнэ		19 333.3	2 900.0	0.0	23 685.7	22 000.0
Аймгийн төв	Орлого, мян.төг	555.3	567.9	67.9	22.5	142.2	64.3
	Ширхэг		25.5	24.9	1.0	5.8	3.1
	Үнэ		20 848.7	3 292.0	22 500.0	25 108.1	22 297.7
Сумын төв	Орлого, мян.төг	299.6	273.3	32.7	0.0	70.8	61.3
	Ширхэг		14.2	13.1	0.0	2.9	2.5
	Үнэ		19 119.7	2 673.1	0.0	22 223.2	21 416.7
Хөдөө	Орлого, мян.төг	418.3	352.3	57.2	33.1	66.6	42.2
	Ширхэг		17.9	19.9	1.9	2.8	2.1
	Үнэ		19 340.4	2 932.3	19 400.0	23 037.5	21 203.7
Дундаж	Орлого, мян.төг	421.0	379.2	56.4	30.7	82.9	47.1
	Ширхэг		18.8	20.0	1.7	3.4	2.3
	Үнэ		19 563.3	2 962.0	20 088.9	23 374.0	21 381.9

Сүү борлуулсан нийт өрхийн 15.9 хувь нь бог малын сүү, 0.6 хувь нь ингэний сүү, 91.0 хувь нь үхрийн сүү, 6.3 хувь нь гүүний саам зарж ашиг шимийг нь хүртсэн байна.

Хүснэгт 4.11. Малаас сүү, сүүн бүтээгдэхүүний ашиг шим хүртдэг малчин өрхийн хувь, төрөл, байршлаар

Байршил	Бог малын сүү	Ингэний сүү	Үнээний сүү	Гүүний сүү
Нийслэл	0.0	0.0	97.8	4.4
Аймгийн төв	14.1	0.0	93.6	3.8
Сумын төв	5.3	5.3	84.2	5.3
Хөдөө	21.5	0.5	89.0	7.9
Нийт	15.9	0.6	91.0	6.3

Сүү борлуулсан өрх сүүлийн жилд дунджаар 934.8 мянган төгрөгний орлого олсоноос бог малын сүүнээс 534.3 мянган төгрөг, ингэний сүүнээс 255.0 мянган төгрөг, үнээний сүүнээс 878.6 мянган төгрөг, гүүний саамнаас 773.0 мянган төгрөг олжээ.

Сүү борлуулсан өрх сүүлийн жилд дунджаар 1 045.0 литр бог малын сүүг 1058.6 төгрөг, 352.5 литр ингэний сүүг 3000 төгрөг, 1036.5 литр үнээний сүүг 796.4 төгрөг, 1 742.9 литр гүүний саамыг 1523.8 төгрөгөөр борлуулсан байна.

Хүснэгт 4.12. Малчин өрхийн сүү, сүүн бүтээгдэхүүнээс олж буй дундаж орлого, сүүний төрөл, байршлаар

Байршил	Дундаж	Нийт	Үүнээс:			
			Бог малын сүү	Ингэний сүү	Үнээний сүү	Гүүний сүү
Нийслэл	Орлого, мян.төг	1 051.1	-	-	965.9	2 400.0
	Литр		-	-	1 268.2	1 575.0
	Үнэ		-	-	787.0	1 750.0
Аймгийн төв	Орлого, мян.төг	764.3	290.0	-	721.4	1 253.3
	Литр		1 095.4	1 000.0	961.1	2 328.6
	Үнэ		772.7	-	-	0.0
Сумын төв	Орлого, мян.төг	573.7	120.0	10.0	663.8	150.0
	Литр		618.3	10.0	825.2	2 137.5
	Үнэ		800.0	1 000.0	800.0	3 000.0
Хөдөө	Орлого, мян.төг	1 013.0	609.9	500.0	943.8	501.6
	Литр		1069.1	200.0	1040.3	1618.6
	Үнэ		1 141.5	5 000.0	806.8	1 433.3
Дундаж	Орлого, мян.төг	934.8	534.3	255.0	878.6	773.0
	Литр		1 045.0	352.5	1 036.5	1 742.9
	Үнэ		1 058.5	3 000.0	796.4	1 523.8

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 2.2 хувь нь бусад бүтээгдэхүүн (ааруул чихэртэй/чихэргүй, эззгий, айраг, хоормог, өндөг, өрөм, тараг, аарц гэх мэт) борлуулж ашиг шим хүртсэн байна. Бусад бүтээгдэхүүнээс жилд дундажаар 748.6 мянган төгрөг олж байна.

Хүснэгт 4.13. Бусад бүтээгдэхүүн борлуулсан ашиг, байршлаар

Байршил	Нийт өрхөд эзлэх хувь	Дундаж орлого (мян.төг)
Нийслэл	-	-
Аймгийн төв	2.5	1 411.2
Сумын төв	5.8	869.2
Хөдөө	1.7	412.3
Нийт	2.2	748.6

Мал зарсан нийт өрхийн 46.9 хувь нь үхэр, 27.5 хувь нь адуу, 2.2 хувь нь хурдан морь, 1.0 хувь нь тэмээ, 69.0 хувь нь хонь, 59.0 хувь нь ямаа зарж ашиг шимийг нь хүртсэн байна.

Хүснэгт 4.14. Мал зарж ашиг шим хүртсэн малчин өрхийн хувь, төрөл, байршлаар

Байршил	Үхэр	Адуу	Үүнээс:	Тэмээ	Хонь	Ямаа
			Хурдан морь			
Нийслэл	77.8	27.8	0.0	0.0	11.1	5.6
Аймгийн төв	48.4	24.2	6.6	1.1	49.5	40.7
Сумын төв	46.3	20.4	3.7	0.0	72.2	64.8
Хөдөө	45.3	29.2	1.2	1.2	75.4	64.6
Нийт	46.9	27.5	2.2	1.0	69.0	59.0

Мал зарж борлуулсан өрх сүүлийн жилд дундажаар 4790.2 мянган төгрөгний орлого олсон ба үхэр борлуулж 3 199.5 мянган төгрөг, адуу борлуулж 2 527.3 мянган төгрөг, хурдан морь борлуулж 11 938.5 мянган төгрөг, тэмээ борлуулж 1 833.3 мянган төгрөг, хонь борлуулж 2 289.7 мянган төгрөг, ямаа борлуулж 1 231.8 мянган төгрөг олжээ.

Мал зарж борлуулсан өрх сүүлийн жилд дунджаар 7.1 үхрийг 639.6 мянган төгрөг, 4.4 адууг 486.8 мянган төгрөг, 5.8 хурдан морийг 2 407.7 мянган төгрөг, 3.3 тэмээг 591.7 мянган төгрөг, 33.1 хонийг 70.3 мянган төгрөг, 25.6 ямааг 49.9 мянган төгрөгөөр борлуулсан байна.

Хүснэгт 4.15. Малчин өрхийн мал зарж олсон дундаж орлого, малын төрөл, байршлаар

Байршил	Дундаж	Дундаж	Үүнээс:					
			Үхэр	Адуу	Үүнээс: Хурдан морь	Тэмээ	Хонь	Ямаа
Нийслэл	Орлого, мян.төг Ширхэг Үнэ	15 944.4	17 721.4	6 760.0	-	-	2 250.0	600.0
			7.1	10.6	-	-	45.0	20.0
			1 967 857.1	640 000.0	-	-	50 000.0	45 000.0
Аймгийн төв	Орлого, мян.төг Ширхэг Үнэ	5 660.5	2 183.8	6 015.9	22 766.7	1 600.0	2 073.0	1 491.5
			20.9	5.8	10.8	2.0	28.1	30.5
			586 670.5	616 666.7	2 716 666.7	800 000.0	74 777.8	53 108.1
Сумын төв	Орлого, мян.төг Ширхэг Үнэ	3 142.6	2 484.0	1 200.0	3 500.0	-	1 517.6	806.1
			4.4	2.3	1.0		23.3	15.9
			538 000.0	472 727.3	3 500 000.0		66 153.8	51 028.6
Хөдөө	Орлого, мян.төг Ширхэг Үнэ	4 330.0	2 451.0	1 838.8	2 320.0	1 880.0	2 417.3	1 254.0
			4.2	4.1	1.6	3.6	35.0	26.1
			566 585.1	456 544.7	1 600 000.0	550 000.0	70 247.6	49 453.5
Дундаж	Орлого, мян.төг Ширхэг Үнэ	4 790.2	3 199.5	2 527.3	11 938.5	1 833.3	2 289.7	1 231.8
			7.1	4.4	5.8	3.3	33.1	25.5
			639 599.6	486 840.5	692.3	591 666.7	70 256.9	49 953.2

Мал махалж зарсан нийт малчин өрхийн 44.2 хувь нь үхэр, 22.9 хувь нь адуу, 0.4 хувь нь тэмээ, 64.0 хувь нь хонь, 50.4 хувь нь ямаа махалж ашиг шимийг нь хүртсэн байна.

Хүснэгт 4.16. Мал махалж зарж ашиг шим хүртсэн малчин өрхийн хувь, төрөл, байршлаар

Байршил	Үхэр	Адуу	Тэмээ	Хонь	Ямаа
Нийслэл	80.0	20.0	0.0	0.0	0.0
Аймгийн төв	53.7	25.9	0.0	55.6	55.6
Сумын төв	41.2	35.3	0.0	52.9	58.8
Хөдөө	40.7	20.9	0.5	69.2	49.5
Нийт	44.2	22.9	0.4	64.0	50.4

Малын мах борлуулсан өрх жилд дунджаар 5 461.9 мянган төгрөгний орлого олж байгаагаас үхэр (4 527.9 мянган төгрөг), хонь (3 395.4 мянган төгрөг), адуу (2 299.1 мянган төгрөг) голлож тэмээ (1 100.0 мянган төгрөг), ямаа (1 507.7 мянган төгрөг)-ны мах борлуулсан орлого харьцангуй бага хэмжээтэй байна.

Жилд дунджаар 1 062.0 кг үхрийн махыг 4 127.1 төгрөг, 602.9 кг адууны махыг 3 667.8 төгрөг, 500 кг тэмээний махыг 2 200 төгрөг, 828.9 кг хонийн махыг 5 453.6 төгрөг, 572.6 кг ямааны махыг 3 565.8 мянган төгрөгөөр борлуулсан байна.

Хүснэгт 4.17. Малчин өрхийн мал махалж зарж олсон дундаж орлого, малын төрөл, байршлаар


Байршил	Дундаж	Нийт	Үүнээс:				
			Үхэр	Адуу	Тэмээ	Хонь	Ямаа
Нийслэл	Орлого, мян.төг	4 416.4	2 520.5	12 000.0	-	-	-
	Кг		847.5	2 000.0	-	-	-
	Үнэ		3 025.0	6 000.0	-	-	-
Аймгийн төв	Орлого, мян.төг	7 635.7	7 033.3	1 910.5	-	4 083.2	1 970.7
	Кг		1 668.4	519.1	-	1 194.2	806.0
	Үнэ		4 039.7	3 628.6	-	5 790.0	2 530.0
Сумын төв	Орлого, мян.төг	5 881.3	7 725.0	3 274.6	-	1 440.1	1 329.8
	Кг		1 348.0	792.5	-	314.7	447.1
	Үнэ		5 000.0	4 000.0	-	8 500.0	5 360.0
Хөдөө	Орлого, мян.төг	4 806.5	3 352.1	2 033.0	1 100.0	3 371.3	1 373.1
	Кг		805.1	567.2	500.0	782.7	508.8
	Үнэ		4 138.4	3 568.4	2 200.0	5 156.0	3 711.7
Дундаж	Орлого, мян.төг	5 461.9	4 527.9	2 299.1	1 100.0	3 395.4	1 507.7
	Кг		1062.0	602.9	500.0	828.9	572.6
	Үнэ		4 127.1	3 667.8	2 200.0	5 453.6	3 565.8

Малын гаралтай түүхий эдээс орлого бүрдүүлэхэд малчдын дийлэнх хэсэг нь ноос, ноолуураа зах зээлд борлуулж ашгийг нь хүртдэг бол 55 хувь нь малаа амьдаар нь зарж ашгийг нь хүртдэг бөгөөд цаг үеийн нөхцөл байдал, улирал, аж байдлын онцлогоос хамаардаг учир байнгын орлого гэж үзэх боломжгүй. Сүү нь бусад түүхий эдтэй харьцуулахад харьцангуй тогтвортой гарц бүхий түүхий эдэд тооцогдох хэдий ч байршил, маллагааны төрлөөс хамааран хоёр өрх тутмын зөвхөн нь нэг нь орлого олох зорилгоор ашиглаж байгаа нь чамлалттай үзүүлэлт юм.

4.3. Зээлтэй малчин

ҮСХ-ны эх сурвалжаас харахад 2017 оны байдлаар нийт малчдын 55.8 хувь нь зээлтэй байна. Зээлтэй малчдыг насны бүлгээр авч үзэхэд 4.8 хувь нь 15-24 насны, 23.4 хувь нь 25-34 насны, 32.0 хувь нь 35-44 насны, 23.2 хувь нь 45-54 насны, 12.2 хувь нь 55-64 насны, 4.3 хувь нь 65 ба түүнээс дээш насны малчид байгаа юм.


Зураг 4.17. Зээлтэй малчдын хувь, насны бүлгээр, 2017 он



Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, www.1212.mn

Манай судалгаанд хамрагдсан нийт өрхийн 54.6 хувь нь зээлтэй байлаа. Нийслэл болон сумын төвөөс хамрагдсан 5 өрх тутмын 3 нь, аймгийн төв болон хөдөөний 2 өрх тутмын 1 нь зээлтэй байлаа.

Зураг 4.18. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүд, зээлтэй эсэх, байршлаар



Зээлтэй өрхийн 97.0 хувь нь арилжааны банкнаас, 0.3 хувь нь банк бус санхүүгийн байгууллагаас, 1.7 хувь нь хадгаламж зээлийн хоршооноос, 2.6 хувь нь хувь хүнээс, 2.3 хувь нь төрийн байгууллагаас, 2.4 хувь нь бусад байгууллагаас зээл авсан байна.

Арилжааны банкнаас зээл авсан өрх дунджаар 18.2 сарын хугацаатай 5.7 сая төгрөг, банк бус санхүүгийн байгууллагаас зээл авсан зээл авсан өрх 11.4 сарын хугацаатай 2.1 сая төгрөг, хадгаламж зээлийн хоршооноос зээл авсан өрх 7.3 сарын хугацаатай 1.2 сая төгрөг, хувь хүнээс зээл авсан өрх 4.5 сарын хугацаатай 0.9 сая төгрөг, төрийн байгууллагаас зээл авсан өрх, 34.3 сарын төлөх хугацаатай 6.7 сая төгрөг, бусад байгууллагаас зээл авсан өрх 17.6 сарын төлөх хугацаатай 1.8 сая төгрөгийн зээл авсан байна.

Хүснэгт 4.18. Зээлтэй малчин өрхүүд, зээлийн эх үүсвэр, зээлийн хэмжээ, хугацаа, байршлаар

Байршил	Дундаж	Арилжааны банк	ББСБ	ХЗХ	Хувь хүн	Төрийн байгууллага	Бусад
Нийт зээлд эзлэх хувь		97.0	0.3	1.7	2.6	2.3	2.4
Нийслэл	Хэмжээ, мян.төг	9 075.2	1 200.0	0.0	0.0	0.0	0.0
	Хугацаа, сараар	24.5		2.0			20.0
Аймгийн төв	Хэмжээ, мян.төг	7 753.1	3 000.0	0.0	675.0	11 250.0	1 712.5
	Хугацаа, сараар	23.0		10.0	5.8	43.2	21.5
Сумын төв	Хэмжээ, мян.төг	4 489.1	0.0	1 164.0	520.0	4 666.7	1 135.0
	Хугацаа, сараар	18.5	10.8		6.0	24.0	19.2
Хөдөө	Хэмжээ, мян.төг	4 993.8	0.0	1 350.0	1 061.4	4 666.7	2 083.8
	Хугацаа, сараар	16.3	12.0		3.6	32.0	15.0
Дундаж	Хэмжээ, мян.төг	5 667.1	2 100.0	1 257.0	886.2	6 692.3	1 842.1
	Хугацаа, сараар	18.2	11.4	7.3	4.5	34.3	17.6


Зээл авсан нийт өрхийн 49.2 хувь нь ахуйн хэрэглээнд, 18.8 хувь нь оюутны сургалтын төлбөрт, 18.7 хувь нь автомашин худалдан авахад, 13.4 хувь нь хадлан тариа бэлтгэх, малын тэжээл худалдан авахад, 10.8 хувь нь өрөө дарах зориулалтаар тус тус зээл авсан байна. Мөн хүүхэддээ гэр барьж өгөх (5.4 хувь), хашаа байшин авах (4.7 хувь), эрүүл мэндийн үйлчилгээнд (3.8 хувь), тоног төхөөрөмж авахад (2.4 хувь), бизнесийн зээл (2.3 хувь), ипотекийн зээлийн (1.8 хувь) зориулалтаар тус тус зээл авсан байна.

Зураг 4.19. Зээлийн зориулалт, хувиар




100-аас доош малтай малчин өрхийн 50.4 хувь нь зээлтэй бөгөөд дунжаар 4393.6 мянган төгрөгийн зээлтэй байгаа бол 101-500 малтай малчин өрхүүдийн 57.1-57.7 хувь нь зээлтэй бөгөөд 4649.1-4838.9 мянган төгрөгний зээлтэй байна. 2000-аас дээш малтай өрхүүдийн 39.5 хувь нь зээлтэй бөгөөд зээлийн дундаж хэмжээ 9564.7 мянган төгрөг байна.

Зураг 4.20. Зээлтэй өрхийн эзлэх хувь, зээлийн дундаж хэмжээ, малын тоогоор



Зээл авсан малчин өрхүүдийг сарын дундаж орлогоор нь харвал 300 хүртэлх мянган төгрөгний орлоготой малчин өрхүүдийн 46.7 хувь нь зээлтэй бөгөөд дундаж зээлийн хэмжээ 3941.8 мянган төгрөг байна. Өрхийн орлогод зээлтэй өрхийн хувь болон зээлийн хэмжээ нь эерэг хамааралтай байна.


Зураг 4.21. Зээлтэй өрхийн эзлэх хувь, өрхийн орлогын бүлэглэлтээр



4.4. Малчдын амьжиргаа

Амьжиргааны түвшний өөрчлөлт, шалтгаан. Судалгаанд хамрагдсан малчдын олонх буюу 65.7 хувь нь өөрсдийн амьжиргааны түвшнийг өөрчлөгдөөгүй, 25.7 хувь нь бага зэрэг сайжирсан, 0.9 хувь нь ихээхэн сайжирсан гэж хариулсан бол 7.3 хувь нь баг зэрэг дордсон, 0.3 хувь нь ихээхэн дордсон, 0.1 хувь нь мэдэхгүй гэжээ.

Зураг 4.22. Малчин өрхийн амьжиргаа сайжирсан эсэх, хувиар



Малчдын хэрэгцээ. Судалгаанд хамрагдсан өрхөөс санхүү мөнгөний хувьд хамгийн их хэрэгцээтэй байгаа 3 зүйлийг нь тодруулахад 3 өрх тутмын 1 нь малын тоо толгойг нэмэгдүүлэх, 26.9 хувь нь орлогоо нэмэгдүүлэх, 20.5 хувь нь гэр сууцаа тохижуулж, сайжруулах, 15.9 хувь нь эмчлүүлж сувилуулах хэрэгцээ байна гэжээ.

Зураг 4.23. Малчин өрхүүдэд чухал хэрэгцээтэй байгаа зүйлс, хувиар




Зээлийн зориулалтыг илэрхийлсэн үзүүлэлт хийгээд хэрэгцээг илэрхийлсэн мэдээллээс харахад малчид амьжиргаагаа тэтгэх, дээшлүүлэхэд чиглэсэн зээл төдийлөн авдаггүй болох нь харагдаж байна.

5. МАЛЧДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ: ОНЦЛОГ, БЭРХШЭЭЛ

5.1. Хөдөлмөрийн онцлог, хөдөлмөрийн хуваарь

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүдийн 74.1 хувь нь хөдөлмөр эрхлэдэг бол 25.9 хувь нь одоогоор хөдөлмөр эрхлээгүй байна.


Зураг 5.1. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлт, хүйсээр



Хөдөлмөр эрхлэлийг хүйсээр авч үзвэл 15 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн 80 хувь, эмэгтэйчүүдийн 68.2 хувь нь хөдөлмөр эрхлэж байна.


Насны бүлгээр үзвэл 15-19 насны гишүүдийн 87.3 хувь нь, 20-24 насны 49 хувь нь одоогоор хөдөлмөр эрхлээгүй гэж хариулсан бол 40-44 насны гишүүдийн 94.3 хувь нь, 45-49 насны гишүүдийн 98.0 хувь нь хөдөлмөр эрхлэдэг гэж хариулсан байна. Харин 65 ба түүнээс дээш насны малчдын 38.2 хувь нь хөдөлмөр эрхлээгүй байна.

Зураг 5.2. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлт, насны бүлгээр




Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг хэлбэрээр авч үзвэл 87.0 хувь нь мал аж ахуйн салбарт, 11.2 хувь нь цалинтай ажил, 1.2 хувь нь өрхийн бизнес, 0.6 хувь нь цалин хөлсгүй ажил эрхлэдэг бол судалгаанд хамрагдсан малчин өрхүүдэд ажил олгогч, хувиараа газар тариалан эрхэлдэг гишүүн байхгүй байна.

Зураг 5.3. Малчин өрхийн хөдөлмөр эрхлэж буй гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр, хувиар




Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харвал цалин хөлстэй ажил эрхлэж буй хүмүүс сум суурин (26.9 хувь), нийслэл (16.0 хувь), аймгийн төв (13.4 хувь)-д харьцангуй өндөр байгаа бол хөдөөгийн малчдын 90.5 хувь нь, аймгийн малчдын 84.5 хувь нь, нийслэлийн малчдын 80.0 хувь нь зөвхөн мал малладаг, цалин хөлстэй ажил эрхэлдэггүй гэжээ.

Зураг 5.4. Малчин өрхийн хөдөлмөр эрхлэж буй гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр, хувиар, байршлаар




Цалин хөлстэй хөдөлмөр эрхлэж буй гишүүдийг насны бүлгээр харьцуулан харахад нас ахих тусам эзлэх хэмжээ нь буурч байгаа бол МAA салбарт ажиллаж байгаа гишүүдийн эзлэх хэмжээ нас ахих тусам нэмэгдэж байна. 15-19 насныхны 14.9 хувь нь, 20-24 насныхны 26.6 хувь нь, 25-29 насныхны 25.7 хувь нь цалин хөлстэй хөдөлмөр эрхлэж байгаа бол энэ насныхнаас МAA салбарт ажиллаж буй залуучуудын эзлэх хэмжээ 80.9, 69.6, 73.3 гэсэн харьцаатай байна.

Зураг 5.5. Малчин өрхийн хөдөлмөр эрхлэж буй гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр, насны бүлгээр



Мал маллах арга туршлагын хувьд дунджаар 19.2 жилийн туршлагатай байна. Малчдын дунд нас ахих тусам туршлага нэмэгдэж байгаа нь дараах үр дүнгээс харагдана.

Зураг 5.6. Малчдын мал малласан жил, насны бүлгээр




Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүдийн эдийн засгийн идэвхгүй байгаа шалтгааныг тодруулахад 59.5 хувь нь оюутан/сурагч, 13.9 хувь нь тэтгэвэрт, 11.8 хувь нь өөрийн хүүхэд болон бусдыг асарсан, жирэмсэн, 6.6 хувь нь тохирох ажил олдохгүй, 3.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй гэж хариулсан бол 1.6 өвчтэй, 1.2 хувь нь түр зогсолт, улирлын чанартай ажил хийдэг, 2.0 хувь нь бусад шалтгаанаар одоогоор хөдөлмөр эрхлээгүй байна.

Зураг 5.7. Эдийн засгийн идэвхгүй байгаа шалтгаан




Судалгаанд хамрагдсан малчин өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлээгүй гол шалтгаануудыг насны бүлгээр харьцуулан харахад 15-24 насныхны 74.0-96.3 хувь нь суралцдаг, 50-аас дээш насанд 45.5-92.3 хувь нь тэтгэвэрт гарсан, 25-49 насанд 22.2-71.4 хувь нь өөрийн хүүхэд болон бусдыг асардаг/жирэмсэн хүмүүс эзлэж байна.

Зураг 5.8. Эдийн засгийн идэвхгүй байгаа голлох шалтгаан, насны бүлгээр



Малчдын 88.8 хувь нь өдөрт 9-өөс дээш цагийг МАА-н хөдөлмөрт зарцуулдаг ба нэг өдөрт зарцуулж буй хугацааг нарийвчлан тооцож үзвэл 46.2 хувь нь 9-12 цаг, 24.5 хувь нь 13-16 цаг, 18.1 хувь нь 17 ба түүнээс дээш цаг, 8.0 хувь нь 5-8 цаг, 3.2 хувь нь хамгийн бага буюу 0-4 цаг зарцуулдаг. Энэ үзүүлэлтийг байршлаар авч үзэхэд аймгийн төвийн малчдын 56.2 хувь нь 9-12 цаг, нийслэлийн малчдын 34.0 хувь нь 5-8 цаг, хөдөөгийн малчдын 29.1 хувь нь 13-16 цаг, сумын төвийн малчдын 27.9 хувь нь 17 түүнээс дээш цаг зарцуулдаг гэжээ.


Зураг 5.9. Малчин өрхийн МАА-д өдөрт зарцуулж буй цаг, байршлаар



Судалгаанд хамрагдан малчдын зүгээс “зуншлага оройтож өвс ногооны гарц муу, бороо ус орохгүй гол горих ширгэж хатах нь элбэгшиж, зуны эхэн сар гарсан ч мал тогтохгүй хаврын хүнд хэцүү цагтай ижил өглөө 4.30 босож, орой ихэвчлэн 21-22 цагийн үед амардаг. Олон цаг малаа дагаж, шөнө зарим үед мал тогтохгүй гүйж, нойргүй хонох үе гардаг” гэсэн нь малчдын хөдөлмөрийн онцлогийг илэрхийлнэ.

Туслах малчинтай малчдын хувьд МАА-н хөдөлмөрт зарцуулах цаг харьцангуй бага байдаг. Туслах малчинтай малчдын 16.9 хувь нь 0-4 цаг зарцуулдаг гэсэн нь дээрх үзүүлтээс 13.7 функтээр, 9-12 цаг зарцуулдаг малчдаас 4.7 функтээр, 13-16 цаг зарцуулдаг малчдаас 2.5 функтээр, 17 ба түүнээс дээш цаг зарцуулдаг малчдаас 6.6 функтээр бага цаг зарцуулдаг.

Зураг 5.10. Малчин өрхийн МАА-д өдөрт зарцуулж буй цаг, үндсэн болон туслах малчин




5.2. Малчдын ахуйн хүрээн дэх хөдөлмөр

МАА-н салбарт хөдөлмөр эрхлэж буй малчдын дийлэнх нь мал хариулах, услах, ноос, ноолуур самнах, хяргах, хашаа хороо барих, нутаг сэлгэж нүүх, оторлох, мал зарж борлуулах,

өвлийн бэлтгэл хангах зэрэг ажлыг хийдэг. Үйл ажиллагааны төрлөөр харвал 3 малчин тутмын 2 нь мал саах, нэмэлт тэжээл авах, тарих, цагаан идээ боловсруулах ажлыг хийдэг бол 2 малчин тутмын 1 нь арьс шир боловсруулах, сүү цагаан идээ зарж борлуулах ажлыг хийдэг байна.

Зураг 5.11. МАА салбарт хөдөлмөр эрхлэж буй малчдын хувь, ахуйн хүрээн дэх хөдөлмөр эрхлэлтээр, хүйсээр




Малчдын хөдөлмөр эрхлэлтийг хүйсээр харвал мал саах, цагаан идээ боловсруулах ажилд эмэгтэйчүүдийн оролцоо эрэгтэйчүүдийнхээс бараг 2 дахин өндөр байгаа бол бусад ажилд эрэгтэйчүүдийн оролцоо өндөр байна.

Арьс шир боловсруулж бүтээгдэхүүн хийх ажил багасаж дийлэнх малчид зарж борлуулдаг болжээ. Зарим малчид *“малын түүхий эдээр өөрсдийн хэрэгцээнд зориулж ганц нэг хэрэглэл хийдэг, хийх шаардлагагүй бол ялангуяа зуны улиралд арьс шир зарж борлуулахад үнэ хүрдэггүй хаядаг”* гэжээ.


МАА салбарт хөдөлмөр эрхлэж байгаа малчдын ахуйн хүрээн дэх хөдөлмөр эрхлэлтийг насны бүлгээр харахад 15-19 насныхан бүгд буюу 100.0 хувь мал услах, 97.3 хувь нь мал хариулах, 91.9 хувь нь хашаа хороо барих ажлыг хамгийн их хийдэг бол 29.7 хувь нь цагаан идээ боловсруулах, 21.6 хувь нь цагаан идээ зарж борлуулах, 27.0 хувь нь арьс шир боловсруулах, 24.3 хувь нь мал зарж борлуулах ажлыг хийж гүйцэтгэдэг. Эндээс 15-19 насныхан шийдвэр гаргах түвшний ажилд харьцангуй бага оролцож, ахуйн хүрээн дэх хөдөлмөрт идэвхтэй оролцдог гэж болохоор байна. 20-64 насны малчдын хувьд нийт хандлагатай ижил байна. Харин 65-аас дээш насныхан нэмэлт тэжээл бэлдэх (71.4 хувь), мал зарж борлуулах (86.7 хувь) ажлыг голлон хийдэг бол мал саах (61.9 хувь), нутаг сэлгэж нүүх (74.3 хувь), оторлох (68.6 хувь), хашаа хороо барих (78.1 хувь), ноос ноолуур самнах (69.5 хувь) арьс шир боловсруулах (40.0 хувь) ажилд харьцангуй бага цаг зарцуулдаг аж.

Зураг 5.12. МАА салбарт хөдөлмөр эрхлэж буй малчдын хувь, ахуйн хүрээн дэх хөдөлмөр эрхлэлтээр, насны бүлгээр



Малчин өрхийн гишүүдийн хөдөлмөрийн хуваарийг байршлаар авч үзэхэд нийслэлд арьс шир боловсруулах (21.8 хувь), ноос ноолуур самнах (37.9 хувь), нутаг сэлгэх (52.9 хувь), оторлох (48.3 хувь), хашаа хороо барих, сэлгэх (62.1 хувь), цагаан идээ боловсруулах (58.6 хувь) ажлыг харьцангуй бага хувьтай хийж гүйцэтгэдэг бол цагаан идээ зарж борлуулах (82.8 хувь), мал саах (80.5 хувь) ажлыг их хийдэг. Нийслэлийн ойр мал аж ахуй эрхэлдэг малчдын хувьд 42.0 хувь нь фермерийн аж ахуй, 28.0 хувь нь уламжлалт болон фермеийн МАА хослуулан эрхэлдэг, мөн ихэвчлэн бод малладаг учир отор нүүдэл бага хийж, ноос ноолуур самнаж арьс шир боловсруулаад байдаггүй. Харин дээр тэмдэглэсэнчлэн сүү сааль бэлтгэх, боловсруулах ажил харьцангуй өндөр хувьтай байна.

Зураг 5.13. МАА салбарт хөдөлмөр эрхлэж буй малчдын хувь, ахуйн хүрээн дэх хөдөлмөр эрхлэлтээр, байршлаар




Малчин өрхийн ахуйн хүрээн дэх хөдөлмөр эрхлэлтийг бүсээр авч үзэхэд зүүн бүсийн малчдын 40.3 хувь нь өвлийн бэлгэл хангах, 21.3 хувь нь нэмэлт тэжээл тарих ажлыг бусад бүсээс хамгийн бага, цагаан идээ зарж борлуулах нь бага байна.

Зүүн бүсийн Сүхбаатар аймгаас судалгаанд хамрагдсан малчдын тухайд “өвс ногоо бага ургадаг хадлан хадах талбай огт байдаггүй, малчид ихэнхдээ гаднаас хадлан худалдаж авдаг. Мөн өвс ногоо бага ургадаг тул бага төлтэй малыг тэр бүр саадаггүй” гэжээ.

Баруун бүсийн хувьд бусад бүстэй харьцуулахад мал хариулах (95.7 хувь), услах (94.5 хувь), нутаг сэлгэх (93.3 хувь), оторлох (92.6 хувь), хашаа хороо барих (91.9 хувь), өвлийн бэлтгэл хийх (91.2 хувь), нэмэлт тэжээл тарих, ноос ноолуур самнах (94.3 хувь), арьс шир борлуулах (90.5 хувь), мал зарж борлуулах (96.4 хувь) ажлыг бусад бүстэй харьцуулахад харьцангуй их хийдэг бол төвийн бүсийн малчдын хувьд мал саах (59.4 хувь), цагаан идээ боловсруулах (55.9 хувь),

арьс шир борлуулах (39.1 хувь), мал зарж борлуулах (67.6 хувь) ажлыг бусад бүстэй харьцуулахад харьцангуй бага хувьтай хийдэг.

Зураг 5.14. МАА салбарт хөдөлмөр эрхлэж буй малчдын хувь, ахуйн хүрэн дэх хөдөлмөр эрхлэлтээр, бүсээр




5.3. Мал маллаж буй арга, хэлбэр, түүнд гарч буй өөрчлөлт

Манай улсад мал маллах аргын хувьд бэлчээрийн мал аж ахуй болон фермерийн буюу эрчимжсэн мал аж ахуй гэсэн үндсэн 2 хэлбэр байдаг. Үндэсний статистикийн хорооны 2017 оны мал тооллогын дүнгээр эрчимжсэн мал аж ахуй эрхлэж байгаа иргэн, өрхийн тоо 3182, аж ахуй нэгж нь 108 байгаа нь нийт малчин өрхийн 1.9 хувийг эзэлж байна.¹⁸

Судалгаанд хамрагдсан малчдын мал маллаж буй арга хэлбэрийг нь тодруулахад 94.0 хувь нь уламжлалт, 2.7 хувь нь фермер, 3.3 хувь нь бэлчээрийн болон суурин маллагааны арга хосолсон аргаар мал малладаг ба байршлаар нь харвал нийслэлд мал маллаж буй малчдын 42.0 хувь нь фермер, 30.0 хувь нь уламжлалт, 28.0 хувь нь бэлчээрийн болон суурин маллагааны арга хосолсон хосолсон мал аж ахуйг эрхлэж байгаа бол аймгийн төвд мал маллаж буй малчдын 91.5 хувь нь уламжлалт, 3.0 хувь нь фермер, 5.5 хувь нь бэлчээрийн болон суурин маллагааны арга хосолсон аргаар МАА эрхлэж байна. Сумын төвд мал маллаж буй малчдын 91.5 хувь нь уламжлалт, 1.0 хувь нь фермер, 4.8 хувь нь бэлчээрийн болон суурин маллагааны арга хосолсон аргаар МАА эрхлэж байгаа бол хөдөөд мал маллаж буй малчдын 99.3 хувь нь уламжлалт, 0.7 хувь нь бэлчээрийн болон суурин маллагааны арга хосолсон аж ахуй эрхэлдэг гэжээ.

Зураг 5.15. Малчдын мал маллаж буй арга хэлбэр, байршлаар




Малчдын эрхлэж буй фермерийн чиглэлийг байршлаар авч үзэхэд нийслэлээс судалгаанд хамрагдсан 2 малчин тутмын 1 нь сүүний үхрийн фермер, 10 хувь нь мах, сүүний фермерийн аж ахуйг хослуулан эрхлэж байна. Аймгийн төвийн малчдын 2.5 хувь нь сүүний үнээний фермерийн аж ахуй эрхлэж байна.

¹⁸ ҮСХ, Мал тооллогын 2017 оны урьдчилсан дүн

Нийслэл, аймгийн төв суурин газрын малчид фермерийн МАА эрхлэх сонирхолтой байдаг бол хөдөө амьдарч буй малчид фермерийн аж ахуй хөгжүүлэх боломжгүй зах зээл байхгүй тиймээс уламжлалт МАА эдийн засгийн хувьд хэмнэлттэй гэж хэлж байсан.

Судалгаанд хамрагдсан малчдаас уламжлалт МАА болон фермерийн МАА-н алийг нь хөгжүүлбэл малчид болон Монгол улсын эрх ашигт хамгийн сайн нийцэх талаар тодруулахад 46.2 хувь нь уламжлалт МАА, 25.9 хувь нь уламжлалт болон фермерийн МАА, 12.1 хувь нь фермерийн МАА, 15.8 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.


Зураг 5.16. МАА-н салбарыг хөгжүүлэх хэлбэр



Дээрх үзүүлэлтийг насны бүлгээр тодруулан харахад 20-24 насныхан хамгийн өндөр, 68.2 хувь нь уламжлалт аж ахуй хөгжүүлэх нь Монгол улсад илүү үр дүнтэй гэж үзсэн. Харин 60-64 насныхан харьцангуй бага буюу 36.8 хувь нь уламжлалт аж ахуй хөгжүүлэх нь, 35.3 хувь нь уламжлалт болон фермерийн МАА хослуулан хөгжүүлбэл илүү нийцтэй гэж үзжээ.

Бүсээр тодруулахад, зүүн бүсийн 55.2 хувь нь уламжлалт аж ахуйг хөгжүүлбэл үр дүнтэй гэж хариулсан бол Улаанбаатараас судалгаанд хамрагдсан малчдын 42.0 хувь нь уламжлалт болон фермерийн аж ахуйг хослуулах, 38.0 хувь нь фермерийн аж ахуйг хөгжүүлбэл илүү нийцтэй гэж хариулсан байна.

Зураг 5.17. Малчдын хувь, цаашид ямар хэлбэрийн МАА хөгжүүлэх нь хэрэгтэй эсэхээр, насны бүлэг, бүсээр




Малчдын дийлэнх нь уламжлалт аж ахуй хөгжүүлэх нь үр дүнтэй гэж үзэж байгаа ч одоогийн маллаж буй арга хэлбэртэй харьцуулан харахад нийслэлийн малчдын 30 хувь нь уламжлалт арга хэлбэрээр малаа маллаж байгаа бөгөөд уламжлалт МАА-г хөгжүүлбэл зохистой гэж үзсэн нь 12.0 хувь болж 18.0 функтээр буурсан байна. Харин уламжлалт болон фермерийн аж ахуй хослуулан хөгжүүлбэл нийцнэ гэж үзсэн нь одоогийн мал маллаж буй арга хэлбэрээс 22.0-29.8 функтээр өссөн байна. Фермерийн аж ахуйг хөгжүүлбэл нийцтэй гэж үзсэн нь 4.8-8.9 функтээр өссөн байна. Мөн судалгаанд хамрагдсан малчдын 15.8 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бөгөөд үүний шалтгаан нь:

- Фермерийн МАА эрхлэж үзээгүй арга туршлага бага, хар ухаанаар бодоход зардал ихтэй
- Фермерийн аж ахуй эрхлэх нь өвлийн улиралд малын хорогдол багатай ч мал тааваараа тарга хүчээ авахгүй малын шим тэжээл буурах
- Фермерийн аж ахуй эрхлэж буй малчдын ажлын ачаалал ихтэй байдаг байх гэж тайлбарлаж байна.

Судалгаанд оролцсон малчдын дийлэнх нь бэлчээрийн болон суурин маллагаа бүхий мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх нь үр дүнтэй гэж үзэж байгаа нь дээрх үр дүнгээс харагдаж байна.


Зураг 5.18. МАА-н салбарыг хөгжүүлэх хэлбэр



5.4. Мал маллахад тулгарч буй бэрхшээл

Мал маллахад тулгарч буй бэрхшээлийг тодруулахад судалгаанд оролцогчдын 95.8 хувь нь ган гачиг, 90.3 хувь нь зуд турхан, 90.4 хувь нь бэлчээрийн хомсдол, 80.9 хувь нь гол горих булаг шанд хатах ширгэх, усны хомсдол үүсдэг гэж хариулсан бөгөөд үүний шалтгааныг цөлжилт, бэлчээрийн доройтол, даац хэтэрч байгаатай холбон тайлбарлаж байна. Мөн 2 малчин тутмын нэг нь буюу 51.9 хувь нь малын хулгай, 51.3 хувь нь араатан амьтан (чоно, үнэг, дорго) гэж хариулсан бол 21.0 хувь нь түймэр, 30.0 хувь нь үер усны аюул, 21.0 хувь нь малаа хулгайд алдах эрсдэл их байдаг гэжээ.

Зураг 5.19. Малчид мал маллахад тулгарч буй хүндрэл бэрхшээл




Мал маллахад тулгардаг хүндрэл бэрхшээлийг бүсээр харвал Улаанбаатарт ган гачиг (100 хувь), бэлчээрийн хомсдол (100 хувь), гол горих булаг шанд ширгэх (92 хувь), бороо усны аюул (72 хувь), малын хулгай (74.0 хувь) зэрэг бэрхшээл өндөр байдаг гэжээ. Гал түймрийн аюул

харьцангуй бага байгаа ч энэ эрсдэл зүүн бүсэд харьцангуй их (34.4 хувь) тохиолддог. Харин ган гачиг (91.2 хувь), зуд турхан (79 хувь), бэлчээрийн хомсдол (74.4 хувь), малын өвчин (40.0 хувь), бороо усны аюул (10.4 хувь), малын хулгай (26.8 хувь), өмчийн хулгай (2.8 хувь) зэрэг эрсдэл зүүн бүсэд харьцангуй бага тохиолддог гэж болохоор байна.


Баруун бүсийн хувьд зуд (97.2 хувь), араатан амьтан мал барих (73.2 хувь) эрсдэл бусад бүстэй харьцуулахад харьцангуй өндөр байгаа бол төвийн бүсэд малын өвчин (68.7 хувь), өмчийн хулгай (51.4 хувь) бусад бүстэй харьцуулахад харьцангуй их гардаг гэжээ.

Зураг 5.20. Малчид мал маллахад тулгарч буй хүндрэл бэрхшээл, бүсээр



Дээрх бэрхшээлийг даван туулж буй аргыг тодруулахад 42.1 хувь нь огт арга хэмжээ авч чадаагүй, 57.9 хувь нь эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх ямар нэгэн арга хэмжээ авдаг аж. Эрсдлээс хамгаалж буй арга, хэлбэр нь эрсдлийн онцлогоос шалтгаалж байна. Тухайлбал, зуднаас сэргийлж малдаа нэмэгдэл тэжээл, эрдэс бодис авах (41.6 хувь), ган гачигтай үед малаа оторлуулах (34.3 хувь), хүйтний үеийн хорогдлоос сэргийлж хашаа саравч барьж, сайжруулах (7.2 хувь) арга хэмжээ авсан бол 5.9 хувь нь малаа зарсан байна.


Зураг 5.21. Малчид мал маллахад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг даван туулж буй хувь



Малчдын 51.9 хувь малаа хулгайд алдаж байсан ч 7.8 хувь нь цагдаагийн байгууллагад хандсан байна. Малчид “Хулгайд алдсан мал ихэвчлэн олддоггүй, цагдаагийн байгууллагад мэдэгдээд ямарч нэмэргүй, үр дүн гардаггүй” гэж онцолж байлаа.

Мал маллах явцад ямар нэгэн торгууль, төлбөрт орж байсан эсэхийг тодруулахад 94.3 хувь нь торгууль, төлбөр төлж байгаагүй гэж хариулсан бол 5.7 хувь нь торгуулийн төлбөрт орж байсан гэж хариулсан байна.

Зураг 5.22. Малчид мал маллах явцад ямар нэг торгуульд орж байсан эсэх, байршлаар



Торгуульд орж байсан малчдын тухайд төвийн бүсэд харьцангуй их буюу 3 малчин тутмын нэг нь ямар нэгэн байдлаар торгууль төлж байжээ. Бусад бүсийн хувьд төв сууринд мал маллахыг хориглосон журмыг зөрчсөний улмаас торгууль төлдөг гэжээ.

6. МАЛЧДЫН НИЙГМИЙН ҮҮРЭГ, БАЙР СУУРЬ


Улсын Бага хурлаас 1991 онд баталсан “Өмч хувьчлах тухай хууль”-ийн дагуу малчид малаа хувьчилж авсанаар “... малчид хувийн өмчтөн-мал сүргийн эзэд болж, ардын аж ахуйтнууд шинээр төрж эхэлсэн. Малчдад мал өмчлүүлснээр 1989 оноос хойш малчин өрхийн тоо 3.9 дахин өсч 268.7 мянга болсон бөгөөд малчдын амьдрал ахуйд зах зээлийн харилцааны үр дагавар хүчтэй туссан хэдий ч нийгмийн шинэ орчин нөхцөлд дасч идээших, түүнд зохицуулан амьдрал ахуйгаа хөтлөх арга барил эзэмших эдийн засаг, нийгэм-сэтгэл зүйн уур амьсгал бүрэлдсэн”¹⁹ юм. Зах зээлийн эхэн үеийн малчдын онцлогийг эрдэмтэд ийнхүү тэмдэглэж, тодорхойлсон байдаг. Харин сүүлийн жилүүдэд энэхүү эдийн засгийн салбарын ангилалд туслах малчин, хөлсний малчин гэж малчдын бүлэг дотороо ялгарах болсон.

6.1. Туслах малчин, тэдгээрийн нийгмийн асуудал

Үндсэн болон туслах малчдын харьцаа. Сүүлийн жилүүдэд туслах малчин гэх ойлголт түгээмэл хэрэглэгдэж, Үндэсний статистикийн хорооноос үүнтэй холбоотой статистик мэдээллийг албан ёсоор гаргах болсон бөгөөд 2017 оны байдлаар нийт малчдын 4.5 хувийг нь туслах малчид эзлэж байна.

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн мал аж ахуй эрхлэж амьжиргаагаа залгуулдаг малчдын 96.5 хувь нь өөрийн эзэмшлийн малаа хариулдаг гэсэн бол 3.5 хувь нь бусдын малыг ямар нэгэн байдлаар хариулдаг туслах малчин гэжээ.


Зураг 6.1. Судалгаанд хамрагдсан үндсэн болон туслах малчид, насны бүлгээр



Насны бүлгээр тодруулвал, 15-24 насны малчдын 10.3, 25-34 насны малчдын 4.2, 35-44 насны малчдын 3.7, 45-54 насны малчдын 3.8, 55-64 насны малчдын 3.1, 65 ба түүнээс дээш насны малчдын 3.3 нь туслах малчин юм.

¹⁹ Х.Гүндсамбуу (2002), “Монголын нийгмийн давхраажил (XX зуун)” х 109 Улаанбаатар

Зураг 6.2. Үндсэн болон туслах малчид, насны бүлгээр, 2017 он




Мэдээллийн эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, www.1212.mn

Туслах малчдын дунд 44 хүртэл насныхан давамгайлж байгаагаас 15-34 хүртэл насны малчид 47.0 хувийг нь бүрдүүлж байна.


Үндсэн (өөрийн малыг маллаж буй малчин) болон туслах малчдыг мал малласан туршлагыг жилээр харьцуулан харвал, туслах малчдын хувьд туршлага багатай залуу малчид буюу 32.8 хувь нь 0-4 жил, 29.9 хувь нь 5-9 жил мал малласан малчид байна. Харин үндсэн малчид туслах малчдаас илүү туршлагатай олон жил мал малласан малчин байна. Үндсэн малчдын 17.7 хувь нь 20-24 жил, 16.8 хувь нь 25-29 жил мал малласан малчид байна.

Зураг 6.3. Үндсэн болон туслах малчдын хувь, мал малласан жилээр




Боловсролын түвшний хувьд туслах малчдын 14.9 хувь нь, үндсэн малчдын 7.0 хувь нь ямар нэгэн боловсрол эзэмшээгүй байна. Харин бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй хүмүүсийн эзлэх хэмжээ туслах малчдын 1.5, үндсэн малчдын 4.8 хувийг, бүрэн дунд хүртэлх боловсролтой хүмүүс үндсэн малчдын 87.9, туслах малчдын 89.6 хувийг бүрдүүлж байна.

Зураг 6.4. Үндсэн болон туслах малчдын хувь, боловсролын түвшингээр




Үндсэн малчидтай харьцуулахад туслах малчид харьцангуй олон мал хариулдаг. Тухайлбал, туслах малчдын 39.1 хувь нь 1000-2000 мал, 26.1 хувь нь 501-999 мал маллаж байна.

Зураг 6.5. Үндсэн болон туслах малчдын хувь, хонин толгойд шилжүүлсэн нийт хариулж буй малын тоогоор




Малчин өрхийн маллаж байгаа тавиул малын тоог харахад, үндсэн малчдын 72.9 хувь нь өөрийн малыг дангаар, малчдын 8.7 хувь нь цалинжуулж буй айлын малыг малладаг. Тавиул мал маллаж буй байдлыг харвал туслах малчдын 78.3 хувь нь 200 ба түүнээс дээш тооны, өөрийн малыг маллаж буй малчдын 10.9 хувь нь тавиул мал малладаг.

Зураг 6.6. Үндсэн болон туслах малчдын хувь, хонин толгойд шилжүүлсэн тавиул малын тоогоор




Судалгаанд хамрагдсан малчдын 12.4 хувь нь өөрийн эзэмшлийн малыг бусдад хөлс төлж харуулдаг. Үүнээс гадна судлагдсан нийт малчдын 10.2 хувь нь өөрийн эзэмшлийн малаас гадна бусдын малыг хөлсөөр хардаг аж. Залуу малчдын хувьд малаа хөлсөөр харуулах нь бага бөгөөд бусдын малыг хөлсөөр харах нь их байна. Харин 55-аас дээш насны ахмад малчдын хувьд бусдын малыг хөлсөөр хариулах нь бага, харин өөрийг малыг бусдаар харуулах нь их байна. (Зураг 6.7)

Зураг 6.7. Малчид мал хөлсөөр харуулдаг эсэх, өрхийн тэргүүлэгчийн насны бүлгээр




Малаа хөлсөөр хариулуулдаг малчин өрхийн хувьд 43.8 хувь нь хамаатан садан, 19.2 хувь нь найз нөхөд, таньдаг хүнээр, 36.9 хувь нь огт хамааралгүй хүнийг хөлсөлж малаа хариулуулдаг. Ажиллах нөхцлийн хувьд 90.8 хувь нь аман тохиролцоо хийдэг бол 4.6 хувь нь албан ёсоор гэрээ байгуулж ажилладаг. Аман тохиролцоо хийж буй хүмүүсийн холбоо хамаарлыг тодруулбал, тухайн малчин өөрийн хамаатан садан, найз нөхөд, таньдаг хүнээр малаа харуулах тохиолдолд гэрээ хийлгүй аман тохиролцоо хийдэг бол холбоо хамааралгүй иргэнээр малаа харуулж буй тохиолдолд гэрээ хийх хандлага харьцангуй өндөр байна. Гэхдээ ураг төрөл, найз нөхдийн харилцаагүй хүнээр мал маллуулж байгаа тохиолдолд ч албан ёсны гэрээ хэлцэлд үндэслэсэн харилцаа бүрэн төлөвшөөгүй бөгөөд хамааралгүй гэх хүмүүсийн дөнгөж 12.5 хувь нь гэрээ байгуулсан байна.

Зураг 6.8. Малаа хөлсөөр харуулдаг малчин өрх, хэнийг хөлсөлдөг эсэх, гэрээ байгуулдаг эсэх



Хөдөлмөрийн хөлс, түүний хэлбэрийг тодруулбал, цалин хөлс, мал, хүнс-хувцас хэрэглэл, малын тэжээл зэргийг төлбөрийн хэрэгсэл болгон ашигладаг. Туслах малчин хөлсөөр ажиллуулж буй малчдын хувьд 69.2 хувь нь цалин, 43.8 хувь нь мал, 31.5 хувь нь хүнсний зүйл, 27.7 хувь нь малын тэжээл өгдөг гэж хариулжээ. Бусдын малыг хөлсөөр хардаг малчдын хувьд дээрхтэй ойролцоо хариулт өгсөн бөгөөд 62.6 хувь мал, 35.5 хувь нь мал, 24.3 хувь нь хүнсний зүйл, 27.1 хувь нь малын тэжээл авдаг байна.

Зураг 6.9. Мал хүнээр харуулсан, харсан тохиолдолд хөлсөө ямар хэлбэрээр авдаг эсэх



6.2. Фермер эрхлэгчид ба бэрхшээл

Монгол улсад уламжлалт бэлчээрийн аж ахуй зонхилж байгаа (98 хувь) ч фермерийн буюу эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх тал дээр бодлогын түвшинд анхааран ажиллаж байгаа юм. Малчид, ялангуяа суурьшлын бүсэд ойр амьдарч буй малчид энэ чиглэлийг хөгжүүлэх талаар өөрсдөө санаачлага гарган ажиллах болсон. ҮСХ-ны 2017 оны мал тооллогын урьдчилсан дүнгээр эрчимжсэн мал аж ахуй эрхлэж байгаа иргэн, өрхийн тоо 3182, аж ахуй нэгжийн тоо 108²⁰-д хүрсэн үзүүлэлттэй гарчээ.

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бүсийн тулгуур төвүүдийн ойролцоо, мөн тариалангийн бүс нутагт газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх, бэлчээрийн нөөцийг зохистой ашиглах, бүтээмж өндөртэй мал, амьтан үржүүлэх²¹ байдлаар хөгжлийн чиг хандлага, бүсийн онцлог, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх бодлого баримтлаж байгаа юм. Тухайлбал, тариалангийн бүс нутаг, бүсийн тулгуур төвүүдийн ойролцоо хүн ам төвлөрсөн газруудад зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн фермерийн аж ахуйг хөгжүүлэх эхлэл тавигдаж, багагүй ажил хийсэн байна.


Судалгаанд хамрагдсан малчдын мал маллагааны арга хэлбэрийг авч үзвэл 94.0 хувь нь уламжлалт аргаар МАА эрхлэж байгаа бол 6.0 хувь нь фермерийн аж ахуй эрхлэж байна. Фермерийн аж ахуй эрхлэж байгаа малчдын 55.6 хувь нь фермер болон уламжлалт арга хосолсон, 44.4 хувь нь дан фермерийн мал аж ахуй дагнан эрхэлдэг.

Фермерийн аж ахуй эрхлэгчдийг үйл ажиллагааны чиглэл, төрлөөр ялган харвал 84.1 хувь нь үнээний сүү, 19.0 хувь нь мах, сүүний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа юм. Харин 6.3 хувь нь фермерийн үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ уламжлалт аж ахуй эрхлэж байна.

²⁰ ҮСХ, Мал тооллогын дүн 2017 он


²¹ (Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр (1 дүгээр хавсралт), 2003)

Зураг 6.10. Фермерийн МАА эрхэлдэг малчин, фермерийн аргаар



Уламжлалт болон фермерийн аж ахуй дагнан эрхэлдэг малчдын дийлэнх хэсэг нь эцэг эхээс өвлүүлж өгсөн малыг дурдан буй аргаар үргэлжлүүлэн авч явж байна. Эцэг, эхийн өвлүүлсэн малаас гадна өмч хувьчлалаар, өөрсдөө худалдаж авах, төсөл хөтөлбөрт хамрагдаж малтай болсон тохиолдлууд мөн зохих нөлөө үзүүлсэн байна. Фермер эрхлэгчдийн хувьд үйл ажиллагааны онцлогоос хамааран тухайн чиглэлийн үйлдвэр, угсааны малыг худалдан авч, үржүүлэх хандлага харьцангуй өндөр (46.0 хувь) байна.

Зураг 6.11. Анх малтай болоход нөлөөлсөн хүчин зүйлс, мал маллагааны хэлбэрээр



Судалгаанд оролцогчдын зүгээс мал маллагааны арга хэлбэрийн үр ашгийг тодруулахад, уламжлалт мал аж ахуй эрхлэгчдийн 48.6 хувь нь бэлчээрийн мал аж ахуйг, фермерийн аж ахуй эрхлэгчдийн 55.6 хувь уламжлалт болон фермерийн аж ахуйг хослуулан хөгжүүлэх нь Монгол улсын эрх ашигт нийцнэ гэж онцолсон.


7. ТӨРИЙН БОДЛОГО НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ХАМРАГДАЛТ

7.1. Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж

Судалгааны хүрээнд эрүүл мэндийн асуудлыг нэгдүгээрт, малчдын эрүүл мэндийн байдал хоёрдугаарт, хэрэглээ зан үйл гуравдугаарт, эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмж зэрэг үзүүлэлтэд үндэслэн тодрууллаа. Судалгааны үр дүнгээс эдгээрийг тодруулбал,


Хөгжлийн бэрхшээлтэй иргэд. Судалгаанд хамрагдсан 1050 өрхийн 4080 гишүүний 3.9 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй гэж хариулсан байгаагаас 32.5 хувь нь төрөлхийн, 67.5 хувь нь олдмол шинжтэй хөгжлийн бэрхшээлтэй байна

Зураг 7.1. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн гишүүд, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр, хувиар




Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг насны бүлэг болон төрлөөр тодруулсан. Үр дүнг бүхэлд нь харвал 25-аас дээш насныхны дунд олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийн эзлэх хэмжээ харьцангуй өндөр байна.

Зураг 7.2. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн иргэдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь, насны бүлэг, төрөлхийн, олдмол эсэхээр



Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг тодруулбал хөдөлгөөний бэрхшээлтэй иргэд хамгийн өндөр хувь (28.8 хувь)-ийг эзэлж байгаа бол харааны бэрхшээл, сонсголын бэрхшээл тус тус 14.4 хувь, сэтгэц, оюуны бэрхшээлтэй иргэд 13.8 хувь, хавсарсан бэрхшээлтэй иргэд 8.1 хувь, хэл ярианы бэрхшээлтэй иргэд 3.1 хувийг эзэлж байна.

Зураг 7.3. Судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, хувиар




Хөгжлийн бэрхшээлийн шалтгаан, хэлбэрийг тодорхойлсон энэ үр дүнгээс хөдөөгийн иргэдийн дунд ялангуяа, насанд хүрэгчдийн дунд олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол элбэг, хэлбэрийн хувьд хөдөлгөөн буюу тулгуур эрхтэний бэрхшээл зонхилж байна.

Ундны усны эх үүсвэр

Ундны усны эх үүсвэр, ус нөөцлөх сав зэрэг эрүүл ахуйн стандарт шаардлагыг хангаагүй тохиолдолд холер, гэдэсний хижиг зэрэг халдварт өвчин тусах эрсдлийг нэмэгдүүлдэг. Судалгааны явцад ундны усны эх үүсвэр, нөөцлөх сав зэргийг тодруулан судалсан.


Усны эх үүсвэрийг тодруулбал, таван өрх тутмын хоёр нь буюу 41.5 хувь нь сайжруулсан эх үүсвэрээс ус хэрэглэж байгаагаас 32.2 хувь нь хамгаалагдсан гүний худгаас усаа авдаг байна. Харин судалгаанд оролцсон нийт малчин өрхийн 58.5 хувь нь сайжруулаагүй эх үүсвэрээс ундны усаа хэрэглэж байгаагаас 25.8 хувь нь хамгаалагдаагүй худаг, 22.2 хувь нь усны ил эх үүсвэр буюу гол, мөрөн, нуур, тойром, цөөрмөөс ундны усаа авч хэрэглэж байна. (Зураг 7.4)

Зураг 7.4. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн ундны усны эх үүсвэр



Бүсээр тодруулвал, Улаанбаатар хотод сайжруулсан ундны усны хэрэглээ хамгийн өндөр (90.0 хувь) байгаа бол баруун бүсэд хамгийн бага буюу 26.4 хувь байна. (Зураг 7.5)


Зураг 7.5. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн ундны усны эх үүсвэр, бүсээр



Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж


Малчдын эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжийг судалгаанд оролцогчдоос тодруулахад малчид хамгийн ойр өрх/сумын эмнэлэг хүртэл дунджаар 25.0 километр, аймаг, дүүргийн эмнэлгээс хамгийн ойр нь дунджаар 98.4 километр явж үйлчлүүлэх боломжтой. Энэ үзүүлэлтийг байршлаар харвал нийслэлд хамгийн ойр буюу өрхийн эмнэлэг хүртэл дунджаар 7.2, дүүргийн нэгдсэн эмнэлэг хүртэл дунджаар 46.8 километрийн зайтай байна. Аймгийн төвийн ойр амьдарч буй малчдын хувьд аймгийн төв дэх сумын эмнэлэг хүртэл дунджаар 20.3 километрийн зайтай байгаа бол аймгийн нэгдсэн эмнэлэг хүртэл дунджаар 21.6 километрийн зайтай байна. Сумын төвийн ойр амьдарч буй малчдын хувьд сумын эмнэлэг хүртэл дунджаар 10 километрийн зайтай бол аймгийн нэгдсэн эмнэлэг хүртэл дунджаар 104 километрийн зайтай байна. Хөдөөд амьдарч буй малчид нийслэл, аймгийн төв, сумын төвтэй харьцуулахад эрүүл мэндийн үйлчилгээ хүртэхэд харьцангуй хол буюу сумын эмнэлгээс 29.9 километр, аймгийн нэгдсэн эмнэлгээс 123.5 километр зайтай амьдарч байна.

Зураг 7.6. Малчин өрхүүдээс хамгийн ойр эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх дундаж зай, байршлаар, километрээр



Судалгаанд хамрагдсан малчдаас сүүлийн 6 сарын хугацаанд эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан эсэхийг тодруулахад 52.9 хувь нь өрхийн аль нэг гишүүн нь эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан, 46.8 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаагүй гэжээ.

Зураг 7.7. Малчдын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан байдал, үйлчилгээний төрлөөр *




* Сүүлийн 6 сарт тухайн өрхийн гишүүд эрүүл мэндийн үйлчилгээг давхардуулан авах боломжтой тул үйлчилгээ авсан хувьтай тэнцэхгүй.

Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан малчдын 35.3 хувь нь нарийн мэргэжлийн эмчийн тусламж, 32.8 хувь нь эмнэлгийн үзлэг, зөвлөгөө, 29.0 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэг, 12.8 хувь нь жирэмсний хяналт, 12.4 хувь нь 0-1 насны хүүхдийн эмнэлгийн идэвхтэй хяналт, 9.9 хувь нь архаг өвчний хяналт, 9.4 хувь нь эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ авчээ. Үйлчилгээнд хамрагдсан малчдын эрүүл мэндийн байгууллагад хандсан шалтгааныг нь тодруулбал, 36.9 хувь нь өвчлөөгүй буюу урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдах, жирэмсний хяналтанд орох, 0-1 насны хүүхдийн эмнэлгийн идэвхтэй хяналтанд хамруулах зэрэг шалтгааны учир эмнэлэгт хандсан байна.


Өвчний шалтгааны улмаас эмнэлэгт хандсан малчдын тухайд 21.3 хувь нь зүрх судас, цусны эргэлтийн тогтолцооны өвчин буюу цусны даралт ихсэх, зүрхний цохилт өөрчлөгдөх, 11.7 хувь нь үе мөчний өвчний улмаас эмнэлэгт ханджээ.

Зураг 7.8. Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан малчид үйлчилгээний төрөл, хүйсээр




Өвчлөлийн эхний гурван шалтгааныг насны бүлгээр харьцуулан харахад залуучуудын хувьд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдахаар (20-24 насныханы 86.7 хувь өвчлөөгүй) эрүүл мэндийн байгууллагад ханддаг бол нас ахих тутам урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах хэмжээ буурч өвчлөлтэй холбоотой хандалт өсдөг аж. Тухайлбал, үе мөчний өвчний улмаас эмнэлэгт хандсан хүмүүсийн эзлэх хэмжээ 45-49 насныхны дунд 10.0 хувь байсан бол 65 ба түүнээс дээш насанд 41.7 хувь болж, зүрх судас, цус эргэлтийн тогтолцооны өвчлөл 25-29 насанд 8.8 хувь байсан бол энэ үзүүлэлт 50-54 нас хүртэл нэмэгдэж, үүнээс хойш тогтворжих хандлагатай болсон байна.

Зураг 7.9. Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан малчдыг насны бүлгээр



Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаагүй малчдаас шалтгааныг тодруулахад 91.0 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах шаардлага гараагүй, 8.1 хувь нь цаг зав гараагүй гэж хариулсан байна. Энэхүү үзүүлэлтийг байршлаар авч үзэхэд нийслэлийн малчдын 84.0 хувь нь шаардлага гараагүй, 4.0 хувь нь бичиг баримт дутуу, 4.0 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээний чанар муу, 4.0 хувь нь эмнэлгийн ажилтнуудын харьцаа муу, 4.0 хувь нь мөнгө байхгүй, 4.0 завгүй, 4.0 өөрөө эмчилсэн гэж хариулсан байна. Аймгийн төвийн малчдын 91.3 хувь нь шаардлага гараагүй, 1.9 хувь нь мөнгө байхгүй, 11.7 хувь нь завгүй, 3.9 хувь нь өөрөө эмчилсэн, 1.9 хувь нь мал харах хүнгүй гэж хариулсан байна. Сумын төвийн малчдын 90.7 хувь нь шаардлага гараагүй, 7.0 хувь нь мөнгө байхгүй, 7 хувь нь завгүй, 2.3 хувь нь өөрөө эмчилсэн гэжээ. Хөдөөгийн малчдын 91.6 хувь нь шаардлага гараагүй, 0.6 хувь нь бичиг баримт дутуу, 1.3 хувь нь үйлчилгээний чанар муу, 1.9 хувь нь ачаалал их, 1.6 хувь нь эмнэлгийн ажилтнуудын харьцаа муу, 1.6 хувь нь мөнгө байхгүй, 7.5 хувь нь завгүй, 4.4 хувь нь өөрөө эмчилсэн, 2.5 хувь нь мал харах хүнгүй гэж хариулсан байна.

Зураг 7.10. Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаагүй шалтгаан



Малын гаралтай халдварт өвчний талаарх мэдлэг. Улсын хэмжээнд малын гоц халдварт өвчнөөс урдъчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа ч 2017 оны жилийн эцсийн байдлаар 21 аймаг, нийслэлийн давхардсан тоогоор 541 суманд халдварт өвчний 1142 гаралт бүртгэгдэж нийт 9998 мал, амьтан өвчилсөн байна²².


²² Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, мал эмнэлэг үржлийн газрын "Халдварт өвчний мэдээлэл" 2017он

Хүснэгт 7.1. Улсын хэмжээнд малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан, халдварт өвчин, өвчнөөр өвчилсөн, эдгэрсэн малын тоо, зардал²³

Үзүүлэлт	2005	2010	2015	2016	2017
Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд					
Хамрагдсан малын тоо, мянган толгой/ давхардсан тоогоор	22 222.0	30 451.7	38 703.5	36 795.4	31 572.3
Зарцуулсан зардал, сая төгрөг	2 415.1	3 573.2	7 976.6	5 328.5	5 748.3
1 малд ногдох зардал төгрөг	108.7	117.3	206.1	145.0	182
Гоц халдварт өвчний вакцинуулалт					
Хамрагдсан малын тоо, мянган толгой/ давхардсан тоогоор	10 500.0	9 245.7	6 595.0	26 816.0	47 868.3
Зарцуулсан зардал, сая төгрөг	2500.0	1 714.3	4330.0	16 777.9	17 056.5
1 малд ногдох зардал төгрөг	238.1	185.4	656.5	625.7	356.3
Халдварт өвчин					
Өвчин гарсан сум, давхардсан тоогоор	274	520	860	598	541
Өвчилсөн малын тоо, мянган толгой	23.9	22.3	15.7	17.4	9.9
Эдгэрсэн малын тоо, мянган толгой	21.7	19.8	12.3	14.0	7.3

Судалгаанд хамрагдсан малчдаас хамгийн түгээмэл, тархалт ихтэй малын өвчин, малаас хүнд халдварладаг өвчнөөс бруцеллөз (96.4 хувь)-ийг онцолсон бөгөөд хачиг, боом, галзуу өвчний талаар сонссон гэжээ.

Зураг 7.11. Малчдын малаас хүнд халдварладаг өвчний талаарх мэдлэг, сонссон байдал бүсээр



Малын гаралтай өвчин бүр хүнд халдварладаг гэж үзэх нь өрөөсгөл бөгөөд судалгааны үр дүнгээс малчид малын өвчний талаар бүрэн бус мэдээлэлтэй болох нь харагдаж байна. Тухайлбал, өвчний шинж тэмдгийг тодруулан асуухад төдийлөн сайн мэддэггүй, өвчнөөс өөрийгөө хамгаалах халдвар хамгааллын дэглэм барьдаггүй байна. Судалгааны мэдээлэл цуглуулахад явцад ийм зүйл ажиглагдаж байсан бөгөөд баруун болон зүүн бүсийн аймгуудад малын сэг нэлээдгүй, бүр судалгаанд хамрагдсан малчин гэрээсээ 5 метрийн зайд сэгийг бөөгнүүлэн орхисон айлтай таарч байсан нь үүнийг гэрчилнэ.


7.2. Боловсролын үйлчилгээний хүртээмж, хамрагдалт

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 15 ба түүнээс дээш насны нийт гишүүдийн боловсролын түвшнийг харвал 6.0 хувь нь боловсролгүй, 13.7 хувь нь бага, 29.8 хувь нь суурь,

²³ МУ-ын статистикийн эмхэтгэл 2017он

35.5 хувь нь бүрэн дунд, 6.6 хувь нь техникийн болон мэргэжлийн, 8.3 хувь нь бакалавр болон түүнээс дээш түвшний боловсрол эзэмшжээ. Малчдын боловсролын түвшинг хүйсээр харвал бүрэн дундаас доош боловсролтой эрэгтэй малчдын эзлэх хувь эмэгтэй малчдынхаас 3.5-4.0 пунктээр илүү байна. Энэ үзүүлэлтийг насны бүлгээр харвал 25-29 насны малчдын дунд дээд боловсролтой малчдын хувь хамгийн өндөр (25.7 хувь) байгаа бол 30-34 насны малчдын дунд боловсрол эзэмшээгүй малчдын эзлэх хэмжээ харьцангуй өндөр (10.6 хувь) байна.


Зураг 7.12. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүдийн боловсролын түвшин, насны бүлгээр



Хүүхдүүд болон өсвөр үеийнхний боловсролын үйлчилгээний хамрагалт

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 6-15 насны 425 хүүхдийн 97.9 хувь нь сургуульд хамрагдсан бол 2.1 хувь нь сургуульд хамрагдаагүй байна. Энэ үзүүлэлтийг байршлаар авч үзэхэд нийслэлээс судалгаанд хамрагдсан малчдын дунд сургуульд хамрагдаагүй хүүхэд байхгүй, аймгийн төвийн малчдын 1.3 хувь, сумын төвийн малчдын 7.1 хувь нь хүүхдээ сургуульд хамруулаагүй байна. Харин хөдөөгийн малчдын 98.3 хувь нь хүүхдээ сургуульд хамруулсан бол 1.7 хувь нь сургуульд хамруулаагүй байна. Сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийг хүйсээр авч үзвэл бүгд эрэгтэй хүүхдүүд байна.


Зураг 7.13. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 6-15 насны хүүхдүүдийн сургуульд хамрагалт, байршлаар



6-15 насны хүүхдийн сургуульд хамрагдаагүй шалтгааныг тодруулахад 25.0 хувь нь өвчний улмаас/ хөгжлийн бэрхшээлтэй, 16.7 хувь нь өрхийн аж ахуйд туслахаар, 16.7 хувь нь өөрөө суралцах хүсэлгүй, 16.7 хувь нь сургуульд орох насанд хүрээгүй(сар дутуу), 8.3 хувь нь эцэг эх


сургах хүсэлгүй, 8.3 хувь нь санхүүгийн боломжгүй, 8.3 хувь нь бусад шалтгаанаар сургуульд хамрагдаагүй байна.

Зураг 7.14. Сургуульд хамрагдаагүй малчин өрхийн 6-15 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдаагүй шалтгаан



Сургуульд сурах насны доод хязгаарыг 6 насаар хязгаарлаж байгааг малчдын 48.5 хувь нь зөв, 51.5 хувь нь буруу гэж хариулсан байна. Үүнийг эсэргүүцэж буй малчид 27.0 хувь нь хэт бага учир ачаалал даахгүй их ядардаг, 14.6 хувь нь хүүхэд хэт балчир учир эхнэр хүүхдээ харахаар төвд суух, улмаар хоол ундны зардал нэмэгдэх, малаа харж байгаа нэг нь хүйтний улиралд зутрах, хоол унд муутай, амарч чадахгүй байх зэрэг сөрөг үр дагавартай гэж, 3.5 хувь нь 6 наснаас хүүхдийг сургуульд хамруулсанаар залуу гэр бүлд салалт их болж байгаа, 3.6 хувь нь бусад (хэцүү байдаг, хүүхдэд дотуур байр олддоггүй) гэсэн шалтгаануудыг дурдаж байгаагийн дээр тэдний 1.9 хувь нь хуучин тогтолцоогоор 7-8 насанд нь хүүхдийг сургуульд явуулбал зүгээр, 1.1 хувь нь мэдэхгүй байна гэж хариулсан байна.

Зураг 7.15. ЕБС-д хүүхдийг 6 наснаас хамруулж байгаа нь зөв эсэх, буруу гэж үзэж буй бол шалтгаан




ЕБС-д хүүхдийг 6 наснаас сургуульд хамруулж байгааг буруу гэж үзсэн ч эцэг эхчүүд хүүхдээ бусдаас хоцроохгүй, дутуу явуулахгүй гэсэн хандлага давамгайлдаг учир албан шахалтаар сургуульд хамруулж, үүнд нийцүүлэн гэр бүлийн амьдралыг зохицуулдаг.

Сургуульд орох насны, сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлээгүй малчдаас цөөн хэсэг нь БСШУСЯ, Дэлхийн банк, хүүхдийг ивээх сангийн хамтарсан “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төслийн хүрээнд гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрийн багц ном, бага боловсрол нөхөн олгох зуны хөтөлбөрт хамрагдсан байна.


Насанд хүрэгчдийн тухайд сүүлийн 12 сарын хугацаанд шинээр мэргэжил болон ур чадвар олгох сургалтад хамрагдсан талаар тодруулахад 8.7 хувь нь тийм гэж хариулсан бол 91.3 хувь нь үгүй гэж хариулсан байна. Сумын төв болон нийслэлд амьдардаг малчид илүү их сургалтад хамрагддаг. Харин хөдөөд амьдардаг малчдын хамгийн бага 4.9 хувь нь сургалтад хамрагддаг гэсэн бол 95.1 хувь нь ямар нэгэн сургалтад хамрагддаггүй гэжээ.

Зураг 7.16. Малчдын сүүлийн 12 сарын хугацаанд шинээр мэргэжил болон ур чадвар олгох сургалтад хамрагдсан байдал, байршлаар



Сургалтад хамрагдсан малчдын 29.7 хувь нь орон нутгийн байгууллагаас, 15.4 хувь нь олон улсын байгууллагаас, 15.4 хувь нь төрийн бус байгууллагаас, 15.4 хувь нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газраас, 7.7 хувь нь сум хөгжүүлэх сангаас, 6.6 хувь нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны, Хүнс хөдөө аж ахуйн газраас зохион байгуулсан сургалтад тус тус хамрагдсан байна. Харин 6.6 хувь нь ямар байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдсанаа мэдэхгүй байна гэж хариулсан.

Зураг 7.17. Сургалтад хамрагдсан малчдаас ямар байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдсан эсэх, хувиар



Сургалтын агуулгыг тодруулбал, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, мал маллагаа/малын эмчилгээ, тогооч, оёдол эсгүүрийн сургалтад хамрагдсан байна. Бусад буюу амьжиргаа дээшлүүлэх, жижиг дунд үйлдвэрийн бизнес, мэргэжил дээшлүүлэх, жирэмсний, мөнгөн хуримтлалын гэх мэт сургалтад хамгийн их хамрагджээ.

Малчдаас цаашид ямар чиглэлийн сургалтад хамрагдах сонирхолтой байгаа талаар тодруулахад дийлэнх нь сургалтад суух завгүй, амжихгүй, боломжгүй, хэт хөгширсөн гэж хариулж байсан ч хэрэв цаг зав гаргаад суух бол мал маллагаа/малын эмчилгээ, сүүн сүүн бүтээгдэхүүн боловсруулах, мах махан бүтээгдэхүүн боловсруулах, гар урлал, оёдол эсгүүр, бусад буюу

орлого нэмэгдүүлэх, бэлчээрийг зөв зохистой ашиглах талаар мэдлэг олгох сургалтад суух сонирхолтойгоо илэрхийлжээ. Суурьшлын ялгааг харвал, Улаанбаатарын малчид сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах, гар урлалын сургалтад суухыг илүүд үзэж байгаа бол зүүн бүсийн малчид мал маллагаа/малын эмчилгээний чиглэлийн сургалтад суух хүсэлтэйгээ илэрхийлсэн байна. Харин хангайн бүсийн малчид хүнсний технологи/хоол ундны үйлдвэрлэл, хүнсний ногооны тариалалтын чиглэлийн сургалтад суухыг илүүд үзсэн бол төвийн бүсийн малчид дархан мужаан, оёдол эсгүүр, үсчин гоо сайхны чиглэлийн сургалтад хамрагдах сонирхолтойг илэрхийлсэн байна.

7.3. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын хамрагдалт, хандлага

Даатгалд хамрагдалтын талаарх статистик баримт

Нийгмийн даатгалын сан нь даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, ажилгүй болоход өөрт нь, даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх боломжийг бүрдүүлдэг²⁴, мөн даатгуулагч эрүүл мэндийн эрсдэлд орох үед эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг даатгалын сангаас төлөх боломжтой болдог.²⁵ Ингэснээр шимтгэл төлсөн даатгуулагч нь улсын зүгээс үзүүлж буй нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдах боломж бүрддэг. Нийгмийн хамгааллын салбар хөгжиж сайжрахын хэрээр тэгш байдал бий болж, улс орон хөгждөг²⁶ гэж үздэг.

Малчдын тухайд Нийгмийн даатгалын сангаас хөнгөлөлт, халамж эдлэх эрх нь сайн дурын оролцоонд үндэслэх байдлаар үүсдэг²⁷ бөгөөд 2013 онд нийт малчдын 8.3 хувь нь буюу 23.7 мянган малчин нийгмийн даатгалд хамрагдсан байна. Энэ үзүүлэлт аажмаар өсч 2014 онд 11.2 хувь болсон бол 2015 онд буурч 9.7 хувь болсон. Харин 2016 оноос малчдын нийгмийн даатгал төлөлт 19.3 хувь болж өссөн²⁸ бол 2017 оны мал тооллогын дүнгээр, нийт малчдын 23.9 хувь нь буюу 72.7 мянган малчин нийгмийн даатгалд хамрагджээ.²⁹ 2017 он хүртэл малчдын НД-д хамрагдах нь 2013 оноос хойш даруй 15.6 хувиар өсжээ. Энэ нь нийгмийн даатгалын ач холбогдлыг ойлгож эхэлсэн гэж хэлж болохоор үр дүн мөн боловч ажиллах хүчний хувьд малчид нийт ажиллах хүчний 24.5 хувийг эзэлдэг, нийгмийн даатгалд хамрагддаг ажиллагсдын 10.0 хувийг эзэлж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм³⁰. Гэхдээ энэхүү тоо нь мал тооллогын үед малчдаас асууж, тодорхойлсон дүн бөгөөд НДЕГ-ын “Нийгмийн даатгалын хамрагдалт, тэтгэвэр, тэтгэмж авагчдын мэдээ”-нд 2018 оны 1 дүгээр сарын 1-ээс 12 дугаар сарын 31-ны өдөр хүртэл нийт сайн дурын даатгуулагчид 194418 иргэн байгаагаас 42201 малчид хамрагджээ.³¹ Харин албан журмын даатгалын хувьд НДЕГ-ын 2018 оны III улирлын байдлаар “Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур”-ын эдийн засгийн салбарт нийт 17871 иргэн хамрагдсан бөгөөд үүнээс “газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, ан агнуур болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаанд” хөдөлмөр эрхлэдэг 16656 иргэн байна.³² Мэдээллийн хязгаарлагдмал байдлаас хамааран мал аж ахуйн салбарт ажиллагсдын албан журмын даатгалд хамрагдагсын бодит тоог ялган харах боломж бүрдсэнгүй.



Нийт малчдад НД-ын
шимтгэл төлдөг малчдын эзлэх

хувь **23.9%**



Нийт малчдад ЭМД-ын
шимтгэл төлдөг малчдын эзлэх

хувь **65.3%**

²⁴ (Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын тухай ойлголт, 1994 он)

²⁵ (Монгол улсын хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай, 2015 он)

²⁶ (Маморү Ямашита, 2018 он)

²⁷ (Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын тухай, 2016)

²⁸ (Монгол улсын үндэсний статистикийн хороо, 2016 он)

²⁹ (Монгол улсын үндэсний статистикийн хороо, 2018 он)

³⁰ (Монгол улсын үндэсний статистикийн хороо, 2018 он)


³¹ (Нийгмийн даатгалын ерөнхий газар, 2018 оны 12 дугаар сарын урьдчилсан мэдээ)

³² (Нийгмийн даатгалын ерөнхий газар, 2018 оны III улирлын мэдээ)

Эрүүл мэндийн даатгалын төлөлт, хамрагдалт харьцангуй өндөр бөгөөд 2017 оны статистик мэдээллээр малчдын 65.3 хувь нь нь буюу 198.3 мянган малчин эрүүл мэндийн даатгалд хамрагджээ.³³ 2015 оны 1 дүгээр сарын 29-нд ЭМД-н тухай хуулийн шинэчлэн найрууллагаар сайн дурын даатгуулагчид (малчид) ЭМД-д сард 3840 төгрөг буюу жилд 46080 төгрөг төлөхөөр тусгасан³⁴ бол 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн тогтоолоор өмнөх тогтоолыг хүчингүй болгож малчид ЭМД-д сард 2400 төгрөг буюу жилд 28800 төгрөг³⁵ төлөхөөр зохицуулсан. Энэ нь даатгалуулагчдын тоо өсөхөд нөлөөлсөн байх талтай.

Малчдын нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг харвал нас ахих тусам даатгалын төлж буй хүмүүсийн хэмжээ нэмэгдсэн байна.

Зураг 7.18. Насны бүлэг дэх малчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал төлөлтийн хувь, насны бүлгээр



Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын төлөлтийг бүсээр авч үзэхэд, төвийн бүсэд хамгийн өндөр буюу нийт 29.5 хувь нь нийгмийн даатгал, 65.8 хувь нь эрүүл мэндийн даатгал, хангайн бүсэд 25.8 хувь нь нийгмийн даатгал, 63.7 хувь нь эрүүл мэндийн даатгал, зүүн бүсэд 22.7 хувь нь нийгмийн даатгал, 68.5 хувь нь эрүүл мэндийн даатгал, баруун бүсэд 22.5 хувь нь нийгмийн даатгал, 62.9 хувь нь эрүүл мэндийн даатгал төлж байна.


Нийгмийн даатгал төлдөг малчдыг нийт малчдын дунд эзлэх хувиар Орхон (35.6 хувь), Говьсүмбэр (33.8 хувь), Дундговь (31.6 хувь) аймгууд өндөр хувьтай байгаа бол Хөвсгөл (18.1 хувь), Сүхбаатар (15.0 хувь), Баян-Өлгий (13.9 хувь) аймгийн малчид хамгийн бага хувьтай байна. Эрүүл мэндийн даатгал төлөлтийн байдлыг харвал Говь-Алтай (80.2 хувь), Дундговь (77.1 хувь), Дорноговь (73.8 хувь) аймгууд өндөр, Сэлэнгэ (57.4 хувь), Баян-Өлгий (55.2 хувь), Орхон (44.0 хувь) аймгийн малчид хамгийн бага хувьтай байна.

³³ (Монгол улсын үндэсний статистикийн хороо, 2018 он)

³⁴ (Эрүүл мэндийн даатгал, 2016 он)

³⁵ (Монгол улсын засгийн газрын тогтоол, 2017 он)


Зураг 7.19. Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал төлдөг малчдын нийт малчдад эзлэх хувь, аймгаар, 2017 он



Судлагдсан малчдын даатгалд хамрагдалт


Малчдын аж байдлын судалгаанд “НДШ болон ЭМД-ыг сүүлийн 12 сарын хугацааны хэдэн сард нь төлсөн бэ?” гэсэн асуултад судалгаанд оролцсон малчдын 71.1 хувь нь нийгмийн даатгал төлөөгүй гэсэн бол 26.7 хувь нь 12 сарын хугацаанд нийгмийн даатгал төлсөн гэжээ. Үлдсэн 2.3 хувь нь тогтмол бус боловч НДШ төлжээ.

Зураг 7.20. Сүүлийн 12 сарын хугацаанд нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, төлсөн сараар




Суурьшлын ялгааг тодруулбал, суурин газар байгаа малчдаас илүүтэй хөдөөгийн малчид НД болон ЭМД-д хамрагдалт өндөр, идэвхтэй байгаа нь ажиглагдаж байна. (Зураг 7.21)

Зураг 7.21. Сүүлийн 12 сарын хугацаанд нийгмийн даатгалд хамрагдсан байдал, төлсөн сар, байршлаар




Малчдын НДШ төлөлтийг суурьшилтай харьцуулж үзвэл: сум, хөдөө орон нутгийн малчдын НД төлсөн дундаж үзүүлэлт нийслэл болон аймгийн төвийн малчдын НД төлөлтөөс өндөр байна.

Зураг 7.22. Сүүлийн 12 сарын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, төлсөн сараар, байршлаар




ЭМД-д хамрагдалт сум, хөдөө орон нутгийн малчдын ЭМД-ийн төлөлтийг илэрхийлсэн дундаж үзүүлэлт (68.9 хувь) нийслэл, аймгийн малчдаас өндөр байна.

Зураг 7.23. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн гишүүдийн сүүлийн 12 сарын нийгмийн даатгалд хамрагдсан байдал, мал малласан жилээр




Судалгаанд хамрагдсан малчдын 22-оос дээш жил мал малласан малчдын 49.4 хувь, 11-ээс дээш жил мал малласан малчдын 31.1 хувь нь НД-д хамрагдсан бол мал малласан жил нь буурах тусам малчдын (19.5 хувь) НД төлөх жин нь буурч байна. Үүнээс үзэхэд малчдын мал хариулсан жил ихсэх тусам НД-д хамрагдалт өсөж байгаа нь малчдын тэтгэвэрт гарах нас ойртож малчид тэтгэвэрт гарах бэлтгэлээ базааж байгаатай холбож ойлгож болно.

Зураг 7.24. Сүүлийн 12 сарын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, мал малласан жилээр




ЭМД-д хамрагдалтадыг мал малласан хугацаатай нь харьцуулахад 22-оос дээш жил мал малласан малчдын 39.2 хувь нь ЭМД төлдөг гэсэн бол мал малласан хугацаа багасах тусам энэ үзүүлэлтийн хэмжээ мөн буурчээ. ЭМД төлдөггүй малчдын тухайд мөн адил дүр зураг ажиглагдаж байна.

Зураг 7.25. Сүүлийн 12 сарын нийгмийн даатгалд хамрагдсан байдал, насны бүлгээр



Малчдын насны бүлгийг НД-д хамрагдсан жингээр нь жигнэж үзвэл 45-54 насныхан хамгийн өндөр буюу 44.6 хувьтай байна. ҮСХ-оос гаргасан “Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга-2017” тайланд 35-аас дээш насны малчдын нийгмийн даатгал төлөлт бусад насныхнаас өндөр буюу 25.2-32.9 хувьтай байна³⁶ гэж тайлагнасан нь бидний хийсэн судалгааны үр дүнтэй нийцэж байгаа юм.

Зураг 7.26. Өрхийн гишүүдийн сүүлийн 12 сарын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, насны бүлгээр



ЭМД-д хамрагдалт 25-54 хүртэл насныхны дунд харьцангуй өндөр хувьтай байгаа бол 15-24 насныхны 59.2 хувь нь даатгалд хамрагджээ.

³⁶ ҮСХ, 2018 он


Зураг 7.27. Өрхийн гишүүдийн сүүлийн 12 сарын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, хүйсээр



НД болон ЭМД-д хамрагдсан малчдыг хүйсээр харьцуулан үзвэл, эмэгтэй малчдын 29.3 хувь, эрэгтэй малчдын 24.0 хувь нь НД-д хамрагдсан байна. Энэ нь “Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга 2017” тайланд “...эрэгтэй малчдын 22.2 хувь нь, эмэгтэй малчдын 26.2 хувь нь нийгмийн даатгал төлж байна.”³⁷ гэсэнтэй ойролцоо үр дүн юм. Харин НД-д огт хамрагдаж чадаагүй эрэгтэй малчид (73.5 хувь) НД хамрагдаагүй эмэгтэй малчдаас 4.8 пунктээр илүү байна.

ЭМД-д хамрагдсан байдлаар эмэгтэйчүүд (69.6 хувь) эрэгтэйчүүдээс (65.2 хувь) 4.4 пунктээр илүү байна.

Зураг 7.28. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн гишүүдийн сүүлийн 12 сарын НДШ, ЭМДШ төлөөгүй шалтгаан




НД-д тэр болгон хамрагдаж чаддаггүй малчдын тухайд үүний шалтгааныг мөнгөний боломжгүй (41.8 хувь) гэж тайлбарласан. Үлдсэн 18.2 хувь нь оюутан сурагч, 17.5 хувь нь тэтгэвэрт гарсан гэж хариулсан бол 9.9 хувь нь нийгмийн даатгал төлөх шаардлагагүй гэж үзсэн байна.

ЭМД-ийн тухайд 55.0 хувь нь тэтгэвэрт гарсан, оюутан сурагчтай учир ЭМД-д хамрагдаагүй гэсэн бол 19.4 хувь нь нэг их өвдөөд байдаггүй, 18.2 хувь нь мөнгөний боломжгүй тул ЭМД-д хамрагдаагүй гэжээ.

ШУА-ийн Философийн хүрээлэнгээс гаргасан “Монголыг нийгмийн бүтцийн судалгаа шинжилгээ” бүтээлийн эмхтгэлд “Малчдын хувьд хамгийн сэтгэл зовоож буй асуудал бол өрхийн хэрэгцээг хангах бэлэн мөнгөний асуудал юм. Судалгаанд хамрагдсан хоёр малчны нэг нь (48.2 хувь) мөнгө төгрөгөөр байнга гачигдаж байна” гэсэн байдаг. Энэ нь бидний судалгааны үр дүн бусад судалгааны байгууллагуудаас хийсэн ижил төрлийн судалгааны үр дүнтэй ойролцоо гарч байгааг харуулна.

³⁷ (Монгол улсын үндэсний статистикийн хороо, 2018 он)


Зураг 7.29. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүд НДШ, ЭМДШ төлснөөр нийгмийн баталгаа хангагдана гэж бодож буй эсэх



Хуулинд заасны дагуу нийгмийн даатгал төлөх эсэх нь сайн дурын асуудал боловч энэ нь ирээдүйд гарах эрсдэлийг бууруулах, байнгын орлоготой болох үндэс суурийг бий болгож өгдөг. Малчдын 57.4 хувь нь нийгмийн баталгаа ямар нэгэн байдлаар хангагдана гэсэн ойлголттой байдаг бол 29.3 хувь нь цөөн зүйл дээр санал нийлдэг.

2016 оны Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 240'000 төгрөг байхаар тогтсон.³⁸ Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд тэтгэврийн даатгал 10 хувь, тэтгэмжийн даатгал 1.0 хувь, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал 1.0 хувь байна. Харин шимтгэл тооцох сарын орлогын доод хэмжээ нь Засгийн газрын баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна.³⁹ гэсэн зохицуулалттай бөгөөд үүнээс харвал малчид НДШ-д хамгийн багадаа сард 28'800 төгрөг, жилд 345'600 төгрөг, ЭМД шимтгэлд сард 2400 төгрөг, жилд 28'800 төгрөг төлөхөөр болсон.⁴⁰ Мөн 2018 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн “Малчин” гэж мал аж ахуй эрхлэж үндсэн орлогоо олдог иргэнийг⁴¹ хэлнэ гээд тэдний тэтгэвр тогтоолгох насыг “нийт 20-оос доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил мал маллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн бол, нийт 20-оос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил мал маллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол”⁴² гэж 2017 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр”-ийн хуулиар өндөр насны тэтгэвэрт гарах насыг 5 жилээр урагшлуулсан. Энэ өөрчлөлтийн талаарх малчдын байр суурийг тодруулахад тэдний 96 хувь нь зөв, 1.0 хувь нь буруу шийдвэр гэж хариулсан. Үлдсэн хэсэг нь энэ шийдвэрийн үр нөлөө, ач холбогдлыг үнэлээгүй.

Зураг 7.30. Малчдын тэтгэврийн насыг өөрчилсөн нь зөв гэж үзсэн малчдын шалтгаан



Малчдын хөдөлмөр эрхлэлт маш хүнд нөхцөлд явагддаг, мөн ямар нэг амрах чөлөө зав байхгүй, өдөр шөнөгүй ажилладаг (57.8), хөдөлмөрийн онцлогоос үүдэн малчдын наслалт богино байдаг (31.8) гэх шалтгааны учир тэтгэврийн насны өөрчлөлтийг зөв гэж үзсэн. Малчдын наслалтын талаар “...Хүнд хөдөлмөр эрхлэж, нар салхинд хамгийн ихээр гандаж явдаг энэ

³⁸ (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай, 2016 он)

³⁹ (Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын сайн дурын даатгал, 2017 он)


⁴⁰ (Монгол улсын засгийн газрын тогтоол, 2017 он)

⁴¹ (Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, 2011)

⁴² (Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, 1994)

хүмүүсийн дундаж наслалт төв суурийн газрын хүмүүсээс доогуур байдаг” гэж тухайн үеийн салбарын яамны сайд нь мэдэгдэж байсан. Энэ нь малчдын аж байдал, амьжиргааг тэтгэх, эрсдлийг бууруулахад чиглэсэн оновчтой бодлогуудын нэг юм. Гэхдээ даатгалын хураамжийг хэрхэн төлөх тухай асуудлыг тусгайлан судлах шаардлагатай. Тухайлбал, малчид НДШ-ийг төлөхдөө хагас жилээр төлөх сонирхолтой гэж судалгаанд хамрагдсан малчдын 34.5 хувь нь хариулсан бол ЭМДШ-ийг бүтэн жилээр төлөх сонирхолтой гэж 49.0 хувь нь хариулсан байна.

Зураг 7.31. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүд НДШ, ЭМДШ төлөх сонирхол



НД-д бүрэн хамруулахын тулд:

- НД-ын ач холбогдолыг таниулсан сурталчилгаа хийх 25.9 хувь
- Төлбөрийг уян хатан болгох, хөнгөлөлт үзүүлж шимтгэлийг багасгах 13.9 хувь
- Малчдын мөнгөтэй үед буюу идэш, ноолуурын үеэр авах 8.0 хувь
- Амжиргааг дээшлүүлж, тогтмол орлоготой болгох 6.4 хувь гэсэн дөрвөн санал голчлон давтагдсан байна.

ЭМД-д бүрэн хамруулахын тулд:

- ЭМД-ын ач холбогдолыг таниулсан сурталчилгаа хийх 17.9 хувь
- Эмнэлгийн үйлчилгээг сайжруулж, хүртээмжтэй болгох 10.3 хувь
- Төлбөрийг уян хатан болгох, хөнгөлөлт үзүүлж шимтгэлийг багасгах 8.6 хувь гэсэн 3-н саналыг малчид голчлон санал болгожээ.

Судалгаанд хамрагдсан малчдын 18.1 хувь нь ЭМД-д бүрэн хамруулахад юу хийх хэрэгтэй талаар тодорхой зүйл хэлж мэдэхгүй гэжээ.

НД болон ЭМД-д хамруулахын тулд юу хийх шаардлагатай талаар малчдын гаргаж буй саналыг багцлан харвал:

1. Түүхийн эдийн үнийг тогтвортой барьж малчдыг тогтмол орлоготой болгоход дэмжлэг үзүүлэх,
2. Мал болон малын ашиг шимээр төлөх боломжтой болгох,
3. Төрөөс хөнгөлөлт үзүүлэх, урамшуулах, нөхөн төлөх боломжийг бүрдүүлэх, хугацааг уян хатан болгох, залуу малчдыг дэмжих,
4. Заавал даатгуулдаг болох, нэгдсэн журмаар хамруулах, нэг цэгийн үйлчилгээг хөдөөгүүр явуулах зэрэг албан үйлчилгээнүүдийг үзүүлэх,
5. Банкны зээлэнд хамрагдах боломжтой болгох, зээлээс суутган авах, малын хөлийн татвартай болж үүнээс НДШ-ийг шингээж авах зэрэг бодлогыг хэрэгжүүлсэн тохиолдолд малчид тогтмол НД төлөх болно гэж үзжээ.

Дээрхээс гадна нийгмийн даатгалын төлөлттэй холбоотой НД-ын ашиг шимийг хүртэж чадахгүй байна, тэтгэвэрт гарах насны хязгаар өндөр байна гэх саналуудыг мөн өгч байсан.

7.4. Орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрт хамрагдаж буй байдал

“Мал сүрэг нь Монгол Улсын үндэсний өвөрмөц, нөхөн сэргээгдэх баялаг, монголын соёл, уламжлалыг хадгалан авч яваа дэлхийн үнэт өв сан, тогтвортой хөгжлийн үндэс, эдийн засгийн тулгуурын нэг бөгөөд хүн амын амьжиргааны гол эх үүсвэр, хүнсний аюулгүй байдлын баталгаа,


малчин өрхийн эдийн засгийн үндэс юм⁴³ гэж “Монгол мал” үндэсний хөтөлбөрт дурдсан байдаг. Гэвч 1990-ээд оноос хойш малчдын мөнгөн орлогыг нэмэх, сууцны нөхцлийг сайжруулах, малчдын эрүүл мэндийг хамгаалах, мал эрүүлжүүлэх ажил байнгын асуудал дагуулсаар байна. Мал аж ахуйн салбарт тулгарч буй асуудлуудыг шийдэхийн тулд төр засаг олон улсын байгууллагатай хамтран төрөл бүрийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр байгаа билээ.

Судалгаанд хамрагдагсдын 52.0 хувь нь ямар нэг төсөл, хөтөлбөрт хамрагдаж байсан гэж хариулжээ. бол үлдсэн 48.0 хувь нь төсөл, хөтөлбөрт хамрагдаж байсан гэж хариулжээ.

Суурьшлаар нь ялган харвал, хөдөө орон нутгийн малчдын 54.5 хувь нь, нийслэлийн малчдын дөнгөж 2.0 хувь нь, аймгийн төвийн малчдын 48.3 хувь нь, сумын төвийн малчдын 38.5 хувь нь төсөл хөтөлбөрт хамрагдсан байна.


Судлагдсан малчдаас 42.0 нь ноосны урамшуулалд, 33.2 хувь нь арьс ширний урамшуулалд, үлдсэн 24.8 хувь нь бусад төсөл, хөтөлбөрт хамрагдсан байна.

Зураг 7.32. Төсөл хөтөлбөрт хамрагдаж байсан малчид ямар төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдсан эсэх



Малчдын хамрагдсан төсөл, хөтөлбөрийг харвал, 11.2 хувь нь “Ногоон алт төсөл”⁴⁴-д, 8.5 хувь нь “Залуу малчдыг малжуулах төсөл”⁴⁵-д, 8.3 хувь нь “Сум хөгжүүлэх сан”⁴⁶-д, 7.3 хувь нь “Дэлхийн зөн ОУБ-ийн малжуулах хөтөлбөр”⁴⁷-т хамрагдсан байна.

Зураг 7.33. Төсөл хөтөлбөрт хамрагдаж байсан малчид ямар төсөл хөтөлбөрүүдэд хамрагдсан эсэх



⁴³ (“Монгол мал үндэсний хөтөлбөр”, 2010)

⁴⁴ **Ногоон алт төсөл нь:** Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны агентлага хэрэгжүүлдэг төсөл. Бэлчээрийн тогтвортой менежментийг төлөвшүүлэх, малчдын бэлчээр ашиглах технологийн мэдлэгийг дээшлүүлэх, зах зээлд нэвтрэхэд нь дэмжих замаар малчин өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд Ногоон алт төслийн зорилго чиглэгддэг.

⁴⁵ **Залуу малчдыг малжуулах төсөл.** Мал аж ахуйн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа залуучуудад эдийн засаг, нийгмийн дэмжлэг үзүүлэн мал маллагааны уламжлалт арга туршлагыг өвлүүлэн, мал аж ахуйгаа эрхлэн хөтлөх менежментийн боловсрол олгож залуу малчдыг бэлтгэх зорилготой.

⁴⁶ **Сум хөгжүүлэх сан:** Сум орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлээр дэмжих зорилгоор 2011 оны 134 дүгээр тогтоолоор байгуулагдсан. 2011-2014 онд Улсын хэмжээнд нийт 84,0 тэрбум төгрөгийг улсын төсвөөс “Сум хөгжүүлэх санд” татан төвлөрүүлж 330 суманд хүн ам, эдийн засгийн боломжит нөхцөл байдлаас хамааруулж сумуудад хуваарилалт хийсэн.

⁴⁷ **Дэлхийн зөн ОУБ малжуулах хөтөлбөр:** 2009-2010 онд дараалан болсон ган, зуд болон нийгмийн бусад олон хүчин зүйлүүдээс шалтгаалж мал нь цөөрсөн байнгын хөдөө байдаг малчин өрхүүдийг “Малжуулах” тэдний амьдралыг дээшлүүлж зах зээлд өрсөлдөх чадвартай болгоход чиглэгдсэн хөтөлбөр.

Суурьшлаар нь харьцуулан харвал, аймгийн төвийн малчдын 28.6 хувь нь “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”⁴⁸-ийн төсөлд, 20.0 хувь нь, “Дэлхийн зөн ОУБ-ийн малжуулах хөтөлбөр”-т, сумын төвийн малчдын 33.3 хувь нь “Ногоон алт” төсөл, 13.9 хувь нь “Сум хөгжүүлэх” төсөлд, хөдөө орон нутгийн малчдын 23.8 хувь нь “Ногоон алт” төсөлд, 19.5 хувь нь “Залуу малчдыг малжуулах төсөл”-д, 17.3 хувь нь “Сум хөгжүүлэх төсөл”-д хамрагдсан байна.

Хүснэгт 7.2. Төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдсан малчид, байршлаар

	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө
1. Монгол мал үндэсний хөтөлбөр	0.0	8.3	2.2
2. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	5.7	8.3	5.4
3. Ядуурлыг бууруулах хөтөлбөр	0.0	2.8	2.7
4. Дэлхийн Зөн ОУБ малжуулах хөтөлбөр	20.0	11.1	14.1
5. Залуу малчдыг малжуулах төсөл	14.3	5.6	19.5
6. Тогтвортой амжиргаа төсөл	2.9	0.0	2.7
7. Ногоон алт төсөл	2.9	33.3	23.8
8. Бэлчээрийн ТМ төсөл	0.0	0.0	1.1
9. Сум хөгжүүлэх сан	14.3	13.9	17.3
10. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан	28.6	2.8	4.3
11. Бусад төсөл, хөтөлбөрүүд	11.4	13.9	7.0
Нийт	100.0	100.0	100.0

Жич: Судалгаанд хамрагдсан нийслэлийн малчид дээр дурдагдсан төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдаагүй гэж хариулсан болно.

Судалгаанд хамрагдсан малчид өөрсдийн хамрагдсан төсөл, хөтөлбөрийн ач холбогдлыг доорх байдлаар үнэлсэн байна. Үүнд:

- “**Ногоон алт**” төсөлд (11.2 хувь) хамрагдсан малчид ач холбогдлыг нь: 54.4 хувь нь ямар нэгэн хэмжээгээр ач холбогдол нь их гэсэн бол 19.3 хувь нь ач холбогдлыг нь сайн мэдэхгүй байна гэж хариулжээ.
- “**Залуу малчдыг малжуулах төсөл**”-д (8.5 хувь) хамрагдсан малчид: 90.7 хувь нь ач холбогдол ихтэй гэж хариулсан байна.
- “**Сум хөгжүүлэх төсөл**”-д (8.3 хувь) хамрагдсан малчдын 90.5 хувь нь ач холбогдол ихтэй гэж хариулжээ.
- “**Дэлхий зөн ОУБ малжуулах төсөл**”-д (7.3 хувь) хамрагдсан малчид: 91.9 хувь нь ач холбогдол нь их байсан гэж хариулсан байна.
- “**Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан**”-д (3.7 хувь) хамрагдсан малчдын 94.8 хувь нь тус сангийн ач холбогдол их байсан гэж дүгнэсэн байна. (Хүснэгт 7.3)

⁴⁸ *Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан:* Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгож, тэднийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилготой.

Хүснэгт 7.3. Төсөл хөтөлбөрүүдэд хамрагдсан малчид, төсөл хөтөлбөрүүдээ үнэлсэн байдал

		Маш их	Их	Дунд	Бага	Ач холбог-долгүй	Мэдэхгүй	N
1.	Монгол мал үндэсний хөтөлбөр	14.3	71.4	0.0	0.0	14.3	0.0	100
2.	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	20.0	66.7	13.3	0.0	0.0	0.0	100
3.	Ядуурлыг бууруулах хөтөлбөр	16.7	66.7	16.7	0.0	0.0	0.0	100
4.	Дэлхийн Зөн ОУБ малжуулах хөтөлбөр	35.1	56.8	5.4	2.7	0.0	0.0	100
5.	Залуу малчдыг малжуулах төсөл	37.2	53.5	7.0	0.0	2.3	0.0	100
6.	Тогтвортой амжиргаа төсөл	16.7	83.3	0.0	0.0	0.0	0.0	100
7.	Ногоон алт төсөл	14.0	40.4	15.8	3.5	7.0	19.3	100
8.	Бэлчээрийн ТМ төсөл	50.0	0.0	0.0	50.0	0.0	0.0	100
9.	Сум хөгжүүлэх төсөл	35.7	54.8	4.8	2.4	2.4	0.0	100
10.	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан	31.6	63.2	5.3	0.0	0.0	0.0	100
11.	Бусад төсөл хөтөлбөрүүд	26.1	43.5	26.1	4.3	0.0	0.0	100
12.	Дундаж үнэлгээ	27.0	54.6	8.6	5.7	2.4	1.8	


Малчид өөрсдийн хамрагдсан төсөл, хөтөлбөрийн ач холбогдлыг харьцангуй өндрөөр буюу 80.0 гаруй хувь нь эерэг үнэлгээ өгсөн.

Малчдыг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдээс гадна үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа. УИХ-ын 30 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоолоор “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”⁴⁹, мөн Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолоор “Хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох тухай журам”⁵⁰-ыг баталж, малчдад мөнгөн урамшууллыг олгож эхэлсэн.

Ноосны урамшуулал олгох хөтөлбөр 2011 оноос эхлэн хэрэгжиж эхэлснээс хойш 2016 он хүртэл нийт 506'717 (давхардсан тоогоор) малчны 92068.3 тонн ноосонд 136.0 тэрбум төгрөгийн урамшуулал⁵¹, арьс ширний мөнгөн урамшууллын хөтөлбөр 2013 оны эхний хагасаас хэрэгжиж эхэлснээс хойш 2016 оныг хүртэл нийт 132'492 малчны бод, богын нийлсэн 5.3 сая арьс, ширийг хүлээн авч, урамшуулалд нь 20.4 төгрөгийг зарцуулжээ.⁵²

Судалгаанд хамрагдсан малчдын 85.6 хувь нь ноосны урамшуулалд, 67.7 хувь нь арьс ширний урамшуулалд хамрагджээ.

Зураг 7.34. Ноос болон арьс ширний урамшуулалд хамрагдсан байдал



⁴⁹ (Монгол улсын засгийн газар Ж. ш., 2013)


⁵⁰ (Монгол улсын засгийн газар, 2015)

⁵¹ (2016 оны арьс ширний урамшуулал олгож эхэллээ, 2017)

⁵² (2016 оны арьс ширний урамшуулал олгож эхэллээ, 2017)

Ноос болон арьс ширний урамшуулалын ач холбогдлыг үнэлгээг харьцуулан харвал малчдын ноос, арьс ширний урамшууллын ач холбогдлыг өндөр гэж судалгаанд оролцогчдын 80.0 гаруй хувь нь хариулжээ.

Зураг 7.35. Ноос болон арьс ширний урамшууллын ач холбогдол



7.5. Малчдын талаар төрөөс баримтлаж буй бодлого, хэрэгжилтийн байдал

Үндсэн хууль хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн УИХ-аас “Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын зорилт, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэх”⁵³-ээр зохицуулсан байдаг. 2009 онд Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын хүрээнд “...Төлөвлөгөөнд заасан арга хэмжээ, санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж ажиллах...”⁵⁴ төлөвлөгөөний явцад:

1. Малчин өрх рүү чиглэсэн төсөл, хөтөлбөр нь малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөл бүрдүүлэх, ядуурлаас ангид байлгах, тэдэнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа бий болгоход чиглэсэн эрх зүй, эдийн засаг, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;
2. Малчин өрхийн эдийн засгийн үндэс болсон мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохион байгуулалтыг сайжруулж бүтээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх, бүтээгдэхүүн борлуулах зах зээлийн оновчтой тогтолцоог бий болгох;
3. Малчдын өөрөө өөртөө туслах, өөрөө өөрийгөө удирдах, иргэний нийгмийн бүтцийг бий болгон хөгжүүлэхийг дэмжих, боловсрол, мэдлэг чадварыг дээшлүүлэх, тусгай мэргэжил эзэмшүүлэх, малчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах замаар амьдралын дадал, заншилд өөрчлөлт оруулах гэсэн гурван үндсэн зорилтын хүрээнд төрөөс малчдын талаар баримтлах бодлогын эхний үе шатыг хэрэгжүүлсэн байна.⁵⁵

Хүснэгт 7.4. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын эхний үе шат (2009-2015 он)-нд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө⁵⁶ /сая төгрөгөөр/

			2009	2010	2011	2012	2013	2014	2015
НИЙТ ТӨСӨВ	471'256.6	100.0	14,310.0	38,311.8	63,656.9	113,432.5	81,723.4	82,576.0	77,246
1. Улсын төсвөөс санхүүжүүлэх	378,350.6	80.29	6,270.0	27,384.8	44,379.9	100,475.5	68,088.4	67,741.0	64,011.0
2. Мал хамгаалах сан	22,800.0	4.84	0	0	0	1,200.0	3,600.0	8,400.0	9,600.0
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	7,720.0	1.64	420	1,500.0	1,550.0	1,550.0	1,550	650	500.0

⁵³ (Төрөөс малчдын талаар баримтлах бодлого батлах тухай, 2009)

⁵⁴ (МУЗГ-ын тогтоол, 2009)

⁵⁵ (Монгол Улсын Их Хурлын 2009 оны 39 дугаар тогтоолын хавсралт, 2009 он)

⁵⁶ (Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын эхний үе шат /2009-2015 он/-нд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2009)


4. ШУТСангаас санхүүжүүлэх	140	0.03	0	90	50	0	0	0	0
5. Гадаадын зээл, тусламж, банкны зээл	48,946.0	10.4	7,620.0	6,392.0	14,472.0	7,102.0	6,870.0	4,570.0	1,920.0
6. Малчид, ААН-ийн хөрөнгө	11,500.0	2.4	0	2,595.0	2,755.0	2,655.0	1,165.0	1,165.0	1,165.0
7. Бусад тусгай сан	1,800.0	0.4	0.0	350.0	450.0	450.0	450.0	50.0	50.0

Төрөөс баримталж буй бодлогын хүрээнд 2009-2015 оны хооронд нийт 471'256.6 тэрбум төгрөгийг 6 эх үүсвэрээр дамжуулан малчид болон малчин өрхөд чиглэсэн үйл ажиллагааг дэмжихэд зарцуулсан байна.

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг 2009 онд хэрэгжүүлснээс хойш 2010 онд мал сүрэг нь Монгол Улсын үндэсний өвөрмөц, нөхөн сэргээгдэх баялаг, “Монголын соёл, уламжлалыг хадгалан авч яваа дэлхийн үнэт өв сан, тогтвортой хөгжлийн үндэс, эдийн засгийн тулгуурын нэг бөгөөд хүн амын амьжиргааны гол эх үүсвэр, хүнсний аюулгүй байдлын баталгаа, малчин өрхийн эдийн засгийн үндэс юм.”⁵⁷ гэсэн үндэслэлийн хүрээнд “Монгол мал” үндэсний хөтөлбөр, 2015 онд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангах чухал үүрэгтэй эдийн засаг, нийгмийн хөгжлийн суурь салбарын нэг учир хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжил нь үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэн өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэгдэх шаардлагатай⁵⁸ гэсэн үндэслэлээр “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ыг тус тус батлан гаргаж, мал аж ахуйн салбарын хөгжлийн ойрын болон дунд хугацааны зорилтуудыг тодорхойлсон.

Төр засгийн зүгээс малчдыг дэмжсэн, малчдад чиглэсэн бодлогыг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилтэй уялдуулан боловсруулж ирсэн ч үр дүнтэй хэрэгжилтийг хангах асуудал эргэлзээтэй байх нь бий. Үүнтэй холбоотой холбогдох яам, агентлагийн зүгээс малчдыг хэрхэн дэмжиж буй тодруулахад,

Зураг 7.36. Малчдыг дэмжиж ажиллах талаарх байгууллагууд үнэлгээ



Ер нь Сайн: Төрийн дээд шатны бодлого боловсруулах байгууллагууд болох УИХ болон яамдуудыг дунджаар 10 хүн тутмын нэг нь сайн гэж үнэлсэн (ХНХЯ 12.1 хувь, ХХААХҮЯ 10.0 хувь, УИХ 10.1 хувь, БОАЖЯ 6.6 хувь).

⁵⁷ ("Монгол мал үндэсний хөтөлбөр", 2010)

⁵⁸ (Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, 2015)


Дунд: УИХ 24.0 хувь нь, ХНХЯ 22.8 хувь нь, ХХААХҮЯ 19.1 хувь нь, БОАЖЯ 16.5 хувь нь дунд гэжээ.

Ер нь муу: Маш муу болон муу гэсэн үнэлгээ харьцангуй өндөр байна. Судалгаанд оролцогчдын хариултын үр дүнг харвал, УИХ-ын үйл ажиллагааг муу гэж 35.9 хувь, ХХААХҮЯ-ны үйл ажиллагааг муу гэж 31.0 хувь, БОАЖЯ-ны үйл ажиллагааг муу гэж 30.7 хувь, ХНХЯ-ны үйл ажиллагааг муу гэж 23.9 хувь нь хариулжээ.

Мэдэхгүй: УИХ болон дурдан буй яамнууд малчдыг дэмжиж ажилладаг эсэхийг мэдэхгүй гэж бараг хоёр хүн тутмын нэг нь хариулсан байна.


Малчдыг дэмжиж ажиллах тал дээр төрийн дунд шатны хэрэгжүүлэгч байгууллагууд хэрхэн ажиллаж байгааг тодруулахад засаг захиргааны анхан шатны буюу бага нэгжийн үйл ажиллагааг илүү эерэгээр үнэлж байгаа бол шатлал өсөх тусам үйл ажиллагааг нь мэддэггүй гэж хариулжээ.

Зураг 7.37. Малчдыг дэмжиж ажиллах талаарх байгууллагууд үнэлгээ



Малчдыг дэмжиж ажиллах тал дээр төрийн бус байгууллага болон олон улсын байгууллагууд хэрхэн ажиллаж байгаа талаар бараг гурван малчин тутмын хоёр нь мэдэхгүй байна. Тухайлбал, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны талаар мэдэхгүй гэж судлагдсан малчдын 69.3 хувь нь хариулсан бол олон улсын байгууллагын үйл ажиллагааны талаар мэдэхгүй гэсэн хариултын эзлэх хэмжээ мөн адил 66.6 хувь байна.

Зураг 7.38. Малчдыг дэмжиж ажиллах талаарх байгууллагууд үнэлгээ



Төр хийгээд олон нийтийн дэмжлэг, тусламжийн байгууллагуудын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхийн тулд юуны малчдын хэрэгцээг тодорхойлох нь зүйд нийцнэ. Судалгааны асуулгад энэ асуудлыг тусган үр дүнг гаргахад малчид, мал аж ахуйн салбарын эрсдэлийг

бууруулах (10.3 хувь), нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах (9.9 хувь), орлогын эх үүсвэрийг баталгаажуулах (8.5 хувь) асуудлыг хамгийн эхэнд тавьжээ.

Зураг 7.39. Төр засгийн зүгээс малчдыг дэмжих бодлогын чиглэлүүд



Дээрх график дахь утгуудыг чиглэл бүрээр нь 7 хэсэгт бүлэглэн жинлэж үзэхэд, малчин өрхийн амьжиргаа, эдийн засгийн баталгааг сайжруулах (27.9 хувь), нийгмийн хамгаалал амьдралын баталгааг хангах (19.8 хувь), малчдын мэргэжил боловсролд анхаарах (16.0 хувь) гэсэн асуудлууд хамгийн их жин эзэлж байна. (Хүснэгт 7.4)

Хүснэгт 7.5. Төр засгийн зүгээс малчдыг дэмжих бодлогын чиглэлүүд

Бодлого		Хувь
1	Амьжиргаа, эдийн засгийн баталгааг хангах	27.9
2	Нийгмийн хамгаалал амьдралын баталгааг хангах	19.8
3	Малчдын мэргэжил боловсролд анхаарах	16.0
4	Бэлчээр болон өвс тэжээл, худаг усны асуудлыг шийдэх	13.7
5	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	13.1
6	Төр засгийн бусад төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	4.9
7	Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих	4.7
Нийт		100.0

Хүснэгтэд үзүүлэлтүүдийг тус бүрт нь задлавал:

I. Малчдын эдийн засгийн баталгааг хангах:

1. Мал аж ахуйг эрсдэл багатай, баталгаатай болгох (33.6 хувь)
2. Орлогын эх үүсвэрийг баталгаатай болгох (27.9 хувь)
3. Ядуурлыг бууруулах бодлогыг эрчимжүүлэх (22.0 хувь)
4. Бүтээгдэхүүн борлуулалтын сүлжээг орон нутагт бий болгон хөгжүүлэх (15.5 хувь) гэсэн малчдын эдийн засагтай холбоотой дээрх 4-н асуудлууд руу чиглэсэн асуудлаар малчдыг түлхүү дэмжих хэрэгтэй гэж хариулжээ.

II. Малчдын нийгмийн амьдралыг сайжруулахад:

1. Малчдыг НД, ЭМД-д бүрэн хамруулах (49.0 хувь)
2. Малчдын эрүүл мэнд, ахуй амьдралын нөхцөлийг сайжруулах (34.0 хувь)
3. Тэтгэвэр, тэтгэмжийн бодлогыг боловсронгуй болгох (17.4 хувь) гэсэн асуудлуудын хүрээнд малчдын нийгмийн амьдралыг сайжруулах шаардлагатай байна гэж хариулсан байна.

III. Малчдын мэргэжил боловсролд анхаарах:

1. Малчин, малчин өрхийг хөгжүүлэх (38.2 хувь)
2. Малчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх (36.0 хувь)
3. Малчдад мэргэжил, боловсрол олгох (24.7 хувь)
4. Малчдын хүүхдийн сурах орчинг бүрдүүлэх, сургалтын төлбөрийг хөнгөлөх (1.1 хувь) хэрэгтэй гэж үзсэн байна.

IV. Бэлчээр болон өвс тэжээл, худаг усны асуудал:

1. Орон нутагт худаг усны асуудлыг шийдэх (45.8 хувь)
2. Бэлчээрийн менежментийн бодлогыг хэрэгжүүлэх (25.0 хувь)
3. Малын эрүүл мэндийг анхаарах, мал эмнэлгийг төрийнх болгох, малын эмчээр хангах (14.6 хувь)
4. Өвсний фонд болон тэжээл тарих талбай бий болгох, малын тэжээлийн үнийг бууруулах (14.6 хувь) гэж тэмдэглэжээ.

V. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих:

1. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (39.7 хувь)
2. Бэлчээрийн МАА-г эрхлэн хөтлөх аргыг боловсронгуй болгох (38.4 хувь)
3. Эрчимжсэн МАА эрхлэгчдийг дэмжих (12.6 хувь)
4. Мал маллагааны шинэ технологийг нэвтрүүлэх (9.4 хувь) шаардлагатай байна гэж хариулжээ.

VI. Төр засгийн бусад төсөл хөтөлбөрүүдийг эрчимжүүлэх

1. Залуу малчдыг дэмжих, малжуулах (43.0 хувь)
2. Төр, төрийн бус байгууллага, малчдын хамтын үйл ажиллагааг хөгжүүлэх, дэмжих (43.0 хувь)
3. Малжуулах төслийг эрчимжүүлэх (14.0 хувь) гэсэн хариултыг өгсөн байна.


VII. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих:

1. Малын гаралтай бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх (43.1 хувь)
2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх (34.9 хувь)
3. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих (22.0 хувь) хэмээн хариулжээ.

Мэдээллийн хүртээмж


Малчид төр засгаас хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөр, үйлчилгээний талаарх мэдээллийг ихэвчлэн телевизээс авдаг. Бусад эх сурвалжуудаас, сум/багийн ажилтан, албан хаагч, дарга нараас гэж 10.0 хувь, ам дамжсан ярианаас мэдээлэл авдаг гэж 9.0 хувь нь, радио/фм - ээс авдаг гэж 8.0 хувь нь хариулжээ.

Зураг 7.40. Төр засгаас хэрэгжүүлж буй хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, үйлчилгээний талаарх мэдээллийг ямар эх сурвалж



Мэдээллийн эх сурвалжаа хаанаас авдаг эсэхийг суурьшлаар нь ялган тодруулвал:

Зураг 7.41. Төр засгаас хэрэгжүүлж буй хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, үйлчилгээний талаарх мэдээллийг ямар эх сурвалж, байршлаар



Телевизээс мэдээлэл авдаг гэсэн хариулт аль ч хэсэгт өндөр хувьтай гарсан байна (дундаж 64.9 хувь). Аймгийн төвийн малчдын 11.6 хувь, нийслэлийн малчдын 8.6 хувь нь сум багийн ажилтан, албан хаагч, дарга нараас мэдээлэл авдаг гэж хариулжээ. Харин ам дамжсан яриаг эх сурвалж болгодог гэж нийслэлийн малчдын 12.9 хувь нь, сумын төвийн малчдын 4.7 хувь нь хариулсан байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Дүгнэлт

Хөдөлмөр эрхлэлтийн хувьд малчдын 74.1 хувь нь мал маллаж, мөн цалин хөлстэй ажил хийдэг бол 25.9 хувь нь мал ахуйн хөдөлмөрт оролцох оролцоо бага буюу хөдөлмөрийн идэвхи багатай гэж өөрсдийгөө тодорхойлжээ. Хөдөлмөрийн хэлбэрийн хувьд мал аж ахуйд суурилсан хөдөлмөр давамгайлж байгаа бөгөөд насны хувьд залуучууд мал маллагаа, арчилгаатай холбоотой хөдөлмөр илүүтэй эрхэлдэг бол нас ахих тусам шийдвэр гаргах (малын хорогдол эрсдлийг бууруулах ажил, мал зарж борлуулах г.м)-д илүүтэй оролцдог. Хөдөлмөрийн үргэлжлэх хугацааны хувьд малчдад тогтсон ажлын цаг байхгүй, харин улирлын онцлог, малын тоо хэмжээнээс хамааран хөдөлмөрт зарцуулах цаг өөр өөр байдаг. Цалин хөлстэй ажиллагчидтай харьцуулахад харьцангуй олон цагаар ажилладаг. Сүүлийн жилүүдэд мал маллахад байгаль, цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй хүчин зүйлээс үүдэлтэй бэрхшээл тохиолдох нь элбэгшсэн.

Хөдөлмөрийн үйл ажиллагааны хувьд байршлын онцлог чухал үүрэгтэй. Тухайлбал, нийслэлд мал маллаж буй малчид арьс шир боловсруулах (21.8 хувь), ноос ноолуур самнах (37.9 хувь), нутаг сэлгэх (52.9 хувь), оторлох (48.3 хувь), хашаа хороо барих, сэлгэх (62.1 хувь), цагаан идээ боловсруулах (58.6 хувь) ажлыг харьцангуй бага хувьтай хийж гүйцэтгэдэг бол цагаан идээ зарж борлуулах (82.8 хувь), мал саах (80.5 хувь) ажлыг их хийдэг.

Эдийн засгийн идэвхийн хувьд малчид, цалин хөлстэй ажиллагчид идэвхтэй хэсэгт хамаарах бол оюутан сурагч, тэтгэврийнхэн, бусдыг асарч буй хүмүүс идэвхгүй хэсэгт хамаарна.

Судалгааны үр дүнгээс, мөн статистикийн тоо баримтаас харахад мал аж ахуйн салбарт ажиллагсдын дунд статусын хувьд ялгаатай эзэн малчин, туслах малчин гэх бүлгүүд бий болжээ. Хөдөлмөрийн харилцаан дахь статус, эрх хэмжээний хувьд малчдын дийлэнх хэсэг нь өөрийн малыг маллаж байгаа ч бусдыг хөлсөөр ажиллуулах байдал нэлээдгүй байна. Туслах малчдыг аман тохиролцоонд үндэслэн, цалин хөлс өгөх, эсвэл мал, эд материал өгөх байдлаар ажиллуулдаг бөгөөд албан ёсны тусгайлсан зохицуулалт, зөвлөмж хэрэгтэй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Мал маллагааны арга хэлбэрээс хамааран салбарын хөгжлийн чиглэлийг ялгаатай байдлаар ийнхүү томъёолж байгаа ч уламжлалт мал аж ахуйн салбар зонхилж, суурин маллагааны арга багахан хувийг эзлэж байна. Энэ нь суурьшил, бүс нутгийн онцлогоос хамааран харьцаа нь өөр өөр байгаа юм.

Судлаачид социализмын үед хөдөө орон нутагт олон тооны худаг ус гаргаж байсан гэж тэмдэглэдэг ч өнөөдөр тэрхүү худаг усны олонх нь ашиглагдах боломжгүйгээр эвдэрч, сүйдсэн байна. Өдгөө хөдөөгийн малчдын дийлэнх хэсэг нь сайжруулсан худаг усны хүрэлцээ муу, бүсийн онцлогоос хамааран ил задгай ус хэрэглэж байгаа гэж дүгнэх үндэс бий.

Малчид эрүүл мэндээ сахин хамгаалахдаа суурьшлын онцлогоос хамааран эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломж харилцан адилгүй, ахуйн хэрэглээний онцлогоос үүдэлтэй өвчлөлд өртөх, осол гэмтэлд орж хөдөлмөрийн чадвараа алдах эрсдэл өндөр, мөн мал амьтны халдварт өвчин, түүнээс хэрхэн хамгаалах, халдвар хамгаалалтын ямар дэглэм барих тухай ойлголт мэдээлэл туйлын хангалтгүй байна.

Судлагдсан малчдын тухайд дээд боловсролтой залуучуудын хэмжээ өсөх хандлагатай болжээ. Насанд хүрэгчдийн хувьд цаашид бүсийн онцлогт тохирсон амьжиргаа дээшлүүлэхэд аргачлалд суралцах сонирхолтой байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Харин хүүхдүүдийн хувьд 6 наснаас сургуульд сургах асуудал нь гэр бүлийн харилцаа, өрхийн амьжиргаа, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл өндөр байгааг онцлон дурдсан байна. Үүнээс үүдэлтэй сургууль завсардалт, тэр дундаа эрэгтэй хүүхдүүдийг сургуулиас завсардуулах хандлагатай байна.

Малчид Монгол улсын нийт хүн амын 9.6 хувийг эзэлдэг бөгөөд ажиллах хүчний 24.5 хувийг эзэлдэг томоохон бүлэг билээ. Тэдний 57.4 хувь нь нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал зэрэг нь ирээдүйд гарч болохуйц эрдслийн нөлөөллийг бууруулахад чиглэсэн үр ашигтай бодлого гэдгийг ойлгодог ч бодит байдалд 3 хүн тутмын нэг нь нийгмийн даатгал, мөн тооны хүнээс 2 нь эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлдөг. Энэ нь дийлэнх малчдын хувьд ирээдүйд гарч болох нийгэм-эдийн засгийн эрдслээс сэргийлэх боломж алдагдаж буйг харуулна. Судалгааны үр дүнгээс харахад тухайн асуудал нь 1) малчдын орлого, зарлага, 2) хүн ам зүйн шинж, 3) хууль эрх зүйн зохицуулалт, 4) даатгалын шимтгэл төлөх нөхцөл, хэлбэрээс хамаардаг байна. Хэрэв эдгээр нөхцлийг тодорхой хэмжээгээр зохицуулж өгөх аваас нийгмийн хамгаалал, даатгалд хамрагдах малчдын хэмжээ нэмэгдэх боломж бүрдэх боломжтой юм.

Төр засаг болон олон улсын байгууллагын зүгээс малчдын амьжиргааг дээшлүүлэх, эдийн засаг, нийгмийн хэрэгцээ хангамжийг сайжруулах үүднээс олон янзын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн бөгөөд судлагдсан малчдын хоёрын нэг нь ямар нэгэн төсөл, хөтөлбөрт хамрагдсан байна. Суурьшлын хувьд хөдөө орон нутгийн малчид төсөл, хөтөлбөрт хамрагдах нь их байна.

Малчдын хамрагдсан төсөл, хөтөлбөрүүдээс, Монгол улсын Их хурал, Засгийн газраас хэрэгжүүлж буй ноос болон арьс ширний урамшуулалд хамрагдсан малчдын эзлэх хэмжээ хамгийн их, мөн хөтөлбөрийн үр дүнг хамгийн өндрөөр үнэлсэн байна. Ноос, арьс ширний урамшуулал тэдний дансаар шууд орж ирдэг нь малчдын хэрэгцээ, сонирхолд нийцдэг гэжээ.

Төсөл, хөтөлбөрийн ач холбогдлыг, ялангуяа “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”, “Дэлхий зөн ОУБ малжуулах” төсөл, “Залуу малчдыг малжуулах” төсөл, “Ногоон алт” төслийн ач холбогдлыг өндрөөр үнэлсэн байна.

Мал аж ахуйн салбар нь манай орны эдийн засгийн голлох салбаруудын нэг бөгөөд Үндсэн хуулиар хамгаалсан байдаг. Мөн уг салбарын хөгжлийн асуудалтай холбоотой “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” (2009 он), “Монгол мал” үндэсний хөтөлбөр (2010 он), “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” (2015 он) зэрэг бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлж байна.

“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хүрээнд 2009-2015 оны хооронд 471'256.6 тэрбум төгрөг зарцуулжээ. Мөн “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Монгол улсын нэгдсэн төсвийн 3 хувиас багагүй байхаар тооцож жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгаж, хэрэгжүүлэхээр баталсан байдаг.⁵⁹ Гэвч малчдын хувьд бодлого батлаж, хэрэгжүүлж буй УИХ, яамдын үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээлэл бага байдаг. Харин төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдээс ноос, арьс ширний урамшуулалд харьцангуй идэвхтэй хамрагддаг.

Төрийн дунд шатны хэрэгжүүлэгч байгууллагуудаас баг, хорооны ИНХ, засаг даргын удирдлагуудын үйл ажиллагааг харьцангуй эерэгээр үнэлсэн. Харин сум, дүүргийн ИТХ, засаг даргын үйл ажиллагааны талаар дунд, аймаг, нийслэлийн засаг дарга нарын үйл ажиллагааг доогуур үнэлжээ.

Төрийн удирдах болон хэрэгжүүлэгч байгууллагуудаас гадна төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудаас олон төрлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг боловч төслийн зорилго чиглэлээс хамаарч тэдгээрийн хамрах хүрээ харьцангуй хязгаарлагдмал, энэ талын мэдээлэл хүрдэггүй байх талтай нь ажиглагдсан.

Санал, зөвлөмж

Энэхүү судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд үндэслэн дараах санал, зөвлөмжийг бодлого боловсруулагч болон шийдвэр гаргагчдад хүргүүлж байна.

1. 2017 онд энэ насныхан нийт малчдын 34.5 хувийг эзэлж байгаа нь 1990 оны үзүүлэлтээс 21.1 пунктээр, 2016 оны үзүүлэлтээс 0.3 пунктээр буурчээ. Харин 35-39 насны малчид 1990 онд нийт малчдын 40.3 хувийг эзэлж байсан бол 2017 онд 55.7 хувь болж 15.4 пунктээр, 2016 оноос 0.4 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Залуу малчдын тоо жилээс жилд буурч байгаа нь малчдын залгамж халаа алдагдах, дунд болон ахмад малчдын тоо өсөх хандлагатай байгааг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, насжилтын үйл явц явагдаж байгааг зайлшгүй анхаарвал зохистой.
2. 2017 оны байдлаар нийт малчдын хүйсийн харьцаа 128 (56.1 хувь нь эрэгтэй, 43.9 хувь нь эмэгтэй) байна. Энэ үзүүлэлт 15-24 насны малчдын дунд 210 (67.7 хувь нь эрэгтэй, 32.3 хувь нь эмэгтэй) гэсэн харьцаатай байгаа нь хүн амын бодлогын түвшинд анхаарвал зохих асуудал болно. Залуучуудын дундах хүйсийн харьцаа их зөрүүтэй байгаа нь малчдын дундах гэрлэлт буурах, оройтох, төрөлт буурах, бэлгийн зүй бус харилцаа олшрох, гэрлэлт дагасан шилжилт хөдөлгөөн эрчимжих, цаашлаад малчдын залгамж чанарт сөрөг нөлөө үзүүлэх эрсдлийг дагуулж байна. Иймд хүн ам зүй, эдийн засаг үйлдвэрлэл, соёлын хүчин зүйлд үндэслэн малчдын хүйсийн харьцааг тэнцвэржүүлэхэд анхаарах шаардлагатай болжээ.
3. Малчдын амьдрах сууц, орон байр нь улирлын онцлогтой уялдаатай өөрчлөгдөх хандлагатай болсон нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Мөн малчдын олонх хэсэг нь цахилгааны эх үүсвэртэй болсон. Дулааны эх үүсвэрийн хувьд аргал, мод, зэргийг хөдөөгийн малчид түлхүү хэрэглэж байна. Өнөөдөр малчдын олонх нь сэргээгдэх эрчим хүч ашиглаж байгаа учир энэхүү хэрэглээнд тулгуурлан улирлын онцлогоос үүдэлтэй өөрчлөгдөж буй сууцны онцлогт нь нийцүүлэн дулааны эх үүсвэр, хэрэглээг шийдэх цаг болсныг харуулж байна. Хэрэв хямд төсөр, зардал багатай дулааны эх үүсвэрийг шийдсэн тохиолдолд мод, заг, бургас зэрэг байгалийн түүхий эдийн хэрэглээг бууруулахад эерэг нөлөө үзүүлэх талтай.
4. Малчдын хөдөлмөр эрхлэлт, ялангуяа эзэн болон туслах малчны тухай харилцаа нэгэнт бий болсон ч тэдгээрийн харилцааг зохицуулах албан ёсны эрх зүйн харилцаа хөгжөөгүй байна. Тухайлбал, бусдаар мал маллуулах гэж буй эзэн малчин туслах малчны хооронд гэрээнд суурилсан албан ёсны харилцаанаас илүүтэй аман тохиролцоонд үндэслэсэн харилцаа давамгайлж байгаа юм. Иймд туслах малчдын нийгмийн асуудлыг тусгайлан судлах, улмаар бодлогын түвшинд хөдөлмөрийн гэрээ, урамшуулал, эрх тэгш харилцааг хангах албан ёсны орчныг бүрдүүлэх тал дээр цаашид анхаарах шаардлагатай болсныг харуулж байна. Түүнчлэн туслах малчны эрэлтийг судалж, түүнд тохирсон зуучлалыг хөгжүүлвэл ажилгүйдлийн түвшинг бууруулахад томоохон түлхэц болох юм.
5. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал зэрэг нь ирээдүйд гарч болохуйц эрдслийн нөлөөллийг бууруулахад чиглэсэн үр ашигтай бодлого бөгөөд малчдын зүгээс даатгалын шимтгэлийн хэмжээ, түүнийг төлөх хугацаа, мөнгөн хэлбэрээр төлж буй байдал зэрэг гол бэрхшээл болдог. Иймд судлагдсан малчдын олонх нь нийгмийн даатгалын шимтгэлийг хагас жилээр, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бүтэн жилээр төлөх, шимтгэлийн төлөлтийн хэлбэрийг шууд бэлэн мөнгө гэж авахаас илүүтэй “малын хөлийн татварт шингээх, мал-малын түүхий эдээр орлуулах г.м” хэлбэрээр авч байхыг санал болгож байна. Мөн үүнээс гадна даатгалын үр ашгийг бүх талаар таниулан, сурталчилахад анхаарч ажиллах нь үр дүнтэй.
6. Малчдын хоол, хүнсний хэрэглээнээс харахад уламжлалт хүнсний бүтээгдэхүүнтэй зохицох, өөрсдийн гараар боловсруулан хэрэглэж болохуйц, амархан муудаж, үрэгдэхгүй,

хадгалалтын хугацаа даах зүйлсийг хүнсэндээ хэрэглэж байна. Өөрөөр хэлбэл, малчид өөрсдийн амьдралын онцлог хийгээд уламжлалд нийцүүлэн орчин үеийн гэгдэх хүнсний бүтээгдэхүүнээс өөрсдийн онцлог, хэрэглээнд тохирохыг нь илүүтэй сонгон хэрэглэж байна. Гэхдээ нийтлэг ажиглагдсан зүйлсийн хувьд хоол, ундны зөв хэрэглээ, түүнээс үүдэл бүхий өвчлөлийн асуудлыг хөндсөн эрүүл мэндийн зөвлөмж, сурталчилгааны ажлыг зохион байгуулах шаардлага өндөр байгаа юм.

7. Судлагдсан малчдын дунд олдмол шинжтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хэмжээ харьцангуй өндөр байгаа нь анхаарал хандуулах шаардлагатай асуудлын нэг болно. Хөгжлийн бэрхшээлтэй болоход нөлөөлж буй шалтгааныг цаашид тодруулан судлах зайлшгүй шаардлага байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.
8. Малчдын дунд сум суурингаас алслагад тусам эрүүл мэндийн үйлчилгээ авах, үзлэг оношлогоонд хамрагдах боломж бага учир орон нутгийн газар нутгийн хэмжээ, замын бартаа зэрэг хүчин зүйл, голлох өвчнийг тооцон явуулын оношлогоо, эмчилгээ үйлчилгээг улам бүр хөгжүүлэх тал дээр анхаарах. Ингэснээр хөдөөгийн малчдын дийлэнх хэсэг нь эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломж бүрдэнэ. Мөн малчдын эрүүл мэндийн асуудалтай холбоотой голлох өвчний шалтгааныг тодруулан судлах тал дээр анхаарвал зохино.
9. Боловсрол, сургалтын хүрээнд хүүхдүүдийг 6 настайгаас нь сургуульд сургах болсон нь гэр бүлийн харилцаа, эдийн засагт сөргөөр нөлөөлөх хандлагатай байгаа учир энэ насныхны онцлогт нийцсэн багийн бага сургуулийг байгуулах, сургалтын олон талт хэлбэрийг хөгжүүлэх хэрэгцээ байгаа юм. Ингэснээр эцэг эхчүүд тусдаа амьдрах, өрхийн санхүү тарамдах, улмаар салалт, гэр бүлийн харилцааны хөрөлт зэрэг сөрөг хандлагаас сэргийлэх боломжтой юм.
10. Харин малчдад хандсан сургалтын тухайд бүсийн онцлог, хэрэгцээг нарийвчлан тодорхойлох байдлаар сургалтын агуулга, чиглэлийг тодорхойлох нь оновчтой. Тухайлбал, энэ судалгааны үр дүнгээс харахад Улаанбаатарын малчид сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах, гар урлалын сургалтад суухыг илүүд үзэж байгаа бол зүүн бүсийн малчид мал маллагаа, малын эмчилгээний чиглэлийн сургалтад суух хүсэлтэйгээ илэрхийлсэн байна. Харин хангайн бүсийн малчид хүнсний технологи, хоол ундны үйлдвэрлэл, хүнсний ногооны тариалалтын чиглэлийн сургалтад суухыг илүүд үзсэн бол төвийн бүсийн малчид дархан мужаан, оёдол эсгүүр, үсчин гоо сайхны чиглэлийн сургалтад хамрагдах сонирхолтой байгаа тул сургалтын агуулгыг ийм байдлаар чиглүүлэх нь зохистой юм.
11. Механикжсан тээврийн хэрэгслийн тоо өсөн нэмэгдэж байгаа нь ажил төрлөө хурдан хугацаанд бүтээхэд ашигтай боловч үүнийг дагаад техникийн хөдөлгөөнөөс үүдэлтэй хөрс элэгдэх, амь насаа эрсдэлд оруулах зэрэг сөрөг үзэгдлүүд гарах болсоныг анхаарвал зохино. Энэ асуудлыг нарийвчлан судлах, улмаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллах нь малчдын амь нас, эд хөрөнгийг хамгаалахад ихээхэн ач холбогдолтой.
12. Цахилгаан үүсгүүртэй болж энэ хэрээр ахуйн хэрэглээний зүйлийн тоо нэмэгдэж, суурин амьдралтай өрхийн нэгэн адил амьдрах болсон зэрэг нь өнөөгийн хөдөөгийн малчдын нийтлэг дүр болсныг анхаарах хэрэгтэй. Энэхүү хэрэглээ болон соёлын үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэн, хөгжүүлвэл малчдын залгамж халааг бэлтгэхэд томоохон дэвшил болохыг онцлон тэмдэглэе.
13. Малчдын орлого болон зардлын хэмжээ нь суурьшлын ялгаатай байдал, малын тоо хэмжээ, мал маллагааны арга хэлбэрээс хамааралтай өөрчлөгдөж байна. Гэхдээ малчид хаана амьдарч байгаагаас үл хамааран зардал нь орлогоосоо давсан үзүүлэлттэй байна. Энэ нь малчдад чиглэсэн өрхийн орлого зарлагыг хөтлөх, төлөвлөх зэрэг санхүүгийн мэдлэг олгох сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах шаардлагатай байгааг илтгэнэ.

14. Малчдын тал илүү хувь нь зээлтэй бөгөөд зээлийн хэмжээ нь малын тоо, мал маллагааны арга хэлбэрээс хамаардаг. Зээлийн зориулалт нь ихэнхдээ ахуйн хэрэглээнд зарцуулагдаж байгаа нь зээлийн үр ашгийг бууруулах, зарим талаар үргүй зардал гаргаж байна гэх дүгнэлтийг хийх боломж байна. Гол нь малчдын орлого тогтмол бус байдгаас төлөвлөгдөөгүй зардалд барьц алдах, өрхийн амьжиргаанд дарамт үүсэх, жилд цөөн тоотой орж ирж буй орлого нь нэг удаад зээл төлөхөд зарцуулагддаг. Иймээс малчдын орлого, түүнээс үүдэлтэй хуримтлал бий болгох, зээлийн ачааллыг бууруулах, үр ашигтай зээлийн талаар ойлголт өгөхөд анхаарч ажиллах шаардлага байна.
15. Өрхийн орлого бүрдүүлэлтэд мал, малын гаралтай түүхий эд зарж борлуулсан орлого зонхилох хувийг эзлэж байгаа ч, суурьшлын аль бүсэд хамаарч байгаагаас өөр өөр байна. Малчдын орлого бүрдүүлэлтэд ноос ноолуур, мал, мах голлох нөлөө үзүүлдэг. Гэхдээ эдгээр нь түүхий эдийг тогтмол зарж борлуулах боломжгүй бөгөөд үүнд малчдын амьдралын хэмнэл, улирлын онцлог голлох нөлөө үзүүлдэг. Харин сүү, сааль нь дулааны улиралд элбэг хангалуун байдаг ч хөдөөгийн иргэд уг бүтээгдэхүүнийг зарах боломжгүй. Иймд сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи хөгжүүлэх, эсвэл түүхий эдийг нэгдсэн журмаар хүлээн авч боловсруулах тал дээр анхаарч ажиллавал малчдын орлого нэмэгдэх сайн талтай. Сүүлийн үед малчид бог болон бод малын сааль, сүүг сааж авах талын ажлыг ажиллагаа ихтэй, орлогод нэмэр багатай хэмээн орхигдуулах болсон зэрэг нь дээр дурдсан шийдлийг эрэлхийлж, алдагдаж буй нөөцийг үр ашгийг өсгөх боломж бүрдэнэ.
16. Малын түүхий эдийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх ажил улирлын онцлогоос ихээхэн хамаардаг. Тухайлбал, дулааны улиралд арьс шир зарж борлуулахад үнэ хүрдэггүй учир хаях нь элбэг байдаг. Иймд малын гаралтай түүхий эдийг ашиглах, үр ашгийг нэмэгдүүлэх гарц боломжийг судлах шаардлагатай юм.
17. Мал маллагааны арга хэлбэрээс хамааран салбарын хөгжлийн чиглэлийг уламжлалт болон фермерийн аж ахуйн гэж ялгаатай байдлаар томъёолж байгаа ч цаашид мал аж ахуйн салбарын хөгжлийн чиглэлийг бүс нутаг, суурьшлын онцлогт нийцүүлэн хөгжүүлэх нь үр дүнтэй арга зам болох талтай. Гэхдээ энэ явцад, фермерийн аж ахуй эрхлэгчдийн хувьд зах зээлд ойр, нээлттэй байх давуу тал өндөр. Харин бэлчээрийн аж ахуй эрхлэгчдийн хувьд энэ нөхцлийг хангах боломж бага учир бодлогын түвшинд уламжлалт аргаар мал маллаж буй малчдын орлогыг хэрхэн нэмэгдүүлэх боломж гарц байгааг тусгайлан судлавал зохилтой.
18. Малын гаралтай өвчин, тэдгээрийн халдварлах чадвар, өвчний илрэх шинж, өвчнөөс урьдчилан сэргийлэх талын сургалт мэдээллийн хүртээмж, чанарыг дээшлүүлэх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай гэдэг нь судалгааны үр дүнгээс харагдаж байлаа. Мөн сүүлийн жилүүдэд гарсан малын гаралтай өвчин, түүнийг эмчилэхэд зарцуулсан зардал зэргээс харвал бэлчээр болон хөрсний эрүүл ахуйг хамгаалах, малын угаалга, вакцинжуулалтыг сайжруулах зэргээр малын эрүүл ахуйг хангах тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй юм.